

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2026 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-4

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 5-73

1. “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ 6-14

2. Хаврын тариалалтын бэлтгэл ажил, мал төллөлтийн явцын мэдээ болон цаг үеийн асуудлаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох 15-59

3. Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан 59-73

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
4 дүгээр сарын 14-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 30 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 56.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 17 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Золжаргал;
Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, С.Амарсайхан, С.Ганбаатар, Х.Ганхуяг, Ц.Туваан.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Байнгын хорооны дарга Б.Бейсен хэлэлцэх асуудлын дөрөвдүгээр асуудал болох “бусад” гэсэн асуудлыг хойшлуулав./10:18/

**Нэг.“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.03.17-ны өдөр өргөн
мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга А.Энхманлай, мөн газрын Геодези, зураг зүйн хэлтсийн дарга Д.Мөнхцэцэг, мөн хэлтсийн мэргэжилтэн Ц.Орлого, мөн газрын Хуулийн хэлтсийн мэргэжилтэн Д.Мөнхцэцэг, Сүхбаатар аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга Б.Оюунхорол, Шинжлэх ухааны академийн Нийгмийн шинжлэх ухаан хариуцсан Дэд ерөнхийлөгч Ц.Цэрэндорж, мөн академийн Газар зүй, гео-экологийн хүрээлэнгийн захирал А.Дашцэрэн, Хэл зохиолын хүрээлэнгийн Харьцуулсан хэл шинжлэлийн салбарын Эрдэм шинжилгээний дэд ажилтан М.Очирцэнд, Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний дэд ажилтан П.Төрболд, Монгол Улсын Зөвлөх инженер Д.Оюунчимэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, мөн газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны зөвлөх П.Хулан, референт Б.Бадралт, Ц.Рэнцэнтогтох, Б.Энхгэрэл нар байлцав.

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Тогтоолын төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Б.Бейсен нарын тавьсан асуултад Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга А.Энхманлай, Шинжлэх ухааны академийн Нийгмийн шинжлэх ухаан хариуцсан Дэд ерөнхийлөгч Ц.Цэрэндорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Б.Бейсен нар үг хэлэв.

Б.Бейсен: “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 7
Бүгд: 22
68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Хаврын тариалалтын бэлтгэл ажил, мал төллөлтийн явцын мэдээ болон цаг үеийн асуудлаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбат, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, мөн газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны зөвлөх П.Хулан, референт Б.Бадралт, Ц.Рэнцэнтогтох, Хяналт шалгалтын газрын референт Д.Мөнхтуяа нар байлцав.

Мэдээллийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбат танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Н.Наранбаатар, Р.Сэддорж, Ц.Мөнхбат, У.Отгонбаяр, П.Батчимэг, М.Мандхай, Г.Ганбаатар, Б.Мөнхсоёл, С.Замира, М.Ганхүлэг, Ж.Бат-Эрдэнэ, Б.Бейсен нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбат хариулж, тайлбар хийв.

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Р.Сэддорж, М.Мандхай, М.Ганхүлэг, Б.Бейсен нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд хаврын тариалалтын бэлтгэл ажил, мал төллөлтийн явцын мэдээ болон цаг үеийн асуудлаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбатын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 13 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, мөн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, мөн яамны Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Ц.Уранчимэг, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Анар, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Баяраа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын дарга Ч.Ганболд, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга А.Энхманлай нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Дэд дарга Г.Эрдэнэбат, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, мөн газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны зөвлөх П.Хулан, референт Б.Бадралт, Ц.Рэнцэнтогтох, Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын зөвлөх Б.Алтантуяа, Хяналт шалгалтын газрын референт Д.Мөнхтуяа нар байлцав.

Тайланг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Г.Ганбаатар, М.Ганхүлэг, Б.Бейсен нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, мөн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Г.Ганбаатар, М.Ганхүлэг, Б.Бейсен нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг хэлэлцлээ.

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Уг асуудлыг 14 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 53 минут үргэлжилж, 30 гишүүнээс 24 гишүүн хүрэлцэн ирж, 80.0 хувийн ирцтэйгээр 14 цаг 10 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХ УЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
10 цаг 17 минут.

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Б.Бейсен: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц 56.7 хувьтай бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 26 оны 4 сарын 14-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Гишүүдийн ирцийг танилцуулъя.

Наранцэцэгийн Алтаншагай гишүүн ирсэн байна. Буланы Бейсен гишүүн ирсэн байна. Мэндбаярын Мандхай гишүүн ирсэн байна. Тогтмолын Мөнхсайхан гишүүн ирсэн байна. Салдангийн Одонтуяа гишүүн ирсэн байна. Агваанлуvsсангийн Ундраа гишүүн ирсэн байна. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн ирсэн байна. Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн ирсэн байна. Баатаржавын Мөнхсоёл гишүүн ирсэн байна. Ухнаагийн Отгонбаяр гишүүн ирсэн байна. Болдын Уянга гишүүн ирсэн байна. Пүрэвийн Батчимэг гишүүн ирсэн байна. Сүрэнжавын Лүндэг гишүүн ирсэн байна. Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн ирсэн байна. Нанзадын Наранбаатар гишүүн ирсэн байна. Ренчинбямбын Сэддорж гишүүн ирсэн байна.

Хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн Байнгын хорооны хурлаар 4 асуудал хэлэлцэхээр тогтсон байгаа.

Нэгдүгээрт, “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Засгийн газрын 2026 оны 3 сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх.

Хоёрдугаарт, Хаврын тариалалтын бэлтгэл ажил, мал төлөлтийн явцын мэдээ болон цаг үеийн асуудлаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох.

Гурав дахь нь Хууль тогтоолоор, үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан.

Дөрөв дэх нь бусад гээд. Бусад гээд хэлэлцэх асуудлын материал ирээгүй учраас энийг жич хуралдаж зарлахаар болсон тул энэ дөрөв дэх асуудлыг хойшлуулъя.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу?

Байхгүй байна. Хэлэлцэх асуудалд оръё.

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье.

Хууль санаачлагчийн танилцуулгыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Баттөмөр Энхбаяр танилцуулна.

“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн танилцуулгууд дурдсанаар Баян-Өлгий аймгийн 12 сумын нутаг дэвсгэрт хамаарах 319 нэрийг Монгол оноосон нэрээр шинэчлэн нэрлэх, 47 газар зүйн нэрийг шинээр нэмж, Сүхбаатар аймгийн 13 сумын газар зүйн нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжиж байгаа хэдий ч Улсын Их Хурлаар батлуулаагүй 940, байрлал зөрүүтэй 17, үг, үсгийн зөрүүтэй буюу хэл бичгийн дүрмийн алдаатай 45 газар зүйн нэр байгааг тогтоож нэмж батлах тухай төсөлд тусгасан байгаа. Энхбаяр сайд танилцуулга хийнэ.

Б.Эхбаяр: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нутаг дэвсгэрт хамаарах уул, нуруу, гол, нуур зэрэг байгалийн физик газар зүйн объектын нэр, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн нэр, хүний гараар бий болсон объектод оноосон нэрийг Засгийн газар нэгтгэж, Улсын Их Хурлаар батлуулах үүргийг Геодези, зураг зүйн тухай хуулиар хүлээсэн байдаг.

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу газар зүйн нэр нь соёлын биет бус өвд хамаардаг бөгөөд Монгол Улсын 2025 оны нэгдэн орсон ЮНЕСКО-ийн 2003 оны Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенц ёсоор газар зүйн нэрийг хамгаалах үүрэгтэй. Мөн Монгол хэлний тухай хуулийн дагуу газар зүйн нэр Монгол хэл дээр батлагдаж ашиглагдах шаардлагатай юм.

Албан ёсны газар зүйн нэрийг бүх төрлийн газрын зураг дээр тэмдэглэн олон нийтэд танилцуулахаас гадна улсын хил, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хил заагийг тогтоох, иргэн үл хөдлөх хөрөнгийн хаягжилт зэрэг олон чиглэлээр ашиглаж байна. Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоолоор Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт хамаарах 214805 нэрийг баталсан бөгөөд үүнээс Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрт хамаарах 8767, Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт хамаарах 6941 газар зүйн нэрийг баталсан байна.

Гэвч дээрх газар зүйн нэрийн зарим нь Монгол хэлнээс өөр хэл дээр буюу Орос, Казак, Тува гэх мэт хэл дээр нэрлэгдэж батлагдсан, багийн нэрийг Казак хэл дээр нэрлэж батлуулсан зөрчил илэрсэн тул хээрийн болон суурин судалгаагаар Баян-Өлгий аймгийн 12 сумын нутаг дэвсгэрт хамаарах Монгол хэлээс өөр хэл дээр баталсан 319 газар зүйн нэрийг тогтоож, мөн 47 газар зүйн уламжлалт нэрийг шинээр тодруулсан байгааг Улсын Их Хурлаар батлуулах шаардлагатай байна.

Мөн Сүхбаатар аймгийн 13 сумын газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2021-2022 онд гүйцэтгэж, батлагдаагүй орхигдсон уламжлалт 2020 газар зүйн нэр болон үг, үсгийн зөрүүтэй хэл бичгийн дүрмийн алдаатай батлагдсан 45 газар зүйн нэр байгааг тогтоосныг шинэчлэн батлуулах шаардлагатай байна.

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Баян-Өлгий, Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт хамаарах тогтоолын төсөлд тусгасан газар зүйн нэрсийг түүхийн эх сурвалж, архивын баримт материал болон орон нутгийн иргэдийн яриа, мэдээлэлд тулгуурлан хээрийн болон суурин судалгааны дагуу тогтоосон бөгөөд газар зүйн албан ёсны нэрийг бүх төрлийн газрын зурагт тэмдэглэж, олон нийтэд зөв нэрээр сурталчлан таниулж хэрэглээнд нэвтрүүлснээр үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолын баталгаа болсон газар нутаг, байгаль орчноо хадгалах, хамгаалахаас гадна хойч үедээ газар нутгаа хайрлан хамгаалах үзэл бодол төлөвшлийг өвлүүлэн үлдээхэд чухал ач холбогдолтой юм.

Иймд Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын газар зүйн нэрийн жагсаалтад дээр дурдсан Баян-Өлгий, Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт хамаарах 364 нэрийг өөрчилж, 2067 нэрийг шинээр нэмж батлуулахаар Улсын Их Хурлын тогтоолын төсөлд тусган танилцуулж байна.

Хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Б.Бейсен: Баттөмөр сайдад баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Энхбаяр Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Д.Нямдэлгэр Засгийн газрын ахлах референт, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас Энхманлай газрын дарга, Д.Мөнхцэцэг, Геодези, зураг зүйн хэлтсийн дарга, Д.Мөнхцэцэг Хуулийн хэлтсийн мэргэжилтэн, Ц.Орлого Геодези зураг, зүйн хэлтсийн мэргэжилтэн Сүхбаатар аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Б.Оюунхорол Газрын удирдлагын хэлтсийн дарга, Монгол Улсын Шинжлэх ухааны академи Ц.Цэрэндорж Нийгмийн шинжлэх ухааны хариуцсан Дэд ерөнхийлөгч, А.Дашцэрэн Газар зүй, гео-экологийн хүрээлэнгийн захирал, М.Очирцэнд Хэл зохиолын хүрээлэнгийн Харьцуулсан хэл шинжлэлийн салбарын эрдэм шинжилгээний дэд ажилтан, П.Төрболд Түүх, угсаатан зүйн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний дэд ажилтан, Д.Оюунчимэг Монгол Улсын Зөвлөх инженер.

Танилцуулгатай холбоотой асуулт асуух гишүүд нэрсээ өгье.

Бат-Эрдэнэ гишүүнээр тасалъя. Бат-Эрдэнэ гишүүнээс асуулт асууя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Ингээд юм цэгцдээ орж байгаа явдалд баяртай байна. Энэ Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилт дээр хяналт тавьдаг Монополын эсрэг газар хуучин Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар энэ яг ингэж явах ёстой юм уу? Тухайн үедээ ч бид нар бас хөнддөг байсан. Сонгууль болдог Казак бичгээр, Казак хэлээр бүх сурталчилгаануудаа бичээд тавьчихсан. Ардын нам, Ардчилсан нам гээд 2 намын сонгуулийн ажлын хэсэг, штабынханд бас албан бичиг тухайн үед хүргүүлж, хариуцлагын арга хэмжээг хуулийн дагуу авч байсан. Тэгээд энэ Монгол хэлний хяналтад, хэрэгжилтэд яг хэн хяналт тавих ёстой юм бэ? Энэ Монополын эсрэг газар үргэлжлүүлээд хяналтаа хийгээд явах ёстой юм уу гэдэг нэгдүгээр асуулт байна.

Хоёрдугаар асуулт газар, усны нэр өөрчилсөнтэй холбоотой яах вэ бас л намайг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын даргаар ажиллаж байх цаг хугацаанд хөндөгдөж байсан асуудал. Тэгээд л гомдлыг нь гаргаж байсан.

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Сүүлдээ баахан Казахуудад, Баян-Өлгийчүүдэд бас баахан загнуулж, баахан л бүүлийдүүлсэн. Энэ яагаад ингээд өөрчлөөд байдаг юм бэ? Энийг ингээд дураараа өөрчлөөд байх нөхцөл суурийг нь тэнд үнэхээр бий болгочихсон учраас ингээд яваад байдаг юм уу? Би сая нөгөө Сонгуулийн тухай хуулийг хүртэл, сонгуультай холбогдож хүртэл хэллээ шүү дээ газар, орон нутгийн нэрс, нэршил байна. Энэтэй холбоотой асуудал. Тэгээд энэ олон газар, орны нутгийн нэрийг өөрчлөөд байх ер нь нөхцөл байдал ийм суурь байдлаараа цаашдаа яваад байх ёстой юм уу гэдгийг би асуух гэж байгаа юм.

Гуравдугаарт, Геодези, зураг зүйн газрынхан маань бас байх шиг байна. Саяхан бас Нямбаатар дарга руу баахан дайрцгаагаад л байсан энэ Нисэх, Яармагийн чиглэлийн Улсын Их Хурлын гаргасан тогтоолыг уулын нэрээр нэрлэснээс улбаатайгаар аваачиж 2011 онд танай байгууллагын удирдлагаар ажиллаж байсан хүн Байгаль орчны сайдтай нийлж байгаад координацыг нь өөрчлөөд Байгаль орчны тухайн үеийн ногоон хөгжлийн яам өөртөө аваад ингээд газар зарах процесс явагдсан. Энэ эцэслэх нь бол 2023 онд бид нар Барилга, хот байгуулалтын яам тухайн үед Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос тогтоол гараад хэрэгжүүл гэдэг шийдвэр гараад тэрний дагуу бас хэрэгжүүлж явсан байдаг. Тэгээд энэ газар усны нэртэй холбоотой ер нь энэ хил, нутгийн заагтай холбоотой ийм олон асуудлууд үүсээд байдаг. Тэгээд энэ дээр манай яг мэргэжлийн агентлаг өөрөө ямар байр суурьтай байдаг юм гэдгийг асуух гэж байгаа юм. Баярлалаа.

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? 5 номер.

А.Энхманлай: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын Үндсэн хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг дээр Монгол хэл бол төрийн албан ёсны хэл гэж заасан байдаг. Энэ учраас Монгол хэлний тухай хууль дээр Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа албан хэргийг Монгол хэлээр хөтлөн явуулна. Газар нутаг, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, гудамж, зам талбайн хил хязгаар, хаягийг Монгол хэлээр хөтлөн явуулна гэсэн ийм хуультай байгаа.

Тэгээд энэ хуулийн хэрэгжилт бол бид бүхэн энэ Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоолоор Монгол Улсын хэмжээний газар зүйн нэрийг баталсан байгаа. Энэ тогтоолыг 4 жил тутам шинэчилж байх ийм үүргийг Засгийн газарт тухайн үед өгсөн. Гэхдээ энэ тогтоол маань өөрөө 2017 онд л нэг удаа Хэнтий хан уулыг Бурхан Халдун уул болгож шинэчилснээс өөрөө өөрчлөгдөөгүй байгаа. Ингээд 2017 оноос хойш Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг гарсан. Энэ дээр энэ газар усны нэрийг өөр хэл дээр нэрлэж байгаа энэ асуудлыг цэгцлэх юм. Орон нутгийн Засаг дарга нарын бүрэн эрхэд энэ газар усны нэрийг Монгол хэл дээр өөрөөр хэлбэл Их Хурлын тогтоолыг мөрдүүлэх ийм үүрэг заасан байдаг.

Тийм учраас энэ ажлыг цаашид хяналт тавьж ажилла, мөн нийт ард түмэнд Монгол хэлээр газар усаа нэрлэхийг уриалсан ийм зарлиг гарч байсан. Үүнтэй холбогдуулаад Эрүүгийн тухай хууль дээр бас өөрчлөлт орсон. Энэ хуулиар газар усны нэрийг албан ёсны баримт бичиг дээр өөр хэлээр нэрлэх, орчуулж нэрлэхийг хориглож хориглосон. Энэтэй холбоотой хариуцлагын ийм механизмыг бүрдүүлж өгсөн. Мөн Зөрчлийн тухай хууль дээр энэ төрлийн бас асуудлыг зохицуулсан. Ингээд 2017 оноос хойш зарим нэр бүхий иргэдээс газар, усны нэрийг Монгол хэлнээс өөр нэрээр хэрэглэж байгаа, зарим аймаг дээр бас багийн нэрийг аймгийн

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Иргэдийн хурлаар өөр хэлээр нэрлэж баталсан ийм зөрчилтэй асуудал үүссэн. Үүнтэй холбогдуулаад манай байгууллагаас холбогдох 9 байгууллагын төлөөллийг оролцуулж, 6 аймаг дээр энэ төрлийн шалгалтыг зохион байгуулсан байгаа.

Ингээд энэ 6 аймагт Сүхбаатар, Дорноговь, Булган, Дундговь, Дархан-Уул, Говьсүмбэр, Орхон гэсэн аймгууд хамрагдсан. Энэнтэй холбоотой 1500 орчим нэр Монгол хэлнээс өөр нэр дээр энэ 2003 онд батлагдсан байна, байж болзошгүй юм гэдэг ийм урьдчилсан суурин судалгаа гарсан. Энэ хүрээндээ бид нар бас ажлын хэсэг байгуулаад Баян-Өлгий аймагт ажилласан байгаа.

Баян-Өлгий аймагт ажиллаад бид бүхэн өнөөдрийн энэ тогтоол руу оруулж ирж байгаа 319 нэрийг Орос, Тува, Казах хэл дээр нэрлэчихсэн байна, нэрлэж баталсан байна тухайн үед. Тийм учраас дахиж өөрчилж шинэчилж батлуулах ийм шаардлагатай гэсэн утгаар өнөөдрийн энэ тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудал орж ирсэн. Цаашид бас түрүүний нэр дурдсан аймгууд дээр мөн адилхан Орос, Хятад гэсэн Тува гэсэн нэрс дээр бас нэрлэгдсэн ийм газрууд байгаа. Энийг бид нар үе шаттайгаар ингээд оруулж ирж энэ Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах юм.

Улсын хэмжээнд энэ газар зүйн нэрийг тодруулах ажил 8 аймаг дээр бүрэн хийж дууссан байна. Одоо бол 49.5 хувийн хэрэгжилттэй явж байгаа.

Хоёрдугаарт гэхээр бид бүхэн бас энэ нийслэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт хамаарах Богд уулын дархан цаазат газрын хилийг 1995 онд тогтоосон. Энэ тогтоосон хилийг сая бас гишүүн хэллээ 2018 онд энэ буруу зураглаж тогтоосноос болж Байгаль орчны яаман дээр ийм зөрчилтэй шийдвэр гаргах ийм нөхцөл бүрдсэн. Үүнийг 2019 оноос хойш Ажлын хэсэг байгуулагдаж ажиллаад ингээд 2023 онд зассан. Энэ засаж шийдсэнтэй холбоотой бас нэлээд.../минут дуусав./

Б.Бейсен: Гүйцээж яриульъя 5 номер.

А.Энхманлай: Тухайн үед Байгаль орчны сайдын тушаалаар, мөн Нийслэлийн Засаг даргын захирамжаар, шийдвэрээр газрын эрх олгогдсон газрууд хүчингүй болсонтой холбоотой бас маргаан, зөрчил гарсан. Энэ шинэ буюу бид бүхэн шинэчилж тогтоосон буюу Улсын Их Хурлын тогтоолоор батлагдсан газар зүйн нэрийн, хилийн цэсийн дагуу одоо мэдээллийн сандаа оруулаад энийг мөрдөж ажиллаж байгаа. Ер нь цаашдаа бид нар энэ бүх тусгай хамгаалалттай газар, мөн хилийн цэсүүдийн маргаантай асуудлыг газрын нэгдмэл сангийн цахим системд үнэн, зөв оруулж түүнийг мөрдүүлэх тал дээр бодлогын түвшинд бас арга хэмжээ авч ажиллаж байна.

Б.Бейсен: Монгол хэл, Монополын эсрэг газарт бас асуулт асуусан байна. Хэн хариулах вэ? Ажлын хэсэгт нь байхгүй байгаа юм байна даа. Бат-Эрдэнэ гишүүн тодруульъя.

Б.Бат-Эрдэнэ: Тэр Монополын эсрэг газар дээр юугаа ч хийж Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилт явдаг юм. Тэрийг та хэд маань бас шалгахгүй бол цаашдаа бас өөрчлөх юм руу нь оруулахгүй болохгүй байх гэж бодож байгаа. Энхманлай дарга энэ танайх дээр яг нэгдсэн санд бүгд бүртгэгдэж байгаа юу гэдгийг би асуух гэж байгаа юм. Яагаад гэхлээр тусгай хамгаалалттай газар нутаг

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

өөрийн гэсэн системтэй байгаа. Тэнд тухайн аймаг, сумын хилийн цэс, мөн уулын нэршил энэ тэр бас зөрдөг тохиолдлууд гардаг. Тэгээд яг би бас өөрөө сайдаар ажиллаж байсан хүний хувьд яг Монгол Улсын энэ газар нутгийн мэдээллүүд танай геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд нэг байдлаар бүртгэгдэж байгаа юу гэдэг дээр эргэлзэж байгаа. Мэдээж газар орон нутаг болгон өөр өөрийнхөө нэршлээр иргэд нь өөрсдийнхөөрөө нэрлээд явчихсан байдаг.

Б.Бейсен: 5 номер хариулья.

А.Энхманлай: Засгийн газрын 2020 оны 150 дугаар тогтоолоор Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем гэж системийг хэрэглээнд нэвтрүүлсэн байгаа. Энэ систем дээр энэ урьд өмнө нь Улсын Их Хурлын тогтоолоор шийдвэрлэгдсэн бүх засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг бид нар координатаар нь зураглаж бүртгэж оруулсан байгаа. Мөн энэ систем дээр дэд систем болох хилийн цэсийн тусгай систем байгаа нээлттэй. Энэ системээс манай аймаг, сумын хилийн асуудалтай, маргаантай, эргэлзээтэй ийм зүйлүүд байгаа бол эндээс бас манай иргэд мэдээлэл авч болно.

Уул, усны нэрийг бас энэ газар зүйн нэрийн тодруулалт мэдээллийн сан бүрдүүлэх гэдэг ажлын хүрээнд одоо бид бүхэн энэ мэдээллийн сандаа бүрэн бүртгэсэн. Цаашдаа ийм давхцал, зөрчил гаргуулахгүй байхад энэ цахим системээр зохион байгуулж ажиллаж байгаа.../минут дуусав./

Б.Бейсен: Тэр Монгол хэлтэй холбоотой асуудлаар Нийгмийн шинжлэх ухаан хариуцсан Дэд ерөнхийлөгч Цэрэндорж гэдэг хүн байна. Хариулах уу? 7 номер.

Ц.Цэрэндорж: Яг бидэнтэй шууд хамаатай асуудал биш шиг байна. Энэ бол Монополын эсрэг газарт хандаж яасан байх. Ер нь Монгол хэлний хуулийг бас хэрэгжүүлэх гол ажлыг манай Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэн бас хариуцаж явдаг. Тэгэхээр энэ яагаад энэ нэрс гадаад хэлээр нэрлэгдсэн бэ гэдэг дээр би бас хариулт, өөрийн бодлыг хэлье. Яагаад гэхээр энэ нутгийн ард иргэд бас өөрийнхөөрөө нэрлэдэг. Дээр нь бас социализмын үед бас газрын зурагт тэмдэглэхдээ тухайн үеийнх нь хүмүүсийн хэлж байсан энэ нэрээр нь бас тэмдэглэгдсэн гэх мэт ийм олон шалтгаантай байгаа юм тэгээд. Ер нь энэ гадаад нэрээр нэрлэгдсэн гэдэг энэ нэрсийн зарим нь яг уугуул Монгол үгс байгаа. Бид.../минут дуусав./

Б.Бейсен: 7 номер гүйцээж хариулья.

Ц.Цэрэндорж: Тийм. Бид жишээлбэл сая энэ нийт 500 гаран нэр дээр судалгаа хийгээд үзэхэд 200 орчим нь уугуул Монгол үгс байгаа юм. Тэгэхээр бид нар өөрсдөө бас энэ хуучин Монгол үгсээ бас мэдэхээ байчихсан, мартчихсан иймэрхүү асуудлууд бас гарч ирж байгаа. Тэгээд яг гадаад хэлээр нэрлэгдэж байгаа энэ нэрсийг эхний ээлжид энэ Баян-Өлгий аймгийн хэмжээнд энэ хуучин сурвалж бичиг, хуучны газрын зураг, бусад материалууд, тал талаас нь ингэж материалууд дээр ажиллаж тодруулж өгсөн гэдгийг бас энд тэмдэглэе ээ. Баярлалаа.

Б.Бейсен: Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулья.

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Б.Бат-Эрдэнэ: Та хэдийн маань оруулж ирсэн материал дотор үнэн, зөв нэрийг таниулан сурталчлах, тэмдэгжүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай гээд биччихсэн л байгаад байна л даа. Одоо Улаанбаатар хотод байгаа энэ нэршлүүдээ яах вэ? Тэр Туркийн нэртэй гудамж байна. Туркээр биччихсэн. Одоо хүртэл байж л байгаа Зоос гоёлын тэнд. Зарим нь бол бас Хятадад яваад байгаа, Солонгост яваад байгаа нь ч мэдэгдэхгүй юм. Нисэх онгоцны буудлаас наашаа явж байх тэр “Эхлэл” гэдэг компани Хятадаар биччихсэн зар сурталчилгаа байршуулсан бөөн асуудал болсон нийгмийн сүлжээн дээр.

Ер нь энэ хуулийг бид нар яг хэзээ хэрэгжүүлэх юм бэ, хэн хэрэгжүүлэх юм бэ гэдэг дээр Газар, геодези зураг зүйн газар маань хариулах юм уу? Яагаад та хэдээс асуугаад байна гэхээр мэдээллийн нэгдсэн сантай холбоотой асуудал танайх дээр л байгаад байх шиг байна л даа. Тэгээд энэ гудамжны нэршлүүд тавьсан сурталчилгаа бүгд л.../минут дуусав./

Б.Бейсен: 5 номер хариулъя.

А.Энхманлай: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Улаанбаатар хотын хэмжээнд газар зүйн нэрийг хаягжилтын асуудал дээр түлхүү хэрэглэж байгаа. Ер нь аливаа хот суурин газар, гудамж, зам талбайд ер нь гадаад нэрийг бас өгч болно. Геодези, зураг зүйн тухай хуульд нь заачихсан байгаа. Тэгэхээр гадаад нэр өгөхөд Иргэдийн хурлаас шийдвэр гараад, шийдвэр гарахаасаа өмнө Хэлний бодлогын үндэсний зөвлөл гээд Ерөнхийлөгчийн дэргэдэх энэ зөвлөлөөс зөвшөөрөл авч зөвшилцсөнийхөө үндсэн дээрээс Иргэдийн хурлаас тухайн гудамж, замд гадаад нэр олгож ингэж явж байгаа. Тэгэхээр энэ хаягжилтынхаа асуудал дээр гудамжны нэр олгох, мөн хаяг олгох энэ асуудлууд Иргэдийн хурлын түвшинд шийдэгдэж байна.

Бид бүхний хувьд 2013 онд батлагдсан Хаягжилтын тухай хуулийг шинэчлэхээр шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан байгаа. Мөн хаягжилтыг.../минут дуусав./

Б.Бейсен: 5 номер гүйцээж хариулъя.

А.Энхманлай: Системийг ашиглалтад боловсруулж хэрэглээнд нэвтрүүлсэн. Одоо 21 аймаг дээр энэ системийг ашиглаад шинэ хаягаа олгоод явж байна. Нийслэл Улаанбаатар хот дээр Иргэдийн хурлууд бүх гудамж, замдаа нэр олох ийм хурлуудыг зохион байгуулж байгаа юм. Энэ 4, 5 сард багтааж энэ бүх зам, гудамжинд нэр албан ёсоор олгогдчих юм бол энэ систем рүү ороод шинэ системээр Улаанбаатар хотын хэмжээнд гудамжны нэрс автоматаар олгогдоно. Тэгээд үүнийхээ хүрээнд дараа нь бид бүхэн бас энэ тэмдэгжүүлэх ажлуудыг зохион байгуулна.

Энэ удахгүй бас саяын ярьсан Хаягжилтын тухай шинэчилсэн найруулгын хуулиа бид бүхэн оруулж ирж байгаа. Энэ хууль маань өөрөө бас олон улсын хаягжилтын энэ арга, аргачлалын дагуу бас боловсруулах, хаяг олох ийм зохион байгуулалтыг хангасан ийм хууль болж байгаа. Тэгэхээр гадаад нэрийг бас Иргэдийн хурал өөрөө зөвшөөрөл олгуулж байгаа. Энэ хуулиудын хэрэгжилт дээр Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар, аймаг, нийслэл, сумын Засаг дарга нар.../минут дуусав./

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Б.Бейсен: Одоо болсон байх 2 удаа тодруулсан юм чинь. Энэ “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжиж байгаа. Энэнтэй холбоотой асуулт асууя гэж бодож байна.

Зарим нэрийг үнэхээр Монголчлоод түүх соёлоо хамгаалахгүй бол болохгүй асуудал байгаа. Тэгэхдээ энэ Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын Тувачууд бүүр дээр үеэс Нууц товчооны үед бичигдсэн Цэнгэлчүүд амьдардаг гээд. Тэнд газрын нэршил өөрчилсөн асуудал байна уу? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, тийм газрыг бас өөрөөр өөрчлөөд гэхэд тэр ард иргэдээс санал манал авсан уу? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт энэ Баян-Өлгий аймаг, Сүхбаатар аймагтай холбоотой асуудал байна. Энэ зориуд аймгийн Засаг даргын Тамгын газраас ч юм уу тогтоол гаргаж өөрчилсөн юм байна уу? Аль эсвэл нүүдэлчдийн соёлтой холбоотой хаваржаа, өвөлжөө, зуслан, намаржаа энэтэй холбоотой өөрчлөгдсөн юм байна уу энд яг албан ёсоор тийм өөрчлөгдсөн юу байна уу? Аль эсвэл тэрийг шалгахаар байсан байвал шалгалтын дүнг яаж тайлангаа мэдээлдэг юм? Тэр талын асуудал асууя.

5 номер.

А.Энхманлай: Бейсен гишүүний асуултад хариулъя. Би түрүүн хэлсэн 6 аймаг дээр бид бүхэн бас энэ газар зүйн нэрийг гадаад нэр рүү орчуулж нэрлэж байн. Бас гадаад нэрээр нэрлэсэн байна гэсэн ийм асуудлыг шалгаж үзсэн байгаа. Тэгээд Баян-Өлгий аймгийн хувьд нийтдээ 199, 319 нэр гадаад нэр дээр орчуулж нэрлэгдсэн гэсэн ийм судалгааны хүрээнд бас тогтоосон байгаа. Үүнд Казак нэрээр 80 үг, Тува нэрээр 31 үг, Орос үг 9 гэсэн ийм судалгаанууд гарч ирсэн байгаа.

Тэгэхээр цаашид бид нар бас энэ Цэнгэл сум дээр бас 81 Монгол хэлээс өөр нэр дээр нэрлэгдсэн ийм бас зөрчил гарч ирсэн. Тэгэхээр энэ асуудлыг бид бүхэн орон нутагтай бас хамтарч хийсэн. Сумын иргэд, сумын засаг захиргааны байгууллагуудын төлөөллийг оруулж энэ ажлыг зохион байгуулсан. Ингээд энэ ажлынхаа хүрээнд гарсан үр дүнгээр сумдын Иргэдийн хурал, аймгийн Иргэдийн хурлаас Засаг дарга нараар дамжуулж саналуудыг авсан. Энэ саналыг дэмжсэн саналууд орон нутгаас ирсэн.

Ер нь төрийн захиргааны байгууллагууд бас яг энэ тогтоолыг, мөн энэ холбогдох хууль тогтоомжуудыг мэдэхгүйгээсээ болоод бас албан ёсны шийдвэр гаргасан. Баян-Өлгий аймгийн иргэдийн хурлаас багуудын нэрийг Казак нэр дээр нэрлэж ингэж шийдвэрлэсэн байгаа. Энийгээ эргээд энэ зөрчилтэй байсан учраас буцааж хүчингүй болгосон. Энэ асуудалтай холбоотой бас зарим хүмүүст холбогдох хууль тогтоомжуудын дагуу хариуцлага тооцож ийм асуудлууд шийдэгдсэн байгаа.

Тэгэхээр ямар ч байсан яах вэ энэ дээр нэмж хэлэхэд зөвхөн Баян-Өлгий аймаг дээр биш бусад судалгаа хийсэн 6 аймаг дээр бүгд адилхан ийм зөрчлүүд гарч ирсэн. Цаашдаа бид нар бас бусад үлдсэн аймгууд дээр энэ чиглэлийн судалгааг үргэлжлүүлж хийнэ. Энэ газар зүйн нэрийн мэдээллийн сан бүрдүүлж тодруулалт хийх ажлын хүрээнд ч гэсэн ийм зөрчлүүд илэрч байгаа. Тухайн орон нутагт амьдарч байсан гадаадын нэр бүхий иргэний нэр дээр тухайн уул, усыг

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

нэрлэчихсэн ийм зөрчлүүд байдаг. Эсвэл тухайн тэр аманд амьдарч байсан хүний нас барсан, аманд нь нас барсан хүний нэрээр нэрлэчихсэн ийм зөрчил байгаад байгаа юм.

Тийм учраас бид нар энэ 2003 оны Улсын Их Хурлын тогтоол батлахдаа энэ чиглэлийн бас тодруулах ийм юмнуудыг дутуу хийсэн юм болов уу гэж үзэж байгаа юм. Тийм учраас энийг одоо харин засаж зөв болгох, Монгол хэлнийхээ тухай хуулийг мөрдөж ажиллах, Геодезынхоо тухай хуулийг хэрэгжүүлэх ийм бас боломж гарч байгаа. Тэгээд мэдээллийн сан бүрдүүлэх ажил 49.5 хувьтай явж байна.

Одоо бол бүх газар нутгийг тусгай хувийн хэргүүд үүсгэж байгаа мэдээллийн сан дээр. Координатаар бүгдийг нь өгч байгаа. Яагаад энэ нэрийг энэ нэрээр нэрлэх болсон юм бэ гэдэг тайлбар, нотлох баримтуудыг бүгдийг нь хавсаргаж байна. Фото зураг, видео бичлэгүүдийг нэр болгон дээр бид нар үүсгэж, цаашид энэ чиглэлийн зөрчлийг манай ард иргэд болон орон нутгийн удирдлагууд гаргуулахгүй байх ийм энэ бас нөхцөл боломжийг бүрдүүлж өгч байгаа юм.

Б.Бейсен: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хууль санаачлагчийн танилцуулгатай холбогдон санал хэлэх гишүүн байна уу? Нэрс өгнө үү.

Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүнээр тасалъя. Бат-Эрдэнэ гишүүн санал хэлье.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Нэршил өгөх тухай уул нь Энхманлай даргаа хэлээгүй юм. Туркээр бичигдээд байгааг нь хэлсэн юм. Тэгээд Монгол хэлний тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль, бүх хуулиар чинь зөвшөөрөгдөхгүй шүү дээ. Та өөрөө мэдэж байгаа. Энийг чинь л хэлээд байгаа энийг ойлгоосой л гэж нэгдүгээрт хүсэж байна.

Хоёрдугаарт наад хяналт тавьж байгаа, хэрэгжүүлж байгаа агентлаг чинь болохгүй байна. Монополын эсрэг газар Монгол хэлний тухай хуульд хэрэгжилт тавьдгийг больё гэдэг л санаа хэлээд байгаа юм. Тэгээд мэдээж хуулийн асуудал л даа. Тэгэхдээ та хэд маань энэ дээр бас санаачилгатай байгаад, хэрэгжилт дээр нь хяналт тавьж чадахгүй байгаад байгаа учраас л наа чинь ийм олон асуудлууд үүсээд байгаа байхгүй юу. Түрүүний Цэрэндорж Дэд Ерөнхийлөгчийн хэлдэг үнэн. Бид нар уугуул нэрээ мартчихаад орчин үеийн нэрийг нь орчуулж ойлгоод тэр нь Монгол юм шиг ойлгоод байгаа байхгүй юу. Тэгээд уугуул нэрээ гадаад нэр шиг ойлгодог болчихсон ийм цаг хугацаанд бид нар амьдарч байгаа. Тэгээд зарим нэрийг гадаад нэр өгчихсөн байна гээд хайгаад байтал нөгөөдөх нь явж явж манай Монголын үндсэн уугуул нэр болж хувирсан.

Тэгэхээр энэ дээр чинь хэрэгжилт дээр нь хяналт тавьж байгаа байгууллага чинь ажиллаж чадахгүй байна л гэж би хэлээд байгаа юм. Монополын эсрэг газраа ажил хийдэг болгооч ээ, эсвэл байхгүй болгооч ээ, эсвэл чиг үүргийг нь ойлгомжтой болгооч ээ гэдэг дээр та хэд маань бас тодорхой хэмжээний санал, санаачилгууд дэвшүүлээд гаргаад яваасай л гэдэг л ийм л саналыг хэлмээр байна.

Тэгэхгүй бол наад хэрэгжилт дээр хяналт тавьж байгаа байгууллага чинь ажлаа хийхгүй, ажлаа хийж чадахгүй байгаатай холбогдуулаад л ийм асуудлууд ер

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

нь үүсэж байгаа шүү дээ. Одоо үе үеийн 4 жил явдаг энэ Улсын Их Хурал болон орон нутгийн сонгуулиар дандаа гарч байгаа. Ялангуяа Баян-Өлгийд Казак бичгээр, хэлээр нь ч дүүрч. Бичгээр бүх сурталчилгаагаа байршуулаад айлуудаар тараагаад. Тэгтэл төрийн албан ёсны хэл нь Монгол хэл байна гээд заачихсан хуультай. Төрийн сонгууль явагдаж байгаа төрийн албан ёсны хэлээр явагдах ёстой байдаг. Гэтэл хэрэгжилт дээр хяналт тавьж байгаа байгууллага нь ажлаа хийдэггүй.

Нэршил мөн адилхан. Одоо наад Туркээр бичсэн зар сурталчилгаа гэдэг юм уу Туркээр бичсэн нэршил чинь ингээд л хүн ярьсаар байгаад л эцэстээ тогтчихож байгаа байхгүй юу. Одоо бид нар Түргэний ам гэдэг үг ерөөсөө мэдэхгүй бараг. Түргэний ам, Түргэний ам гээд ингээд хэлэхээр ойлгохгүй Кувейтийн ам шүү дээ наадах чинь гэж ярьдаг урдаас. Тэгээд энэ чинь бас л газар орон нутаг нэршсэнтэй л холбоотой асуудал байхгүй юу. Тэгээд ингээд удаан хугацаанд яригдаад энэ дээр ямарваа байдлаар зар сурталчилгаа чинь байрлахгүй, мэдэгдэхгүй Түргэний амыг энэ бол Түргэний ам гэдэг газар юм гээд л бичихгүй л бол хүмүүс энэ Кувейтийн ам юм л гээд яриад байгаа байхгүй юу. Тэгээд ингэж явсаар байгаад 50 жил, 100 жил, 200 жилийн дараагаар тэр ам Түргэний ам биш Кувейтийн ам болж хувирч байгаа юм.

Тэгэхээр хууль дээр хэрэгжилт тавьж ажилладаг байгууллага чинь ажлаа хийхгүй байна. Монополын эсрэг газар гэдэг байгууллага огт ажил хийхгүй байна. Огт ажил хийхгүй байна.

Тэгэхээр энэ газраа ажилд нь оруулдаг талаас та бүхэн маань бас хажууд нь байгаа найз нөхдийн хувьд нь ч гэсэн туслаад дэмжээд өгөөрэй л гэж би хэлье дээ өөр юу хэлэх вэ дээ. Баярлалаа.

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүн санал хэллээ. Энэ Хаягжилтын тухай хууль гээд хэрэгждэггүй хууль байгаа юм. Энийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар энийг хэрэгжүүлэх тал дээр анхаараад хуулийн заалтад өөрчлөлт оруулах юм байвал яаралтай оруулаад хэлэлцүүлэх асуудал дээр анхаараарай гэж хэлье.

Гишүүд санал хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдээрэй.

“Тогтоолын хавсралт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтыг гишүүдийн 68.2 хувь нь дэмжиж, тогтоолын төслийн өөрчлөлт нь дэмжигдлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах гишүүнийг томилъё. Батчимэг гишүүн танилцуулах юм байна. Дараагийн асуудалд оръё. Ажлын хэсгийнхэндээ баярлалаа. Дараагийн асуудалд оръё.

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Хаврын тариалалтын бэлтгэл ажил, мал төлөлтийн явцын мэдээ болон цаг үеийн асуудлаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсьё.

Ажлын хэсгийг танилцуулчихъя Идэрбат Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Ц.Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Д.Есөн-Эрдэнэ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга.

Мэдээллийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Цагаанхүүгийн Идэрбат танилцуулна. 6 номер.

Ц.Идэрбат: Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд мал төллөлт, хаваржилт, хаврын тариалалтын бэлтгэл ажлын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар товч мэдээлэл танилцуулъя.

Тус яам нь Засгийн газрын 2025 оны хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 56 дугаар тогтоолын хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулж ажилласан бөгөөд тогтоолын хэрэгжилт 73.1 хувьтай байна. Засгийн газрын 2015 оны 286 дугаар тогтоолоор баталсан ган, зудын байдалд үнэлгээ хийх журмын дагуу зудын эрсдэлийн үнэлгээ хийхэд Өвөрхангай аймгийн Сант, Баянгол сумдын нутгаар төмөр буюу шилэн зудын, 11 аймгийн 56 сум нь цагаан зудын, 16 аймгийн 77 сум нь цагаанаар зудрах уу гэсэн үнэлгээ гарсан байна.

Түүнчлэн Засгийн газрын 2025 оны импортын зарим барааны гаалийн албан татварын хувь, хэмжээг тогтоох тухай 228 дугаар тогтоолоор малын тэжээлийг баруун 5 аймгийн хилийн боомтуудаар 2026 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл татваргүй импортлохоор шийдвэрлэж, 18.9 мянган тонн тэжээлийг импортлосон байна.

Мөн Засгийн газрын 2025 оны 230 дугаар тогтоолоор улсын аюулгүй нөөцөөс 760 тонн өвс 8.1 мянган тонн тэжээлийг зудын эрсдэл өндөр аймгуудад олгосон байна. Дэлхийн банкны санхүүжилтээр салбарын яамнаас хэрэгжүүлж буй мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн 2.3 тэрбум төгрөгийн санхүүжилтээр мянган тонн хүчит тэжээл, 400 тонн өвс, 1000 тонн эрдэс тэжээлийг худалдан авч, өвөлжилт, хаваржилт хүндэрсэн Баян-Өлгий, Дорнод, Завхан, Өвөрхангай, Увс, Ховд аймгуудад хуваарилан олгосон.

Өнөөдрийн байдлаар нийт төлөвлөвөл зохих 22.4 сая эх малын 29.6 хувь буюу 4.2 сая хээлтэгч мал төллөөд байна. Улсын хэмжээнд 4.2 сая төл хүлээн авснаас 4.1 сая толгой мал бойжиж бойжилт 98.9 хувьтай байна.

Мал төлөлтийг бүсчлэн үзвэл баруун бүс 32.6 3, зүүн бүс 20.8, төвийн бүс 29.4, хангайн бүс 31.9 хувьтай үргэлжилж байна. Улсын хэмжээнд 2026 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар нийт 186.9 мянган толгой мал зүй бусаар хорогдсон бөгөөд үүнийг төрлөөр нь авч үзвэл тэмээ 142, адуу 15.1 мянга, үхэр

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

19.1 мянга, хонь 71.2 мянга, ямаа 81.1 мянган толгой байгаа бөгөөд оны эхний нийт малын 0.3 хувийг эзэлж байна.

2.Хаврын тариалалтын бэлтгэл ажил

Энэ онд улсын хэмжээнд 372.7 мянган га-д үр тариа, 16 мянган га-д төмс, 18.3 мянган га-д хүнсний ногоо, 121.9 мянган га-д малын тэжээл, 104.1 мянган га-д тосны ургамал буюу нийт 633.4 мянган га-д тариалалт хийж, 474.8 мянган тонн үр тариа, 180.6 мянган тонн төмс, 273.9 мянган тонн хүнсний ногоо, 287 мянган тонн малын тэжээл, 69.1 мянган тонн тосны ургамал хураан авах зорилт дэвшүүлэн хаврын тариалалтын бэлтгэл ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг зохион байгуулж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 47 дугаар тогтоолоор баталсан Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аяны төлөвлөгөөг орон нутгийн түвшинд хангуулах, 2026 оны хаврын тариалалт, намрын ургац хураалтын хэвийн хэмжээнд гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэх, тариалангийн салбарт үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хаврын тариалалтын бэлтгэл ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган зохион байгуулж байна.

Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аяны хүрээнд Засгийн газраас хариуцан төлөх хүүгийн дэмжлэгтэй тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих эргэлтийн хөрөнгийн зээлийг банкны эх үүсвэрээр олгон ажиллаж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар 117 иргэн, аж ахуйн нэгжид 31.4 тэрбум төгрөгийн зээл хамрагдсан байна.

Салбарын яамнаас зээлийг жигд хүртээмжтэй байх зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын батлагдсан төсвөөс эх үүсвэрийг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

Мөн хаврын тариалалтын бэлтгэл ажлыг хангах хүрээнд 2025 оны ургацаас 154.6 мянган тонн хүнсний улаан буудайг зах зээлд нийлүүлсэн 405 иргэн, аж ахуйн нэгжид 12.3 тэрбум төгрөг, хүнсний ногооны зах зээлд нийлүүлсэн 572 иргэн, аж ахуйн нэгжид 4.8 тэрбум төгрөгийн урамшууллыг олгосон байна.

2025 онд импортолсон ургамал хамгааллын нийт 172.5 тонн бодис хадгалагдаж байгаа бөгөөд 2026 онд 8 аж ахуйн нэгжид 523 тонн ургамал хамгааллын бүтээгдэхүүн импортлох зөвшөөрлийг олгосон. Хөдөө аж ахуйн корпорац ТӨК нь бордоо импортлогч 3 аж ахуйн нэгжтэй 8295 тонн бордоо нийлүүлэх гэрээ байгуулагдсан байна. Хөдөө аж ахуйн корпорац ТӨК нь дилер аж ахуйн нэгжүүдтэй бордоо, ургамал хамгааллын бодис, таримал ургамлын үр, техник, тоног төхөөрөмжийг тариалан эрхлэгчдэд зээлээр олгож байна.

Түүнчлэн олон улсын геополитикийн нөхцөл байдлаас шалтгаалан шатахууны хангамж доголдох, нийлүүлэлт тасалдах эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлж, хаврын тариалалтад шаардлагатай 10 мянган тонн шатахууныг тариалан эрхлэгчдэд 3400 төгрөгөөр нийлүүлэх нөхцөлийг бүрдүүлэн шатахууны нийлүүлэлтийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамтай хамтран зохион байгуулж байна.

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Хаврын тариалалтад 50 мянган тонн улаан буудайн үр хэрэгцээтэй бөгөөд үүнээс аж ахуйн нэгжүүд өөрийн хэрэгцээнд 28 мянган тонн, Хөдөө аж ахуйн корпорац ТӨК-д 11.2 мянган тонн, нийт 32.9 мянган тонн үрийн нөөцийг бүрдүүлсэн байна. Хаврын тариалалтад дутагдаж байгаа 12 мянган тонн үрийг импортлох шийдвэрийг гаргаж, 22 аж ахуйн нэгжид импортлох зөвшөөрлийг олгосноор Оросын Холбооны Улсаас 13 аж ахуйн нэгж, 5250 тонн улаан буудайн үрийг импортлоод байна.

Хөдөө аж ахуйн корпорац 2500 тонн улаан буудайн үрийг тариалан эрхлэгчдэд дамжуулан зээлийн нөхцөлөөр олгохоор ажиглаж байна. Салбарын яамнаас хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэх, үнийн өсөлтөөс сэргийлэх, хангамжийг тогтворжуулах зорилгоор улсын төсвөөс 900 сая төгрөгөөр шар манжин, шар лууван, хүрэн манжин, байцайны үр худалдан авч тариалан эрхлэгчдэд зээлээр олгохоор ажиглаж байна.

Мөн Хөдөө аж ахуйн корпорац ТӨК төмсний үрийн нөөц бүрдүүлэхээр 3 мянган тонн төмсний үр нийлүүлэх гэрээг үр импортлогч 3 аж ахуйн нэгжтэй байгуулан ажиглаж байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь 2025 онд төсвийн гүйцэтгэлээс 160.9 тэрбум төгрөгийг санхүүжүүлээгүй бөгөөд 2026 оны батлагдсан төсвөөс өнөөдрийн байдлаар 117 тэрбум төгрөгийн өр авлага буюу улаан буудайн урамшуулал 9.8 тэрбум төгрөг, сүүний урамшуулал 4 тэрбум төгрөг, хүнсний ногооны урамшуулал 4.1 тэрбум төгрөгийг тус тус шийдвэрлээд байна.

Түүнчлэн Засгийн газраас хариуцан төлөх зээлийн хүүгийн татаасанд 99.08 тэрбум төгрөгийг шийдвэрлэсэн бөгөөд одоогоор хөнгөлөлттэй зээлийн хүүгийн дэмжлэгийн 7-11 сарын төлбөр буюу 5 тэрбум төгрөг байна. 2025 оны төсвөөс санхүүжүүлээгүй үлдэгдэл төлбөр болох ноосны урамшууллын 6.5 тэрбум төгрөг, арьс ширний урамшууллын 595.7 сая төгрөг, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний 17.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэхээр ажиглаж байна.

Байнгын хорооны гишүүд та бүхэнд мал төллөлт, хаваржилт, хаврын тариалалтын бэлтгэл ажлын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар товч мэдээллийг танилцууллаа.

Б.Бейсен: Идэрбат сайдад баярлалаа. Мэдээлэлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрс өгнө үү.

Наранбаатар гишүүнээр тасалъя. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Б.Бат-Эрдэнэ: Идэрбат сайдад баярлалаа мэдээлэл өгсөнд. Гурил, талхны үнэ намар нэмэгдээд эхлэхэд гол нөлөө үзүүлдэг зүйл өнөөдөр бид нар дизель түлш тэгээд тодорхой тариалан эрхлэгчтэй дизель түлшийг бол хямдралтай тарифаар, хямдралтай ч юу байх вэ дээ боломжийн нөөц хэмжээнийхээ боломжит үнээрээ олгож байгаа юм байна гэж ойлголоо. Намар үнэ нэмэгдэнэ ээ.

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Яагаад гэхлээр тэр гурилыг тээвэрлэдэг, тэр талхыг үйлдвэрлэдэг, хот хооронд тээвэрлэдэг бүх юм нь өөрсдөө дизель байдаг. Энэ ингээд нэмэгдэхээс өөр аргагүй нөхцөл байдал руу бид нар очиж байгаа. Тэгээд үнийн нэмэгдэлтэй бид нар яриад байх зүйл байхгүй болж байгаа гэж ойлгож байна. Угаасаа хязгаарлаж чадахгүйгээс хойш.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам энэ намрыг ер нь яг яаж харж байгаа вэ? Гурилын үнэ өснө, талхны үнэ өснө. Ард иргэдийн амьжиргаа, инфляц, татвар гээд ингээд бүх эдийн засгийнх нь уялдаа холбоог харж чадаж байгаа болов уу гэдгийг би асуумаар байгаа. Бид нар иргэдийнхээ цалинг нэмж чадахгүй, инфляцаа зогсоож чадахгүй байгаа бол татварын хөнгөлөлтийг л тодорхой хэмжээнд үзүүлэх нь хамгийн зөв юм шиг өөр гарц байхгүй юм шиг харагдаж байгаа юм. Баруун аймгууд тодорхой хэмжээнд импортын татвар тэглүүлдэг л дээ гааль дээр. Энэ нөхцөл байдал энэ хавраас, эсвэл намраас ч юм уу ахиад үргэлжлэх болов уу? Бусад аймгууд маань яах вэ? Тэгээд цогцоор нь ер нь юу гэж харж байгаа вэ л гэдэг ийм ганцхан асуулт л байна. Баярлалаа.

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? 6 номер хариулъя сайд хариулъя.

Ц.Идэрбат: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Таны ярьж байгаа асуудал бол үнэн. Энэ Ойрх Дорнодод үүсээд байгаа нөхцөл байдалтай холбогдуулаад хүнсний барааны үнийн нийлүүлэлт гээд олон зүйлүүдэд бас төвөг учруулж байгаа гэдэг нь үнэн. Монгол Улс дотооддоо хүнснийхээ хэрэгцээг хангах, энэ Хүнсний хувьсгал, Атар-4 гээд олон аянуудыг хэрэгжүүлж байгаа. Энэ аяны хүрээнд бид бүхэн энэ хаврын тариалалтыг цаг үеийн геополитикийн олон хүндрэлүүд дундуур саадгүй явуулахын төлөө хичээж байгаа.

Тэр дундаа намрын улаан буудайн үнэ, цаашлаад гурилын үнэ, цаашлаад талхны үнэд нөлөөлдөг энэ газар тариалангийн салбарын үнийн өсөлтөөс хамгаалахын тулд саяын таны хэлдэг үнийн өсөлтийн нэлээдгүй хувийг эзэлдэг шатахууны зардал дээр 3400 төгрөгөөр бид нар 1 литр дизель түлшийг нийлүүлж байгаа. Энэ ажил маань энэ 15 гээд зогсоно. Энэ бол та хямдралтай ч гэж дээ гэж байна. Энэ бол хямдралтай үнэ. 3400-гаар нийлүүлж байгаа энэ цаг үед яг зах зээл дээр 4000 гаран төгрөгийн үнэтэй байх үеэс эхлээд энийг нөөцөлж байгаа гэсэн үг. Одоо ингээд 4 сарын 15 гээд энэ ажил ерөнхийдөө зогсоно.

Намрын тариа хураалтад бидэнд үндсэндээ улаан буудай, ногоо гээд ингээд үзэхээр 4500-5000 тонн дизель түлшний асуудал хэрэгтэй болно. Тийм учраас намрын үнэ өсөлтийг хүлээхгүйгээр энэ хаврын тариалалтаа жигдхэн сайхан эхлүүлээд намрын үнийн өсөлтөөс сэргийлэх бензиний энэ шатахууны нөөцийн асуудал руугаа бид бас орохоор ингээд төлөвлөж байна. Санхүү, мөнгөнийхөө асуудлыг судалж байна.

Тариалан энэ хавар, өнгөрсөн хавар Монгол Улсын газар тариалангийн салбар хүнд цохилтууд авсан. Ган гачиг гээд олон зүйлүүдээс болоод өнөөдөр бид нар идэх төмсөө хүртэл 50 хувийг алдсан ийм зовлон дундуур явж байгаа. Тийм учраас энэ хаврын энэ тариалалтаас энэ намрын ургац хураалтаас энэ сэргэлт авахын төлөө бас ажиллаж байгаа юм. Тийм учраас ер нь өнгөрсөн энэ тариалангийн салбарт үүссэн хүнд цохилт, байгаль цаг уурын давагдашгүй хүчин зүйл буюу гангаас нэлээдгүй нөлөөлсөн.

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Жишээ нь, Монгол Улсын төмсний хэрэгцээний 60 хувийг хангаж байгаа Төв аймгийн Жаргалант сум гэхэд өөрөө өнөөдөр төмсний үрийн асуудалд орчихсон гэх жишээтэй. Тийм учраас энэ тариаланчдад үүсээд байдаг энэ хүнд зовлонг давахын тулд бид бүхэн энэ байгаль цаг уурын хүний хүчин зүйл нөлөөлөх оролдлого бол энэ нөгөө пуужин гэж ярьдаг үүлэнд зориудаар нөлөөлөх энэ арга хэмжээнд зориулаад сайдын багцаас 350 сая төгрөгөөр худалдан авалтууд зарлаж байгаа. Энийгээ аваад бид нар байгаль орчин, энэ цаг уурынханд хүлээлгэж өгөөд яг газар тариаланд зориулж энэ асуудлыг хэрэглэнэ ээ гэж ингэж бас өгнө. Тэгэхээр энэ нь бас эрсдэлээс нэлээн сэргийлнэ ээ гэсэн ийм бодолтой байна.

Үнийн, ганц газар тариалангийн салбарын биш ер нь хүнсний салбарын үнийн өсөлт бас тодорхой хэмжээнд ажиглагдаж байгаа, нийлүүлэлтийн доголдууд үүсэж эхлэх гэж байгаа юм. Тийм учраас Эдийн засаг, хөгжлийн яаман дээр Хөдөө аж ахуйн яам бид бас хамтраад энэ, үнийн өсөлт, энэ Ойрх Дорнодод үүсэж байгаа энэ ойлгомжгүй нөхцөл байдал цаашаа үргэлжилбэл бидэнд үүсэх хүндрэлүүдийн талаар бас урьдчилж харж, энэ нэгдүгээрт хүнсний нийлүүлэлтийн асуудал, үнийн хувьд өсөөд ирэх юм бол бид нар татварын зохицуулалт хүртэл хийх зайлшгүй шаардлага урган гарахыг үгүйсгэхгүй ээ гэсэн байдлаар бэлтгэл бэлэн, байдлыг бас хангаж ингэж ажиллаж байгаа гэдэг дээр. Баярлалаа.

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Идэрбат сайд маань бас өөрөө аймгийн даргаар олон жил ажиллаж байсан, энэ Байнгын хороонд бас олон жил байсан учраас юмнуудыг сайн ойлгож, мэдэж байгаа гэдэгт эргэлзэхгүй байгаа. Болорчулуун сайдыг бас зөвлөхөөр авсан байна лээ. Би их зөв шийдвэр болсон гэж ойлгож байгаа, харж байгаа. Болорчулуун сайдыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд байхад би бас Байгаль орчны сайдаар ажиллаж яг саяын таны хэлдэг гол урьд нь орхигдоод байдаг байсан тэр цаг уурт нөлөөлөх буюу пуужингийн асуудал дээр нэлээн сайн анхаарч байсан юм. Тэгээд тэрний хүрээнд ч гэсэн хавар эртхэн шиг чийгшүүлэлттэй ажлууд бас нэлээн сайн явж байсан. Тэгэхээр Болорчулуун сайд бас нөмөр нөөлөг болох байх гэж бодож байгаа.

Бэлчээр дээр би юм асуумаар байна. Яах вэ хадлангийн асуудал ороод ирчихсэн байна. Бэлчээрийн бодлогыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам ер нь яаж авч явж байгаа вэ? Хадлангийн асуудал байна, отрын асуудал байна, бэлчээрийн асуудал байна. Тэгэхээр.../минут дуусав./

Б.Бейсен: 6 номер сайд хариулъя.

Ц.Идэрбат: Манай яамны хувьд би ажлаа аваад 8 хонож байна. Тэгээд эхний ээлжид энэ цаг хугацаатай, технологитой, энэ газар тариалан, хаврын тариалалт руугаа ер нь онцгой анхаараад ерөнхийдөө тулгамдсан олон асуудлуудыг 2 ч удаагийн Засгийн газрын хуралдаанаар оруулаад шийдвэрлээд ингээд тариаланчидтайгаа нэгд уялдаа холбоотой ажиллаад бүгдээрээ ургуулахын төлөө, намар арвин ургац авахын төлөө ингээд хамтраад ажиллаж байгаа манай хамт олон, яам бол. Таны яг энэ тухайлан асуусан бэлчээртэй холбоотой энэ асуудал дээр бид зөвхөн бэлчээр гэж харахгүйгээр ер нь Монгол Улсын мал аж ахуйн аж ахуйн салбар гэдэг том агуулгаар нь харж, энэ мал аж ахуйн салбар дээр үүсээд байгаа энэ олон бодитой хүндрэлүүдийг бид цогцоор нь яаж давах вэ гэдэг тал дээр бас тодорхой төлөвлөгөөг энэ 8 хоногийн хугацаанд бас гаргаж байгаа.

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Тэгэхээр удахгүй энэ төлөвлөгөөгөө мэргэжлийн Байнгын хороо, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороондоо танилцуулгаас эхлээд бид ажилдаа орно. Тэр үеэр би танд бас дэлгэрэнгүй мэдээлэл өгье гэж.

Б.Бейсен: Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Тэгээд энэ жил Цөлжилтийн конвенцын талуудын 17 дугаар бага хурал Улаанбаатар хотноо зохион байгуулагдах гэж байгаа. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны асуудал мэт боловч Монгол Улс өөрөө бүх яамнууд энэ дээр орж ажиллах нэн шаардлагатай. Ялангуяа манай улсаа дэвшүүлсэн зорилт бол бэлчээр. Энэ жил ядаж энэ шонхроо хориглохчооч ээ. Цөлжилтэд бас тодорхой хэмжээнд нөлөөлдөг тэмцлийн багахан ч гэсэн хэмжээний хэсгийг нь өөрийн чадлаараа хийж байгаа амьтан болов уу гэж ойлгодог. Тэгээд СОР зохион байгуулагдаж байгаа энэ цаг хугацаанд шонхор барих энэ ажлууд яг давхацдаг. Тэгээд Сандаг-Очир сайдтай бас ярьж байгаад ялангуяа бэлчээрийн том конвенц бид нар дэвшүүлж байгаа учраас энэ шонхор гэдэг амьтан дээр нь та бүхэн энэ жил ядаж хориглолтын арга хэмжээг хийчих боломж байна уу гэдгийг би сайдаас асуух гэж байгаа юм.

Б.Бейсен: Сэддорж гишүүн, Замира гишүүн 2 асуулт асуухаар нэрсийг нь нэмчхээрэй. Сайд хариулъя 6 номер.

Ц.Идэрбат: Тийм бэлчээрийн хортон мэргэчтэй тэмцэхэд био олон арга хэмжээ зохион байгуулдаг. Гэхдээ байгаль өөрөө бас зохицуулдгийн нэг яг би таны энэ асуудал гэж ингэж бас ойлгож байна. Тийм учраас бэлчээр хамгаалах тал дээр энэ Засгийн газрын холбогдох яамнууд бид бас нэлээн хамтарч ажиллах болно. Саяын миний хэлдэг ингээд цогцоор нь танилцуулах энэ арга хэмжээ бэлчээртэй, мал аж ахуйтай холбоотой энэ асуудлууд ч тэр мөн энэ Байгаль орчны яамтай ингээд уялдаад ингээд явах зураглал, төлөвлөгөө бид гаргасан байгаа.

Тэгээд тэр хүрээндээ ер нь бэлчээр хамгаалалт дээр байгалийн өөрийнх нь зохицолдлогоо, дээрээс нь хүний хүчин зүйлийг яаж багасгах вэ, дээрээс нь бид энэ мал аж ахуйн салбараа, өнөөдрийн үүсээд байгаа энэ олон хүндрэлүүдийг давж гарахын тулд яаж зөв удирдах вэ гэдэг дээр цогц бодлогыг удахгүй танилцуулна. Тэр хүрээнд бас таны саяын асуулт орж ирнэ. Та сайдаар ажиллаж байсан хүний хувьд энэ асуудлыг маш сайн ойлгож байгаад баярлалаа.

Б.Бейсен: Нанзадын Наранбаатар гишүүн асуулт асууя.

Н.Наранбаатар: Байнгын хорооны гишүүдэд өглөөний мэнд хүргэе ээ. Тэгэхээр говь нутагт бол бас өдөр болгон л цөлжилт эрчимтэй явагдаж, бэлчээр нутаг хомсдож усгүйдэж байгаа малчид маань амьжиргаагаа залгуулах мал сүргээ өсгөж үржүүлэхэд бас их хүндрэлтэй байгаа. Тэгээд Цогтцэций сумын Сийрст багийн дарга Энхцэцэг гэж хүн над руу мессеж явуулсан байгаа юм. Тэгээд би энийг бас уншаад өгчихье гэсэн юм.

Сайн байна уу? Цогтцэций сумаас холбогдож байна. Манай сумын малчдын ноолуурыг авах газар байдаггүй. Үнэ хямд хамгийн бага ханшаар авч байна. Та говийн бүсийн сонгогдсон гишүүдтэй хамтраад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, сайдтай уулзаад энэ талаар дорвитойхон арга хэмжээ авч өгөөч.

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Суманд дуудлага худалдаа зохион байгуулдаг ч юм уу яахаар юм? Малчид маань банкны зээл, зээлийн хүүд байдгаа барж байна даа. Өдөр бүр хаврын хавсаргатай, дээр нь уул уурхайн тоосны нэмэртэй, хүүхдүүд хичээл сургуульдаа явчихсан, төл мал, ноолуурын ажилтай жинхэнэ ядарч байна даа. Та үүн дээр дөмөгхөн арга хэмжээ авч өгөөч ээ гэж Цогтцэций сумын нийт малчдын өмнөөс хичээнгүйлэн хүсэж байна гээд. Энэ дээр та хариулт өгөөдхөөч ээ.

Тэгээд Цогтцэций сум бол хамаг баялаг газрын доорх алт, эрдэнэс, нүүрсээ экспортод гаргаад л ингээд энэ улсыг тэжээгээд ингээд явж байдаг энэ улсын төсвийн ер нь тал хувийг нь Цогтцэций сумаас бүрдүүлж байгаа. Гэтэл газар нутагт нь амьдарч байгаа малчид нь иймэрхүү байдалтай байгаад байгаа юм. Тийм учраас бас энэ дээр яам ямар бодлого авч хэрэгжүүлэх вэ? Зүүн аймгуудад бол худалдааг бас амжилттай зохион байгуулаад 1 тонн ноолуур 200 мянга хүрсэн гэж мэдээ авсан. Тэгээд одоо энэ байдал нь ямар байна? Төрөөс яамнаас ямар бодлого баримталж төвийн болон баруун аймгууд руу авч хэрэгжүүлэх вэ гэсэн ийм үндсэн асуулт байна.

Мөн хүлэмжийн аж ахуй тойрогт ажиллаж байхад иргэд маань их асууж байдаг ямар нэгэн байдлаар төрөөс дэмжлэг юу байна гээд ялангуяа өвлийн хүлэмж. Тэгээд саяхан би яамны бас мэдээлэл харж байсан. Энэ жил 2.1 тэрбум төгрөг хүлэмжийн аж ахуйд зориулж өгнө, хүүгүй зээл өгнө, урт хугацаатай ийм зээл өгнө, өвлийн хүлэмжийг хэрвээ барих юм бол цахилгааны хөнгөлөлтийг үзүүлнэ ээ гэсэн. Энэ бас их аятайхан ийм мэдээлэл байгаа. Ялангуяа энэ говийн бүс нутагт ус ховортой газар хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх ийм бас боломж байдаг. Тэгээд энийгээ дэлгэрүүлж бас хэлж өгөөч ээ гэж.

Гурав дахь асуудал бол малын гаралтай түүхий эдийг боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн болгох, экспортлох ажил байгаа. Тэгэхээр энэ талаар бас олон ярьсан. Үйлдвэр, технологийн паркийн хууль баталсан. Тэгээд энэ чиглэлээр ямар ажлууд хийгдэж байна? Ойрын үед ямар үйлдвэрүүд ашиглалтад орох юм бэ? Малчидтай уулзаад явахад ерөөсөө дуу нэгтэй бүгдээрээ л ярьдаг асуудал бол энэ байдаг. Тийм учраас энэ.../минут дуусав./

Б.Бейсен: 6 номер сайд хариулъя.

Ц.Идэрбат: Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Нэгдүгээрт, ноолуурын асуудал байна. Ноолуур гэдэг Монголын малчдын хавартаа гол орлого олдог эх үүсвэр ээ. Тэгээд ноолуурын үнийг аль нэгэн сайд тогтоочихдог юм биш ээ. Энэ дэлхийн зах зээлийнхээ үнэ ханшаар зохион байгуулагддаг. Тийм учраас энэ жилийн ноолуур үнэтэй байна, үнэтэй болгочихлоо гэж ярих нь утгагүй асуудал. Энийг малчид ч гэсэн ноолуур дэлхийн зах зээл дээр ямар үнэтэй байгаа гэдгийг бодитоор нь хараад ингээд байж байгаа. Харин манай Хөдөө аж ахуйн яамны зүгээс хөдөө аж ахуйн биржээрээ дамжуулаад дуудлага худалдаануудыг зохион байгуулна. Энэ жил нөгөө ноолуурын цаг агаарын нөхцөл байдлаас болоод ноолуурын гаралт жоохон оройтсон. Зүүн аймгаас эхлээд энэ ноолуурын дуудлага худалдаанууд ингээд зохион байгуулагдаад явж байгаа.

Тэгээд энэ Хөдөө аж ахуйн биржийн гол ажил энэ дуудлага худалдаануудыг зохион байгуулах байгаа юм. Тэрнээс энийг бас малчдынхаа нөгөө тухайн бүс нутгийн ноолуурын гаралттай бид нар уялдуулахгүй бол самнаж дуусаагүй байхад нь тэгээд ноолуур зохион байгуулаад ингээд хаана хаанаа үр дүнгүй ажил болж

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

магадгүй учраас Хөдөө аж ахуйн биржтэй говийн бүсэд хэдийгээр зохион байгуулах боломжтой вэ, энэ ноолуур нуурын худалдан авах аж ахуйн нэгжүүд энэ тал дээр ямар байр суурьтай байгаа вэ, малчдын маань ноолуур хэр гаралт нь хэр байгаа вэ гэдэг дээр бас тал талаас нь үзэх ёстой ийм зүйл байна лээ гэж ингэж бас би хэлье.

Хоёрдугаарт, хүлэмжийн аж ахуйтай холбоотой асуудлыг та асууж байна. Ер нь Монгол Улсад энэ хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх зуны болон өвлийн хүлэмжийн асуудал руу бас Засгийн газрын зүгээс сая өнгөрсөн 3 дахь өдрийн хуралдаанаар дараа тодорхой тогтоол оруулж бас бид нар батлууллаа. Үүн дээрээ хүлэмж дээр хугацаа бас нэлээн боломжийг нь тавиухан, хүүгүй ийм зээлийг олгоно. Гэхдээ энэ зээл гэж энэ хүлэмж нь биетээрээ хүрээд ирэх юм билээ. Тэгээд өчигдөр Монголын тариаланчдын нэгдсэн холбоотой уулзахад хүлэмжийн чанараас авхуулаад олон зүйлийг ярьж байгаа юм. Нөгөө талдаа энэ хүлэмжийг бид нар нэг нэгээр нь биш яг таны хэлдэг энэ бүсчилсэн байдлаар хүлэмжийн аж ахуйг авч явах хоршоо, малчид, энэ хүмүүсээ бид бас малчид юу байх вэ, хоршоо, газартай, хоршоотой, бас энэ талын туршлагатай хүмүүстэйгээ нөгөө хоршоотойгоо бас уялдуулаад ингээд явах нь зүйтэй гэсэн ийм байр суурьтай байгаа.

Олгох дүрэм, журмын хувьд Хөдөө аж ахуйн яам маш нээлттэй ажиллана. Хэзээгээр олгох юм, яаж олгох юм, ямар дүрэм, журамтай юм гэдгийг нь бүгдийг нь нээлттэй дэлгэрэнгүй энэ иргэд олон нийтдээ түгээнэ ээ гэсэн ийм бодолтой байгаа.

Гурав дахь асуудал бол та маш чухал асуудлыг ярьж байна. Ер нь хөдөө аж ахуйн сайдын хувьд малаас гарч байгаа түүхий эд, ноос ноолуур, арьс шир, мах энэ 4-ийг дайвар бүтээгдэхүүн гэсэн. Энэ 5-ыг зах зээлийн эргэлтэд оруулахад ноолуур дэлхийн зах зээл дээрээ өсөхөд дагаад өсчихдөг ийм зүйл. Хөдөө аж ахуйн яам энэ салбарыг хариуцаж байгаа сайдын хувьд яг малчдын үнэгүйдээд байгаа энэ арьс шир, дайвар, ноос гэдэг энэ 3 зүйл рүү бид онцгой анхаарлаа хандуулах ёстой юм билээ. Тэрнээс үнэтэй юмыг нь шүүрч авчхаад одоо болж байна гээд ингээд толгой дохиод байхгүйгээр хаягдаад байгаа, үнэгүйдээд байгаа юм руу нь бид нар гол анхаарлаа хандуулна.

Ажил аваад энэ нөгөө бид нар малчдад олон ярьдаг нөгөө арьс, шир боловсруулах үйлдвэрүүд маань яг бодит байдал дээр хаана вэ гээд ингээд судлаад үзэхээр ер нь цаасан дээр олон төслүүд байна. Яг бодитой явж байгаа гээд ингээд дүгнээд үзэх юм бол энэ Эмээлтийнх байна гэж ингэж үзэж байгаа. Тэгэхээр Нийслэлийн Засан даргатай энэ нийслэлээс хэрэгжүүлж байгаа энэ Эмээлтийн энэ төслийг хурдавчлах, яаравчлах тал дээр онцгой анхаарч ажиллана.

Бид олон жил ярьсан Дарханы тэр арьс, ширний үйлдвэр бүтэлгүй болсон юм билээ. Энийг тэр төлбөр мөнгөө олж авах асуудал руугаа л орохоос биш шинэ тэнд үргэлжилж байгаа, хийж байгаа гэж түмэн олныг хуурах боломжгүй.../минут дуусав./

Б.Бейсен: Сайд гүйцээж хариулъя.

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Ц.Идэрбат: Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар Цагаан алт хөтөлбөр хэрэгжиж, энэ хэрэгжилтийн үе шат үндсэндээ 1, 2 дугаар шат руу орсон. Өчигдөр бид нар Цагаан алт хөтөлбөрийнхөнтэй бас уулзалтуудыг зохион байгуулахад энэ арьс, ширний салбар дээр энэ Монгол малын арьс, ширээр бүтээгдэхүүн хийж борлуулах энэ тал руугаа нэлээн манай үйлдвэрүүд шугамаа нэмэх, хүчин чадлаа нэмэх олон зүйлүүд бас хийгдсэн байна.

Тэгэхээр нөгөө анхан шатын болон гүн боловсруулалтын асуудлууд дагалдаад энэ бүтээгдэхүүн болгох энэ асуудлыг, бүүр цаашлаад энийг гадагш нь экспортлох асуудал гээд үндсэндээ энэ Хөдөө аж ахуйн яаман дээр мал аж ахуйтай холбогдолтой малын махны экспортын асуудал, ургамлын экспортын асуудал, энэ Цагаан алт хөтөлбөрийг цааш нь амжилттай экспортлох экспортын ажлын хэсэг, мөн дээрээс нь хэдэн сарын дараа хэрэгжих Евроазийн хэлэлцээрийг амьд болгох бас ажлын хэсэг гээд үндсэндээ 4 ажлын хэсгийг бас зохион байгуулалтад энэ 7 хоногоос оруулаад ажиллаж эхэлсэн байгаа гэж хэлье.

Б.Бейсен: Наранбаатар гишүүн тодруулъя.

Н.Наранбаатар: 2 жилийн өмнөөс ингээд Шинэ хоршоо хөдөлгөөн гээд төсөв дээр 2 жил дараалаад бас нэлээн төсөв хөрөнгө тавиад ингээд явсан. Тэгээд уг нь зорилго нь бол энэ малчдаа мал аж ахуйн эрхлэх, хажуугаар нь бизнес рүү оруулах, нэмэлт орлого олох, ханган нийлүүлэлтийн сүлжээ бий болгох, үүлдэр угсаагаа сайжруулах, анхан шатны боловсруулах үйлдвэртэй болох гээд зорилт тавьж явсан. Тэгээд энэ Шинэ хоршоо хөдөлгөөнийг яамны зүгээс юу гэж харж байгаа юм? Үр дүн ямар байв? Цаашдаа дараа дараа жилүүд дээр энэ хөдөлгөөнийг үргэлжлүүлж явах юм уу? Ирэх жилийн төсөв дээр төсөв, хөрөнгө тавих шаардлага байгаа юу? Эргэн төлөлт энэ тэр нь ямар байгаа юм, Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагаа нь ямар байгаа юм, эрсдэлтэй байгаа юу гэсэн ийм зүйл дээр тодруулга авъя.

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? 6 номер сайд хариулъя.

Ц.Идэрбат: Шинэ хоршоотой холбоотой асуудал малчдад маш том боломжийг бас олгосон. Олддоггүй байсан тэр 6 хувийн зээл жирийн малчинд очсон ийм том сэргэлтийн зээл болсон. Шинэ хоршоо хөтөлбөрийг цааш нь амилуулахад ер нь Шинэ хоршоо хөтөлбөрийн чиг үүрэг бол Шадар сайдын ажлын албан дээр бодлого нь гараад ингээд явж байсан. Шадар сайдтай бид бас энэ Шинэ хоршооны асуудлаар цаашид яаж хөгжүүлэх талаар энэ Шадар сайдын ажлын албатай Хүнс, хөдөө аж ахуйн яам энэ улс орон даяар байгуулагдсан хоршоодынхоо үйл ажиллагааг яаж идэвхжүүлэх вэ, яаж дэмжих вэ гэдэг тал дээр ер нь ажлын төлөвлөгөө гаргаад ингээд ажиллаж эхэлж байгаа юм. Тэгэхээр энэ ганцхан Шадар сайдын ажлын албаны асуудал биш Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Шадар сайдын ажлын албатайгаа хамтраад ингээд ажиллана.

Энэ хугацаанд олгосон зээлүүд дээр яг өнөөдрийн байдлаар эргэн төлөлт дээр хүндрэл гараад Зээлийн батлан даалтын сан дээр санхүүгийн сахилга бат алдагдсан тохиолдлууд гараагүй байгаа.

Б.Бейсен: Сэддорж гишүүн асуулт асууя.

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Р.Сэддорж: Байнгын хорооны дарга, гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе ээ. Сайдаас асуухад энэ амьд мал гаргах үйл ажиллагаа явж байгаа юу? Тэгээд энэ дээр ямар бодлого барьж байгаа вэ? Хүрэлсүх Ерөнхийлөгч байх аа амьд адуу гаргахыг болиулж байсан тээ? Тэгээд энэ амьд мал гаргах асуудал тийм ч сайн зүйл биш байх. Тэгэхээр хойшоо Эрхүү, Буриадад үржүүлж байгаа сураг байсан. Амьд манай Монгол малыг амьдаар нь гаргаж аваад. Урагшаа Замын Үүдээр гарч байгаа хэвээрээ юу? Энэ тийм ч сайн зүйл биш ээ.

Хоёрдугаарт нь махны экспортыг сүүлийн 2 жил хориогүй. Үүний үр дүн гарч байна. Малчдын орлогын 40 хувийн орлого олдог махнаас гэсэн ийм тооцоо байгаа. Тэгэхээр 40, 50 хувийн орлого олдог энэ юу нь үнэтэй байгаа учраас малчид маань бас жоохон ч гэсэн урамтай байгаа гэсэн ийм мэдээллүүд, статистик мэдээллүүд гарч байна.

Гуравдугаарт нь залуу малчид нэмэх тал дээр, залуу малчдыг төрүүлэх тал дээр ямар бодлого барьж байна вэ? Малчин өрхийн тоо хэдэн хувиар буурч байна жилд? Буурч байгаа нь ойлгомжтой. Жилд хэдэн өвөлжөө, хаваржаа эзэнгүй болж байна, хэдэн худаг ус эзэнгүй болж байна, ширгэж байна гэсэн энэ тооцоонууд дээр та хэлээч?

Малчин айлын хүүхдийн боловсролын асуудал дээр онцгой анхаарахгүй бол 1 дүгээр ангийн хүүхэд, 2 дугаар ангийн хүүхэд гээд дээр үеийнхээр 3 дугаар ангийн хүүхдийг 1 дүгээр ангийн хүүхэд дээр үеийн 1 дүгээр ангийн хүүхэд одоогийн 3 дугаар ангийн хүүхэд болж байж орж байгаа юм. 3 дугаар ангийн хүүхэд байгаа. Тэгэхээр 6 настнуудын малчин өрхийн хүүхэд дээр ямар бодлого барьж байна? Эндээс үүдсэн сумын төв, хөдөө тусдаа амьдрах, гэмт хэрэг, зөрчил, гэр бүл салалт, хүүхэд өнчрөл гээд олон асуудлууд эндээс үүсэж байгаа. Энэ дээр та яам ямар бодолтой байна? Зөвхөн Боловсролын яам руу хариуцах ёстой гэж бодож байна уу? Мал, малчин байхгүй бол тэгээд хөдөө эзгүйрэх янз бүрийн асуудлууд Монгол Улсын тусгаар тогтнолын асуудлууд яригдана. Эдгээр асуултад хариулж өгөөч.

Б.Бейсен: 6 номер сайд хариулъя.

Ц.Идэрбат: Сэддорж гишүүний асуултад хариулъя. Сэддорж гишүүнтэй энэ малчид дээр саяын хэлдэг үгтэй би 100 хувь санал нэг байгаа. Монгол Улс байгаа тохиолдолд мал, малчин 2 зайлшгүй л байна. Байж байж бас энэ улс орон байгаа. Энэ хил, хилийн бүс нутаг эзэнтэй байгаа, орон нутаг эзэнтэй байгаа. Тийм учраас ер нь зүгээр би сайдаа аваад маргааш нь мах ер нь яаж бий болдог, малчны хөдөлмөр гэж ямар хүнд юм байдаг талаар ярьж бас нэлээн шүүмжлэл авсан. Гэхдээ энэ бодит байдлыг хэлэхээс өөр аргагүй. Тийм учраас хэлсэн ийм зүйл байгаа.

Нэгдүгээрт, энэ амьд малын экспортын асуудал байна. Ер нь Хөдөө аж ахуйн яамны сайдын хувьд энэ махны экспортыг бид ямар нэгэн байдлаар зогсоох, тэнд тээг саад тавих ямар ч зорилго байхгүй. Харин ч бүүр энэ махны экспортыг бид өшөө нэмэгдүүлж, энэ орон нутагт махаа бэлдсэн аж ахуйн нэгжүүд зөвхөн Улаанбаатарт ирж аж ахуйн нэгжүүдээр дамжуулж гадагш нь экспортолдог биш орон нутгаасаа экспортоо хийх ийм бололцоог бүрдүүлж чадвал энэ дамжлагад нь зарцуулаад байгаа тэр хөрөнгө мөнгө бас малчдад, үйлдвэрүүдэд очно гэсэн ийм бодолтой байгаа. Энийгээ бид ингээд боловсронгуй болгоод ингээд

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

явуулж чадвал амьд малын экспорт гэдгийг бид бас эргэж харж зогсоох ийм байр суурьтай байгаа гэж ингэж бас хэлье.

Яагаад гэхээр энэ нэмүү өртөг энэ Монголдоо шингэх ёстой. Тэр арьс, шир, гэдэс гүзээ, дайвар бүтээгдэхүүн эндээ шингээд нэмүү өртөг болоод гадагшаа гарах нь ирээдүйд хэрэгтэй юм гэж ийм бодлого бид гаргаж байгаа, баримталж байгаа.

Дараагийнх нь энэ үржлийн нөгөө адууны асуудлыг ярьж байна. Ер нь энэ Замын-Үүдээр үржлийн бус малын 20 хувийг амьдаар гаргаж болно гэсэн Засгийн газрын тогтоолтой юм билээ. Тэгэхээр саяын энэ экспортынхоо арга хэмжээг бид нар маш сайхан зохион байгуулаад цар хүрээг нь нэмээд ингээд нэмүү өртөг шингээгээд энэ тогтолцоогоо бүрдүүлчихвэл гарахгүй ээ гэж, гарахгүй байлгах бололцоотой болно гэж ингэж бас харж байгаа.

Тийм ч учраас энэ 5 сарын 8-нд ер нь Хөдөө аж ахуйн сайдын өөрийн зорилго бол энэ махны экспорт, ургамлын экспорт гээд саяын 4 экспорт руу гол анхаарлаа хандуулна гэсэн энэ зорилтынхоо хүрээнд махны экспортыг нэмэгдүүлэх тал дээр Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хорио цээрийн албатай хамтраад 5 сарын 8-нд орон нутгийн бүх махны үйлдвэрүүдтэй сургалт хийж, ...-ийг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хорио цээрийн албанаас баталгаажуулж, экспортын эрхийг нь нээлгэхээр ингэж хичээж ажиллаж байгаа гэдгээ бас хэлье ээ.

Залуу малчдын асуудал яг орон нутагт явахад маш яригддаг ийм асуудал. Малчны хүүхдийн нас, сургуулийн насны хүүхдийн асуудал ч бас маш хурцаар яригддаг ийм зүйл. Ер нь зүгээр яг амьдрал дээр ингээд аваад үзэхээр, энэ цаг хугацааг ингээд аваад үзэхээр 2000 оны эхээр малчид хүүхдээ сургуульд сургахгүй мал дээр гаргаад байна гэдэг ийм зүйл байсан. Ер нь энэ мал аж ахуйг хөгжүүлэхэд бид нар мал аж ахуйгаас гарч байгаа ашиг тусыг л нэмэгдүүлэх юм бол олон залуучууд энэ хөдөө рүүгээ эргэж гарна гэсэн ийм л бодолтой.

Тэгэхээр ноолуур нь үнэтэй, мах нь экспорттой, ноос нь үнэтэй, хаягдаад байгаа арьс нь үнэтэй, хаягдаад байгаа дайвар бүтээгдэхүүн нь үнэтэй болчих юм бол малчид залуучууд эргээд мал аж ахуйн руугаа гарна л гэсэн ийм бодолтой. Одоогоор ингээд янз янзын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээд 5 сая төгрөг өгье, үүгээр мал аваад хөдөө гарчхаач ээ гэдэг ийм зүйлийг хэрэгжүүлэх гэж бас олон жил бид нар үзлээ шүү дээ. Тэгээд тэрний үр дүн бас төдийлөн гарч өгөхгүй байгаа юм. Тэгэхээр ер нь сууриар нь авч үзье гэвэл мал аж ахуйн дээр ажилласан хүн бол орлого сайтай, ашиг сайтай, амьдрал ахуй нь эргээд сайхан дээшилдэг, дэвждэг байхад олон залуучууд энэ хөдөө мал дээрээ гарна л гэсэн ийм бодолтой. Тийм учраас энэ салбарын суурь бодлого малчин хүний орлогыг нэмэгдүүлэхийг.../минут дуусав./

Б.Бейсен: 6 номер гүйцээж яриулъя сайд.

Ц.Идэрбат: Бүх тал дээр анхаарна. Яг үүн рүүгээ хандаад ингээд тухайлсан бас хуулийн төслийг бид бас анхдагч хууль юм байгаа юм. Энэ юу вэ гэхээр гэрээт малчны асуудал байгаа. Өнөөдөр малаа дийлэхгүй нэг малчин байхад мал дээр гарах юм сан гэж байгаа залуучууд бас олон байгаа. Тэгэхээр энэ хоёрын хоорондох эрх зүйн зохицуулалтуудыг ямар нэгэн зүйлээр хийгээгүйгээс болоод хаана хаанаа хөдөлмөрийн хариуцлага алдагддаг, хөлс мөнгө нь бодогддоггүй,

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

эсвэл төлөөр гэдэг, ноолуураар гэдэг, мотоциклоор гэдэг ийм аман тохироотой яваад байгаа энэ хөдөлмөрийн том зах зээлийг бид нар эрх зүйн хувьд бас зохицуулалт хийгээд өгөх юм бол олон залуучууд бас хөдөө мал дээрээ гарна гэсэн ийм бодолтой байгаа.

Малчдыг хүүхдийн насны асуудлаас энэ 6 настай хүүхэд гэдэг чинь бид нарын үеэр цэцэрлэгийн хүүхэд байгаа. Тэгээд сургуульд яваад дотуур байранд орно гэдэг бол өөрөө эцэг эхэд туйлын хүндрэлтэй. Үүнээс болоод олон асуудлууд үүсэж байгаа. Тэгээд одоо байгаа энэ нөхцөл байдлыг харахад ер нь сургуулийн дотуур байрны асуудал дээр бид нар зүгээр дотуур байрны яг 6 настай, 7 настай хүүхдүүдийг хариуцсан тасаг, багш, бүх зүйлийг л байлгах хэрэгт.../минут дуусав./

Б.Бейсен: Цагаанхүүгийн Мөнхбат гишүүнд асуулт асууя.

Ц.Мөнхбат: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе ээ. Идэрбат гишүүнийг Хүнс, хөдөө аж ахуйн сайдаар томилогдсонд их баяртай байгаа. Орон нутагт ажиллаж байсан, орон нутгийн амьдрал ахуй, орчин нөхцөлийг мэддэг, ойлгодог ийм хүн сайд болсонд их баяртай байгаа юм.

2, 3 асуудал байна. Сая энэ Наранбаатар гишүүн асуучихлаа манай говийн бүсийн Цогтцэций сумаас баахан мессеж ирээд байсан чинь бүгд рүү нь явуулсан юм байна л даа. Энийг би асуухаа больчихъё. Ер нь зүгээр нийтэд нь ингээд хамааруулаад ярихад бол үнэхээр бүс нутгийн хувьд ялангуяа энэ хавар цагт гол малчдын санхүүгийн эх үүсвэрийг бий болгож байдаг нөгөө ноолуур нь хамгийн бага үнээр авагддаг. Тоос шороотой холбоотой, уул уурхайг дагасан тэр үр нөлөөнд бас манай малчид маань нэрвэгдэж, хохирч байгаа ийм юмнууд байдаг юм. Тэгэхээр зэрэг сайд таны хувьд бол бүх ноолуур самнасны ард дээр бид нар дуудлага худалдаа зохион байгуулах байдаг юм уу арга хэмжээ авъя гэж ингэж хэлэх шиг боллоо. Энийгээ заавал авч хэрэгжүүлж өгөөрэй гэж хэлэх байна.

Өнгөрсөн жил ноолуурыг бас дараагийн дамжлагад оруулах, бас самнах үйлдвэрүүдээ дэмжих ийм зорилгоор бид нар бол малчдыгаа бол хохироосон гэх нь хаашаа юм тэгэхдээ ямар ч байсан жоохон учир дутагдалтай, сэтгэл дундуур үлдээсэн ноолуурын үнийг хязгаарлаж барьж. Тийм болохлоор тэр аж ахуйн нэгжүүддээ энэ саналыгаа тавиад тэгээд энэ малчдын ноолуурыг ялангуяа энэ манай бүс нутгийн говийн бүс нутгийн энэ малчдын ноолуурыг арай жоохон өндөрхөн үнэтэй авчих ийм боломж нөхцөлийг нь гаргаж өгөөрэй гэж хэлмээр байна сайдад. Энэ дээр ийм юу хэлчихье.

Тэр энэ түлш шатахууны асуудлыг хэдэн аж ахуйн нэгжүүдтэй ярьсан юм байна. Одоогоор 10 мянган тонн түлш шатахууны гэрээ байгуулья гэж ярьснаас 6100-г нь авчхаад байгаа юм шиг байна тийм ээ? Энэ үлдэгдлийг нь яах юм нэгдүгээрт?

Хоёрдугаарт энэ яг бодитой тоо мөн үү, эсвэл ямар аж ахуйн нэгжүүд нь энэ бензиний компаниуд чинь түлшээ нийлүүлээд байна? Бензиний компаниуд ерөөсөө түлшээ өгөхгүй байна. Бараг нөгөө хуучин үнээр орж ирсэн түлшээ дарчхаад үнэ нэмэгдсэн түлш орж ирэхээр өгөх гээд ингээд хүлээгээд байна гэсэн ийм юмнууд яриад байх юм. Энэ хэр бодитой байна гэдэг дээр бас хариулт авъя. Энэ төмөр зуд, шилэн зуд гээд хэд хэдэн аймгуудын мэдээлэл ирж байна.

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Б.Бейсен: Мөнхбат гишүүнд 1 минут.

Ц.Мөнхбат: Энэ хэзээний мэдээлэл вэ? Өнөөдөр чинь 4 сарын 14 болчихсон байна. Тэгэхээр зэрэг энэ мэдээлэл арай эрт мэдээлэл үү? Өнөөдөр, өчигдөр, уржигдрын мэдээлэл үү гэдэг энэ дээр тодорхой юм асуучихмаар байна.

Гуравдугаарт, энэ төмсний үрийн асуудалд орсон гэнэ ээ. Улаан буудайн үрийн асуудлыг бид нар ойлгож байгаа. Төмсний үрийн асуудал дээр яагаад орчихдог юм энэний учир шалтгаан юу байдаг юм? Энийг хэлж өгөөч. Энэ авсан, хураасан нөгөө төмс нь үрээ хураадаггүй юм уу, нөөцөд авдаггүй юм уу, эсвэл авсан нөөц нь муудаж сайдчихдаг юм уу? Энэ ямар учиртай юм?

Энэ арьс шир боловсруулах үйлдвэр гээд ингээд л сайд болгон л ярьдаг л даа. Гарч ирээд л сайхан болгоно гээд л. Тэгээд энэний учир шалтгаанаа ерөөсөө ингээд тодорхойлдоггүй. Болгоно л гээд байдаг. Болохгүй 5, 6 жил болж байна. Энийг бас

Б.Бейсен: 6 номерт сайд хариулъя.

Ц.Идэрбат: Ноолууртай холбоотой асуудал дээр ер нь энэ чинь малчдын маань гол орлого. Манай малчид хавар ноолуур, намар мах гэж төлбөр, тооцоо, төлөвлөгөөгөө гаргадаг ийм хүмүүс. Тэгээд энэ одоо яг хаврын энэ гол орлого олдог энэ үйл явцыг бид тэр Хөдөө аж ахуйн биржээрээ зохион байгуулаад малчид маань үнэхээр ноолуураа самнаад дуусчихсан бол тэр дуудлага худалдааг нь зохион байгуулаад ингээд явъя. Энэ дээр Хөдөө аж ахуйн бирж рүүгээ бас тодорхой чиглэлийг сая бас өгчихлөө нэгдүгээрт.

Хоёрдугаарт, тэр түлш шатахуунтай холбоотой асуудал дээр бид бас энэ 23 аж ахуйн нэгжтэй уул нь амаар тохирсон юм байна лээ. Санамж бичиг зурсан юм байна лээ. Харамсалтай нь тэн дээр ярьсан зүйлүүдээ зарим аж ахуйн нэгжүүд биелүүлэхгүй, эсвэл 50 хувь өгнө, эсвэл бүүр байхгүй ийм зовлон бас байгаа. Зовлон бас байгаа. Манай яамны хувьд үүнд шаардлагатай мөнгө санхүүгийн эх үүсвэрээ бүгдийг гаргаад өгчихсэн байгаа. Одоогийн байдлаар 7 мянга жоохон гаран тоннтой ингээд явж байгаа. Тэгэхээр цаад нөгөө импортлогч аж ахуйн нэгжүүдэд маань ч бас тодорхой зовлон байгаа байх.

Гэхдээ яг таны хэлдэг хардлага надад бас байгаа. Оруулж ирсэн түлшээ үнэ өсөхийг хүлээгээд байна уу үгүй юү гэдэг хардлага. Гэхдээ энэ аж ахуйн нэгжүүд зарим нь дийлэнх нь 13, 4 аж ахуйн нэгж нь хэлсэн ярьсандаа бас ингээд гэрээгээ биелүүлээд, санамж бичгээ биелүүлээд ингээд явж байгаа. Тэгээд энэ болгоны ар дээр бас дүгнэж үзэх цаг хугацаа бас бидэнд байгаа. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд энэ талаарх мэдээллүүдийг нь тогтмол өгч байгаа. Хэн нь өгөөд, хэн нь өгөхгүй, хэн нь ярьсандаа, хэн нь багасгаж хэн нь зүгээр амсуулах төдий яваад байгаа вэ гэдэг дээр бид бас эргээд ярих цаг гарах байх.

Энэ төмөр зудтай холбоотой асуудал дээр энэ Байнгын хороонд танилцуулах танилцуулга маань өөрөө өвөлжилт, хаваржилт, хаврын тариалан гэсэн учраас өнгөрсөн өвлийн нөхцөл байдлыг бас дурдаад өнгөрсөн юм.

Энэ төмсний үр дээр бас туйлын хэцүү байдал үүссэн юм байна. Өнгөрсөн жилийн энэ ган, манай Төв аймгийн Жаргалант сум бол Монгол Улсын төмсний

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хэрэглээний бараг 60-аад хувийг хангадаг юм байна шүү дээ. Гэтэл тэнд ган болсон. Дээрээс нь төмсний өвчин гарсан байна. Тийм учраас төмсний тариалалт дээр хүндрэл үүсэж байгаа. Тэгээд өнөөдөр энэ өнгөрсөн энэ 7, 8 хоногийн хугацаанд бид нар Иркутск, Оросын бас зарим хотуудаар явж 5 мянган тонн төмс ирээд 4500 нь 4 сарын 15-нд эхний 3 мянга нь Жаргалантын аж ахуй руу очиж эхлэхээр ийм гэрээ хэлцлүүд нь хийгдээд ингээд явж байна.

Ер нь цаашдаа бид ингээд бүхэл бүтэн улс олон аян ингэж байгуулаад тэгсэн хэр нь төмсний үрийг нэг аж ахуйн нэгжээс тэнд улс төмснийхөө үрийг гуйгаад явж байна гэдэг бидэнд харамсалтай зүйл. Тийм учраас ер нь төмсний үрийн хангалт дээр, хангамж тал дээр, нутагшуулах тал дээр, үржүүлэх тал дээр энэ яг энэ тариалангийн бүс нутагт энэ үржүүлгээр, энэ тариаланд бас ажиллаж байсан олон хүмүүстэй бас хамтарч ажиллая. Эрдэм шинжилгээний байгууллагуудаа ийшээ татаж оруулъя гэсэн ийм чигтэй байгаа гэж ингэж хэлье.

Арьс, ширний үйлдвэр дээр би яг л бодит байгаа байдлыг нь хэлж байгаа юм. Бид Дарханы үйлдвэр гэж хэсэг баахан ярьсан. Тэр нь өнөөдөр тэг зогсолт хийсэн. Ямар нэгэн тэнд арьс, шир боловсруулах үйлдвэрийн үйлдвэрийн үйл ажиллагаа явагдахгүй юм байна лээ. Тэр баахан Хөгжлийн банкны зээл хувь гээд бөөн хэрүүлтэй юм билээ. Энэ олон үйлдвэр, технологийн паркуудаас өнөөдөр хамгийн амжилттай явж байгаа нь би Эмээлтийг байна гэж харж байгаа. Говьсүмбэр, Дорноговийн нутагт байгаа тэр хувийн аж ахуйн нэгжийн тэр том төсөл бол маш сайн яваа юм билээ.

Тэгэхээр ер нь яамны зүгээс энэ арьс, ширийг эргэлтэд оруулах, дээрээс нь нөгөө Арьс ширний холбоо ,энэ нөгөө гутал, цүнх хийж байгаа энэ Цагаан алт хөтөлбөрийн хүрээнд хүчин чадлаа нэмэгдүүлж байгаа энэ аж ахуйн нэгжүүдтэйгээ бид нар бас арьс, ширний асуудал дээрээ нэлээн сайн цогц төлөвлөгөө гаргаж ингээд ажиллая. Бид малчдадаа үйлдвэр Дарханы үйлдвэр гээд л хэсэг баахан явсан, Эмээлт гээд л ингээд одоо яриад яваад байгаа байхгүй юу. Тэгэхээр яг аль нь бодитой юм, аль нь худлаа юм бэ гэдгийг үнэнээр нь хэлээд шийдэхийн төлөө яам хамтраад ажиллая гэсэн бодолтой байгаа.

Б.Бейсен: Мөнхбат гишүүн тодруулъя.

Ц.Мөнхбат: Ойлголоо. Мэдээлэл авлаа. Ер нь энэ арьс, ширний боловсруулах үйлдвэр дээрээ бүгдээрээ ингээд л яг сайд болонгуут нь ингээд олон юм асуугаад байж болдоггүй юм байна лээ. Бүгдээрээ л хийнэ, хэрэгжүүлнэ, болгоно, бүтээнэ гээд байдаг болохоор. Явцын дунд бол энийг манай Байнгын хорооноос удаа дараа шаардаж, шаардлагатай бол газар дээр нь хамт үзээд ингэж явах ёстой гэж ингэж ойлгоод байгаа тэгээд энэ бүх нөхцөл боломжийг бас сайд олгож өгөөрэй гэж нэгдүгээрт хэлэх байна.

Хоёрдугаарт энэ орон нутагт ингээд ажиллаад байхад энэ нөгөө та чинь малчдын сайд болчихсон шүү дээ. Малчдын гол яриад байгаа асуудал тэр Малчны тухай хуулийн НДШ-ийг нөхөн төлүүлэх асуудал хулхидсан юм байгаад байгаа шүү дээ манайхан. 26 оны 1 сарын 1-нд нөгөөх нь хүчингүй болчихсон. Тэгээд энийг тэр Нийгэм хамгааллын яамны сайдтай ярилцаж байж энийг бол хийх ёстой шүү гэдгийг заавал хэлмээр байна.

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Хоёрдугаарт, энэ Шинэ хоршоон дээр дахиад нэмэлт мэдээлэл.../минут дуусав./

Б.Бейсен: Сайд хариулъя 6 номер. 5 номер хариулах юм уу? Сайд хариулъя.

Ц.Идэрбат: Мөнхбат гишүүний асуултад хариулъя. Мөнхбат гишүүн бас маш бодитой асуудал ярьж байна. Одоо бид нар арьс ширээ яг яах юм бэ гэдгээ малчдадаа ил тод болгоод яг ямар үйлдвэр хэзээ байгуулагдах юм, яг яах гээд байгаа юм бэ гэдгээ ил болгоё. Тийм учраас салбарын сайдын хувьд энэ дээр маш анхаарлаа хандуулж ажиллана.

Нөгөө талдаа Улаанбаатар хотын удирдлагуудтай энэ тал дээр бас ярилцсан. Эмээлтийн энэ үйлдвэр бол ганцхан Улаанбаатарын ажил биш ээ энэ Монголын малчдын асуудал байгаа учраас хамтраад ажиллая, газар дээр нь очиж танилцъя гэсэн. Тэгээд Байгаль орчны байнгын хорооны, Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооныхонтойгоо бүгдээрээ хамтраад энэ төслийг урагшлуулахын төлөө бас хамтдаа зүтгэе ээ. Энэ бол малчдын орлоготой шууд холбоотой асуудал учраас Мөнхбат гишүүний саналыг дэмжиж байна гэж ингэж хэлье. Хоёрдугаарт .../минут дуусав./

Б.Бейсен: 6 номер гүйцээж хариулъя сайд.

Ц.Идэрбат: Малчны хуультай холбоотой хэрэгжилт дээр манай Хөдөө аж ахуйн яам бас ингээд дүгнэлт юмнуудаа гаргасан. Энэ олон маш олон хуулиуд дээр малчныг ингэнэ тэгнэ гээд, малчинд ийм дэмжлэг үзүүлнэ гээд ингээд хууль дээр заачихсан байгаа боловчиг амьдрал дээр хэрэгжихгүй байгаагийн бодит жишээ бол энэ нөгөө НДШ-тэй холбоотой асуудал байгаа юм. Тэгэхээр энэ дээр бид нар Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам руу энэ хэрэгжилтийн асуудал дээр ийм ийм зүйлүүд дээр анхаарах хэрэгтэй байна гээд ингээд саналаа хүргүүлнэ ээ.

Дээрээс нь малчны хууль дээр гарсан нөгөө ипотекийн зээл, малчны хүүхдийн их , ээд сургуульд сургах эд нар гээд олон зүйлүүд, эрүүл мэнд гээд олон зүйлүүд байгаа боловчиг хэрэгжилтийн хувьд туйлын хангалтгүй байгаа. Жишээ нь малчны хүүхдийг сургана гэхэд улсын хэмжээнд 160 мянган малчин өрх буюу 300 мянган малчин байхад 45 хүүхэд л сурч байх жишээтэй. Тэгээд тэр тавьж байгаа шаардлага эд нарын хэт өндөр тавиад эд нар гээд ингээд хэрэгжихгүй юмнууд. Ипотекийн зээл олгоно гэж байгаа боловчиг яг малчин статусаар ипотек авсан хүн байхгүй л байгаа.

Б.Бейсен: Ухнаагийн Отгонбаяр гишүүн асуултаа асууя.

У.Отгонбаяр: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийн энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Идэрбат сайдаас ганц нэг зүйл тодруулъя. Таны сая ярианд газар тариалан хүнд цохилт авсан, малчин хүний орлогыг нэгдүүлэхэд онцгой анхаарч ажиллана гэдэг зүйлүүд дурдагдаж байна. Энэ өнгөрсөн хугацаанд тэр дундаа мал аж ахуйн салбар, малчид руу чиглэсэн төрийн бодлого төдийлөн бас байгаа олохгүй, хэрэгжих боломжгүй, сая бас Мөнхбат гишүүн ярьж байна тэр Малчны тухай хууль гээд. Та бид нар тэр дундаа манай зүүн бүсээс сонгогдсон Их

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Хурлын гишүүд өнгөрсөн үндсэндээ 2 жилийн хугацаанд бүх сум суурин газар, багуудаар явж ажиллаж байсан.

Тийм учраас та бол яг амьдрал дээр тэр төрөөс гаргасан бодлого, амьдрал дээр хэрэгжиж байгаа юу үгүй юү гэдгийг маш сайн мэдэж байгаа ийм хүн. Цаашдаа тийм хэрэгжих боломжгүй бодлого бид бүхэн батлаад гаргаад яваад байх юм уу? Орон нутагт ажиллахад нүүр халуун байдаг юм шүү дээ. Та бүгд маань бүгд л мэднэ. Очоод нөгөө Малчны тухай хуулийн хэрэгжилтийг биднээс нэхдэг. Хэлэх үг байдаггүй. Тэгээд аргацаасан маягтай холбогдох яаманд нь уламжилъя, тэр дүрэм журмыг нь хурдан батлуулахад анхааръя гээд л иймэрхүү байдлаар л бид бүхэн хариулт өгдөг. Тэгээд цаашдаа энэ мал аж ахуйн салбар тэр дундаа малчид руу чиглэсэн бодлого яг амьдралд хэрэгжих ийм л бодлого баймаар байгаа юм.

Би юу гэж асуух гэж байна гэхээр яг тийм танд бодсон боловсруулж байгаа ямар бодлого байна? Энэ яг малчид руу чиглэсэн, мал аж ахуйн салбар руу чиглэсэн яг амьдралд хэрэгжих боломжтой. Энэ тал дээр та бас мэдээлэл өгөөч ээ гэж хүсэж байна.

Б.Бейсен: 6 номер сайд хариулъя.

Ц.Идэрбат: Отгонбаяр гишүүний асуултад хариулъя. Манай газар тариалангийн салбар өнгөрсөн гангийн улмаас маш хүнд байдалд орсон. Дээрээс нь нөгөө гаалийн татвар нэмнэ, хасна, авна, авахгүй, оруулна, оруулахгүй гээд энэ асуу судлууд яг газар тариалангийн салбарт ажиллаж байгаа энэ тариаланчид, гурилынхан тэд нар бас хүнд цохилт болсон гэдэг нь бас яг ингээд салбарынхантайгаа уулзаад ний нуугүй ярихад бас олон зүйлүүд дээр илэрч байгаа.

Малчдын хувьд үнэндээ манай Монголын мал аж ахуйн салбарын бодлогыг байгаа бодит зовлон олон маш олон юм байгаа юм. Жишээ нь энэ малын өвчний асуудал. Үүнээс болоод маш их эдийн засгийн хориглолтуудад ордог. Дээрээс нь энэ отор нүүдлийн асуудал, бэлчээрийн хомсдолын асуудал, малын нөгөө ашиг шимийн асуудал, дээрээс нь эдийн засгийн үр ашгийн асуудал гээд ингээд маш олон зүйлүүд байгаа юм.

Тэгэхээр эд нар ингээд малчид руугаа хандсан хууль гаргаад байгаа боловчиг хууль маань ингээд амьдрал дээр хэрэгжиж өгөхгүй хууль гарлаа гэж гоё ярьдаг. Даанч хэрэгжилт нь байхгүйгээс болоод сая Отгонбаяр гишүүний хэлж байгаа үнэн шүү дээ. Малчдын өмнө очоод бид нар нүүрээ улалзуулаад юм тайлбарлах нь битгий хэл ширээн доогуур орчихмоор үе зөндөө таарч байгаа шүү дээ.

Тийм учраас бид Хөдөө аж ахуйн яаман дээр энэ мал аж ахуйн саяын энэ нэр дурдагдсан энэ бүх бэрхшээлийг цогцоор нь харж, бэлчээрээ яах юм, ашиг шимээ яах юм, малын өвчнөө яах юм, мал эмнэлгийн тогтолцоогоо яах юм энэ, тэгээд яаж эцэст нь малын ашиг шимийг дээшлүүлэх юм, үүнийгээ дагаад малчны орлого яаж нэмэгдэх юм гээд энэ бүхнийг цогцоор нь харсан хөдөө аж ахуйн том бодлогыг удахгүй бас танилцуулна.

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Тэгээд энэ бодлого бол зүгээр ингээд суугаад хийчихсэн биш энэ яг хөдөө орон нутагт ажиллаж байхад, малчидтай уулзаж байхад энэ бэлчээртэй, мал эмнэлэгтэй, энэ малын ашиг шимтэй холбоотой олон асуудлуудтай бас нүүр тулаад явж байсан хүний хувьд амьдрал дээр хэрэгжих бүрэн бололцоотой зарим талдаа бараг туршигдаад амжилт гаргачихсан, эерэг үзүүлэлтүүд гаргачихсан, өөрчлөлтүүдийг авчирч байгаа энэ бодлогыг би энэ манай яамны хувьд манай хамт олон энэ өнгөрсөн 5, 6 хоногийн хугацаанд бас нэлээдгүй нухаж суулаа. Энийгээ удахгүй танилцуулна. Үүний хүрээнд бид нар зарим ганц хуулиуд дээр өөрчлөлт оруулна. Саяын миний түрүүний хэлдэг гэрээт малчин гэж яригдаад байгаа, туслах малчны ч гэж болох энэ анхдагч хуулийн асуудлыг Их Хуралдаа өргөн барина.

Үүнийхээ хүрээнд энэ олон асуудлуудыг цогцоор нь харж энэ говь, хангай, хээр гэсэн энэ Монгол улсын уудам энэ цаг уурын, байгалийн онцлогт тохирч амьдарч байгаа энэ малчид руугаа цогцоор нь харсан бодлогыг дэвшүүлж та бүхэндээ танилцуулна. Тэгээд энийг хэрвээ бид зөв төлөвлөөд, зөв хийгээд ингэж чадах юм бол яг сая Отгонбаяр гишүүний хэлдэг бидний бодлого байгаа онооно гэж ингэж бодож байгаа юм. Яг байгаа онооно.

Тийм учраас энэ байгаа оносон бодлогыг хөрсөн дээрээс нь яг малчдынхаа хэлж ярьдаг энэ олон зүйлүүдийг нь тусгаж байгаад гарц нь ийм байна гэсэн бодлогыг л танилцуулна гэж. Тэгээд ингээд цаг дуусаж байгаа учраас цаашаа дэлгэрүүлж ярих хараахан энэ богинохон хугацаанд дэлгэрүүлж ярих хараахан бололцоогүй байна. Ямар ч байсан энэ бодлогыг амьдрал дээрээс урган гарсан энэ бэрхшээлүүдийг яаж гарах вэ гэдэг бодитой хэрэгжих боломжтой ийм хөтөлбөрийг мал аж ахуйн сэргэлтийн хүрээндээ танилцуулна гэж ингээд товчхон хариулъя. Баярлалаа.

Б.Бейсен: Отгонбаяр гишүүн тодруулъя.

У.Отгонбаяр: Би бас энэ Хөдөө аж ахуйн яамныханд нэг зүйлийг бас хэлмээр байна. Та бүгд маань саяын таны мэдээлэлд сүүний урамшууллын асуудал нэлээн томоохон дүн бас яригдаж байна. Энэ яг сүүний урамшуулал яг ямар схемээр яг яаж яваад байгаа юм бэ? Хөдөө орон нутагт очихоор аймгийн төв дээр томоохон сум суурин газруудад байнга л яригддаг асуудал. Сүүнийхээ урамшууллыг авч чадахгүй байна тэгээд та бүгд маань өгөөд байна л гээд байдаг эс үгүй бол нөгөө авах гээд байгаа хүмүүс нь бас учрыг нь сайн олохгүй тэр яг схемд нь орж чадахгүй байна уу, эс үгүй танай схем тэр хүмүүс тэр схем рүү чинь систем рүү чинь нэвтэрч чадахгүй байна уу? Энэ чиглэл дээр та бүгд маань бас цаашид анхаарч ажиллаарай. Бас үүгээр бас тодорхой мэдээлэл өгөөч.

Б.Бейсен: 6 номер сайд хариулъя.

Ц.Идэрбат: Манай хөдөө аж ахуйн салбар дээр маш их дэмжлэг, дэмжлэгүүд, хөнгөлөлтүүд, зээлүүд ингээд олгогддог. Тэгээд сайдын хувьд баримтлах бодлого бол яг энэ олон дэмжлэг, туслалцаанууд яаж олгогдох юм, хэзээ олгогдох юм, ямар бололцоо байгаа юм, ямар шалгуураар байгаа юм энэ болгоныг маш тодорхой болгож энэ нээлттэй яам болгохын төлөө бид байгаа.

Тэгэхгүй бол ингээд хөдөө орон нутагт очиход арьс, ширний урамшуулал олгох юм уу үгүй юм уу, олгоод байгаа бол яаж олгоод байгаа юм, ноосны

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

урамшуулал яаж олгоод байгаа юм гээд ингээд байгаад байдаг. Энд ирээд цаасан дээр харахаар хэдэн тэрбум хэдэн зуун сая төгрөг гарч байгаа л гэсэн ийм зүйл яригдаад байгаа юм. Тэгээд яах вэ ажлаа аваад ингээд яг энэ хөнгөлөлт, дэмжлэгтэй холбоотой асуудлуудыг ингээд шүүгээд үзэхээр сүүний урамшуулал овоо аятайхан явж байгаа нь юм байна лээ. Ер нь тодорхой хэмжээнд үр дүнд хүргээд хүүхдийн сүү эд нар гээд ингээд ангилагдаад ингээд явж байгаа. Тэгэхээр энийг өшөө боловсронгуй болж хэнд ч ойлгомжтой ийм схем болгох шаардлага.../минут дуусав./

Б.Бейсен: Пүрэвийн Батчимэг гишүүний асуулт асууя.

П.Батчимэг: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Идэрбат гишүүн сайдын ажлаа аваад удаагүй байгаа байх. Ер нь бол энэ өнөөдрийн Байнгын хорооны хурлаар орж ирж байгаа асуудал өвөлжилтийн нөхцөл байдал, үр дүн, хаврын энэ хаваржилт, мал төллөлт, энэ тариалангийн бэлтгэл ажлын талаарх тайлан, мэдээлэл хүргэж байх шиг байна.

Тэгэхээр энэ хаврын тариалалтаа зориулж Засгийн газраас хариуцан төлөх хүүгийн дэмжлэгтэй 130 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн хөнгөлөлттэй зээлийг олгохоор шийдвэрлээд сая энэ 26 оны 2 дугаар сарын 25-ны өдөр банкнуудтай хамтраад тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих эргэлтийн хөрөнгийн зээл гээд ийм санхүүжилтийн гэрээ байгуулсан гэж байна тээ? Тэгэхээр одоо 117 иргэн, аж ахуйн нэгж энэ зээлд хамрагдаад 31.04 тэрбум төгрөгийн зээлд гарчихсан гэж байгаа юм байна л даа.

Тэгэхээр энэ зээлийг ямар нөхцөлөөр, ямар аж ахуйн нэгжүүдэд, иргэдэд яаж ямар шатлалаар энийг олгож байгаа юм бэ? Ингээд харахаар 130 тэрбум төгрөгийн энэ тогтоосон хөнгөлөлттэй зээлээс 31 нь гарчихсан гэдэг чинь энэ үлдсэн 4-ний 1 нь л гарсан гэсэн үг үү? Тийм ээ 4-ний 1 нь. Тэгэхээр цаашид энийгээ эрчимжүүлэхгүй юм уу? Тэгэхгүй яг ингээд тариалалтын тариалангийн ид тариаланчид бэлтгэлээ базаагаад тариаландаа гарчихлаа шүү дээ тариалалтдаа. Энэ зээл их удаашралтай явагдаад байгаа юм шиг харагдаад байх юм. Энэ дээр та тодруулж өгөөрэй.

Өнөөдөр би Хүнс, хөдөө аж ахуйн Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун даргын ярилцлагыг хэвлэлд өгснийг уншлаа л даа. Эндээс нөгөө хүнсний ногооны 4 төрлийн хүнсний ногоон дээр үр олгоно гээд. Энэ Засгийн газрын тогтоолын дагуу хэрэгжиж байгаа. Тэгэхээр энэ ерөөсөө энэ 1500 га гэдэг чинь нийт хүнсний ногоон тариалалтын ерөөсөө 10 орчим хувь л хамрагдаж байна гэсэн үг үү? Тэгэхээр энэ шар манжин, хүрэн манжин, лууван, байцай. Шар манжин, хүрэн манжин, луувангийн хувьд тариалалт 5 сараас мэдээж эхлэх байх.

Гэтэл байцай гэдэг энэ хүнсний ногоо чинь эрт тариалалт эхэлнэ шүү дээ. Тариалалтын бараг эхлэх хугацаа болчихсон байж байхад нөгөө хөнгөлөлттэй зээл нь ингээд сунжраад байвал бараг цаг хугацаандаа энэ хүнсний ногоо тариаланчид чинь авч чадахгүй нь байна шүү дээ. Дундговь, Өвөрхангай, Дорноговь энэ аймгуудад байгалийн хадлан тэжээл авч чаддаггүй. Дандаа ингэж худалдаж авдаг. Зүүн аймгаас ирсэн хадлангаас худалдаж авдаг энэ нутгийн иргэдэд хүнсний ногоо тариалалт тариалангаас илүү улаан буудайнаас илүү ач холбогдол өндөртэй амь зуулга гол хэрэгцээ шаардлага нь. Тэгэхээр энэ та ер нь.../минут дуусав./

Б.Бейсен: 6 номер сайд хариулъя. Батчимэг гишүүн 1 минут авъя гэж байна.

П.Батчимэг: Тэгэхээр Идэрбат сайд зүүн бүсээс сонгогдсон ингээд тариалангийн бүс нутаг та ер нь сая сайдын ажлаа аваад тариалангийн бүс нутгаар хэр их явж ажиллав? Энэ хангайн бүс тэр байгалийн хадлан, тэжээл авч чаддаггүй энэ бүсүүд дээр ер нь цаашдаа хэр явж ажиллах юм бэ? Хүнсний ногоо өнөөдөр ард иргэдийн хамгийн амин зуулга болчихсон, мах үнэд орчихсон, одоо дагаад хүнсний ногоо үнэд ороод эхлэх юм бол ер нь ард иргэд юу идэж байх юм бол? Тэгэхээр таныг тэр бүсүүдээр явж ажиллаасай гэж хүсэж байна. Энэ дээр энэ зээлийн хувааж төлөх нөхцөлтэйгөөр иргэдэд олгож байгаа энэ зээл их л бага санагдаж байна даа. Тэгээд энэ дээр сайд ер нь таны өөрийн байр суурь ер нь ямар байгаа юм оо?

Б.Бейсен: 6 номер сайд хариулъя.

Ц.Идэрбат: Батчимэг гишүүнийхээ асуултад хариулъя. Бас чухал зүйлүүдийг хөндөж байна. Би сүүлийн асуултаас нь эхэлье. Тариалангийн бүс нутгаар хэр явсан бэ гэж. Миний хувьд сайдын ажлыг аваад үндсэндээ 7 хонож байна. Тэгээд сайдын хувьд миний хувьд энэ салбартай танилцаад газар дээгүүр нь очоод давхиад байхаасаа илүүтэйгээр энд тулгамдсан асуудлуудыг нь яаралтай шийдвэрлэх.

Яагаад гэвэл яг саяын таны хэлдэг энэ газар тариалан гэдэг чинь өөрөө цаг хугацаатай, технологитой, хэн нэгний ажлыг хүлээдэггүй ийм учраас Дарханд очиж газар тариаланчидтайгаа уулзаж, үндсэндээ тулгамдсан 3 асуудал буюу энэ 130 сая төгрөгийн зээлийг идэвхжүүлэх, хоёрдугаарт шатахууны асуудал, гуравдугаарт нөгөө зээлийн оноо, өнгөрсөн жилийн гангаас шалтгаалаад зээлийн оноо нь багассан аж ахуйн нэгжүүд зээл авч чадахгүй байгаа энэ процессыг хурдлуулах гэдэг 3 асуудлыг тодорхойлоод өнгөрсөн Лхагва гаргийн Засгийн газрын хуралдаанаар шийдвэрийг нь гаргаад, хэрэгжилтийг нь хангаад ингээд ажиллаж байгаа.

Мөн Засгийн газрын хуралдаанаар бид нар албан даалгавраас гадна тогтоол гаргасан. Тогтоол дээр энэ хүнсний ногооны хангамжийг нэмэгдүүлэх, ер нь цаашдаа тогтворжуулах ийм асуудлуудыг сөхөж гаргаж ирсэн. Тэгэхээр энэ 900 сая төгрөгийн үрийн асуудал бол мөнгөөрөө шууд худалдах ийм асуудал байсныг нь зээлээр олгох ийм зохицуулалтыг энэ Засгийн газрын тогтоолоор шийдвэрлүүлээд өнөөдрөөс үрүүд нь ирж байна. Маргаашаас тариаланчид руу саяын хэлдэг 4 нэр төрлийн үр тараагдана. Энэ технологитой учраас бид маш их яараад байгаа юм гэж ингэж хэлье.

Дараагийн асуудал энэ 130 тэрбум төгрөгийн зээлийн асуудал байна. Өнгөрсөн жил Их Хурал та бид бүгдээрээ хамтарч байгаад энэ газар тариалангийн салбар дээр зээлийн хөнгөлөлттэй зээл олгохдоо 130 тэрбум төгрөгийн татаасны эх үүсвэрийг л шийдэж өгсөн. Тэгэхээр яг тэр хүрээндээ ингээд явж байгаа гэсэн үг.

Энэ 130 маань бас дотроо их учиртай. 100 сая нь зөвхөн үр тариа. 100 тэрбум нь үр тарианд. 30 тэрбум нь хүнсний ногоонд гэсэн ийм 2 ангилалтай явж

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

байгаа. Тэгэхээр ингээд 130 тэрбум төгрөгийг олгож байгаа гэж яриад байгаа боловчиг амьдрал дээр энэ маань маш удаан олгогдож байна. Аж ахуйн нэгжүүд авч чадахгүй байна гэдэг гомдол байгаа. Нөгөө талдаа эх үүсвэрийн хувьд бас бага байна гэсэн ийм гомдол байгаа юм.

Тийм учраас өнөөдөр ингээд 14 цагаас Монголбанк арилжааны банкнуудтайгаа яриад гэрээ байгуулах гэж байгаа. Энэ 130-ийг бид нар 200 тэрбум болгож өсгөх гэж гэж байгаа. Тэгэхээр газар тариалан буюу улаан буудайн тариалалтад оруулж байгаа 100 тэрбумыг бид нар 130 буюу 130 тэрбум, 140 тэрбум болгож өсгөөд ингээд 100-г нь 140 болгож өсгөж байгаа гэсэн үг. Нөгөө дотроо ангилсныгаа. Энийг бол эргэлтийн хөрөнгөөр. 30 тэрбум хүнсний ногоонд байсныг 60 тэрбум болгож өсгөө зээлийг нь.

Гэхдээ энэ 60 тэрбумын 45 нь эргэлтийн хөрөнгө болъё. 15 тэрбумыг нь механикжуулалтын ажил руу чиглүүлье ээ. Тэгэхгүй бол хөрөнгө оруулалтын зээл болгоё. Тэгэхгүй бол энэ нөгөө газар тариалан маань өөрөө ялангуяа хүнсний ногоо маш их хүн хүч шаарддаг, цаг хугацаа шаарддаг, ажиллах хүчний нөөц бололцоо төдийлөн ирдэггүй, талбай дээрээ ажилладаггүй гээд энэ зовлонг манай ногоочид маш ихээр ярьж байгаа. Тэгэхээр энэ энэ салбарын сайдын ажлыг аваад энэ 7, 8 хоногийн хугацаанд гол анхаарлаа хандуулсан ажил маань энэ саяын хаврын тариалалт, саяын миний ярьдаг мал аж ахуйн хөгжлийн асуудал, дээрээс нь тулгамдсан асуудлыг шийдвэрлээд орхих биш гүйцэтгэл дээр нь бид маш анхаарч байгаа.

Тэгэхээр дээрээ ярьсан юм дундаа явдаггүй, анхан шатдаа бүүр очдоггүй тэгээд сайхан ярьсан ийм л байдал үүсчих гээд байдаг учраас дээрээ гаргасан шийдвэрээ дундаа яаж хэрэгжээд байгаа юм, анхан шатын ногоочид дээр яаж очиж байгаа юм бэ гэдэг ийм зүйлийг бид нар шийдвэрлэхийн тулд ногоочдоос гарсан саналыг саяын энэ төсөл, хөтөлбөрүүддээ хамруулж байгаа гэж.../минут дуусав./

Б.Бейсен: Батчимэг гишүүн тодруулъя.

П.Батчимэг: Гол нь Идэрбат сайд энэ 100 чинь саяын энэ зээл чинь сайдын батлагдсан төсвөөс эх үүсвэрийг нэмэгдүүлэх гээд байгаа юм л даа. Тэгэхээр таны хэлсэнтэй яг нийлж байгаа юу тээ? Тэгээд Идэрбат сайдын хувьд бол бас саяхан, дөнгөж саяхан ажлаа авсан. Мөн сайдын ажлаа авчхаад сайдын зөвлөхийг бас та томилуулсан байна лээ. Тэгэхээр таны сайдын зөвлөхөөр томилогдсон Болорчулуун гээд энэ хүн өнөөдөр яг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын зөвлөх хийх ийм эрх зүйн чадвар, ашиг сонирхлын зөрчилд дахиж өртөхгүй байх ийм хэмжээний зөвлөхийг та сонгож авч чадсан уу? Урьд нь сайдаар ажиллахдаа, урьд нь гишүүнээр ажиллаж байхдаа Жижиг, дунд үйлдвэрлэл, Жижиг, дунд үйлдвэрлэлийн зээл, малын үхрийн нөгөө зэмэг энэ гэсэн.../минут дуусав./

Б.Бейсен: 6 номер сайд хариулъя.

Ц.Идэрбат: Зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх асуудлын хүрээнд 130 тэрбумаа бид нар 200 болгож эх үүсвэрээ нэмэгдүүлээд үүнд шаардагдах татаасны асуудлыг салбарын сайдын хувьд одоо шийдвэрлээд салбар дотрынхоо багцаас ингээд шийдвэрлээд ингээд явж байгаа. Харин түгээлтийг нь хурдлуулах,

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

тэр сумд ногоо тарьж байгаа тэр хүмүүст очих, тэгээд энэ ногоо манай газар тариалангийн салбарынхан олон зүйлүүдийг ярьж байгаа нь зөвхөн төвийн бүс биш.

Жишээ нь Сүхбаатар аймаг дээр тариаланчдын, ногоочдын холбоо байгуулагдаж байх жишээтэй. Увсын Баруунтуруун хавьцаа бас олон тариаланчид байна гээд ингээд энэ тал руу. Булганыхан яагаад биднийг орхиод байгаа юм бэ гээд. Ингээд маш бодитой саналуудыг сайдад уламжилж байгаа юм. Тийм учраас энэ хаврын тариалалттай холбоотой энэ зээл, хувь энэ хөнгөлөлтийн асуудлыг бид нар нэгдүгээрт ил болгоно. Хоёрдугаарт шаардлагатай бүх л газруудад хүргэхийн төлөө эх үүсвэрийг нь нэмэгдүүлж байгаа гэж ингэж хэлж болно.

Таны хоёр дахь асуудал өчигдөр томилогдсон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын зөвлөх Хаянгаагийн Болорчулуун.../минут дуусав./

Б.Бейсен: 6 номер гүйцээж хариулъя.

Ц.Идэрбат: Ашиг сонирхлын асуудал дээр хэн нэгэн хувь хүн чи ашиг сонирхолтой гэж ингэж дүгнэх ийм би юм биш ээ. Энэ хуулийнхаа дагуу АТГ-т энэ хүн энэ салбарт ажиллахад ашиг сонирхлын зөрчил байгаа эсэх талаар албан бичиг юмнуудыг нь бүгд хууль ёсоор нь аваад томилсон.

Хоёрдугаарт, Монгол Улсын газар тариалан, ер нь хөдөө аж ахуйн салбарын сайдын зөвлөх бол магадгүй гадаад, дотоод сургууль төгссөн хэд гурван хэлтэй гэхээсээ илүүтэйгээр малчны хотны амьдрал мэддэг, газар тариалангийн салбарын тэр хаврын хавсарганаас намрын хяруу унатал энэ тариаланчид яаж зовж зүдэрч ажилладаг вэ гэдгийг мэддэг мэргэжлийн хүн байх нь зүйтэй гэж ингэж үзэж энэ 3 удаа Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж, Хүнс, хөдөө аж ахуйн, байгаль орчны байнгын хорооны даргаар, мөн энэ салбарыг 2 жил удирдаж, энэ салбарыг удирдаж байх хугацаанд Монголын хөдөө аж ахуйн салбарын экспортын орлого нэмэгдэж байсан тэр үзүүлэлтүүдийг харж томилсон гэж.../минут дуусав./

Б.Бейсен: Мандхай гишүүний асуултаа асууя.

М.Мандхай: Энэ өдрийн мэндийг хүргэе. Хөдөө аж ахуйн сайдад ямар ч байсан шинэ ажлаа аваад маш эрч хүчтэй ажиллаж байгаад нь бас талархаж байна. Тэгээд таныг ер нь цаашдаа энэ хөдөө аж ахуйн яг энэ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудлыг хариуцахдаа ер нь малын тоо бус чанарт суурилсан бодлогыг хэрэгжүүлдэг байх, бэлчээрийн энэ менежментийн асуудлыг энэ даацын 40 хувь орчимд хэтэрсэн байгаа асуудал дээр зохистой түвшинд хүргэх ямар бодлого хэрэгжүүлэх дээр онцгойлон анхаараач ээ гэдэг бас захиж хэлэх ийм санал байна.

Танилцуулгыг ер нь хийхдээ бид нар өнгөрсөн жил ч гэсэн яг л ийм танилцуулга хийж байсан юм. Ер нь 2 онтой харьцуулж ядаж хармаар байна. Өнгөрсөн жилтэй хийсэн энэ бэлтгэлийн ажил одоо энэ жилтэй ер нь харьцуулахад сайжирсан юм уу муудсан юм уу, яг ямар өөрчлөлтүүд гарсан юм гэдэг дээр бид нар харьцуулж харж байж үнэлэлт, дүгнэлт өгдөг болмоор байгаа юм.

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Танилцуулга дээр энэ ургамлын ургалт хоцорч байна гэсэн байгаа. Энэ нь өөрөө тариалалтад хэрхэн нөлөөлөх вэ гэдэг асуултыг асууя. Тэгээд ер нь эрсдэлээс ямар сэргийлэх механизмууд бас та бүхэнд дэвшүүлж байгаа юм бэ? Ээ хөнгөлөлттэй зээлийн энэ ашиглалттай холбоотой сая Батчимэг гишүүн асуучихлаа. Гэхдээ ер нь манай хөдөө аж ахуйн салбар бол төрийн дэмжлэг маш өндөртэй, хамгийн ер нь бараг өндөр төрийн дэмжлэг, урамшуулал авч байгаа салбар. Энэ үр ашигтай эсэхийг нь бид нар яаж үнэлээд байгаа юм бэ? Энэ үнэлгээний холбоотой асуудлыг мэдмээр байна. Ер нь төрийн дэмжлэг ороод байдаг. Үр ашигтай гэдгийг нь яг хэмжих үзүүлэлт нь хаана байна гэдгийг бас мэдмээр байна.

Хоёрдугаарт, энэ бордоо, ургамал хамгааллын бодис хэрэгцээ хангагдаагүй ээ гэсэн тоо байна лээ. Жилд 12-15 мянган тонн байхад 3-хан аж ахуйн нэгж байгууллага 8300 орчим тонныг нийлүүлсэн байгаад байгаа юм. Тэгэхлээр энэ нийлүүлэлт хэрэгцээ хоёрын зөрүү үүсээд байгаа. Энэ зөрүүг яах гэж байгаа юм бэ гэдэг асуултыг асуумаар байна. Ялангуяа хэтэрхий их өндөр нийлүүлэлт хийгдээд яг хэрэгцээ нь яг эрэлт дээр түшиглэхгүй хэрэгцээ нь өөрөө хэт өндөр болоод энэнээс болоод дараа нь хадгалалтаас болоод чанар муудах ийм эрсдэлүүд үүсэх юм биш үү? Энэ дээр ер нь яг ямар гаргалгаа шийдлүүд хийгдээд явж байгаа юм, яагаад ийм зөрөө үүсчэв ээ гэдэг асуултыг асууя гэж бодож байна. Тэгээд хариултаа авч тодруулъя.

Б.Бейсен: 6 номерт сайд хариулъя.

Ц.Идэрбат: Мандхай гишүүний асуултад хариулъя. Мандхай гишүүн бас энэ хөдөө аж ахуйн салбарын цаашдын хөгжил, хууль, эрх зүйн орчин дээр бас маш анхаарч, нийлүүлэлт кластерын сүлжээ рүү бас маш их анхаарч ажилладаг. Энэ хөдөө аж ахуйн салбарын энэ тайлан дээр ингээд харьцуулалт хийнэ гэдэг нь туйлын зөв. Одоо яг яамны 2 газрын дарга маань сууж байна. Тэгээд дараа дараагийн тайлан бас харьцуулалттай байх нь үр дүн гарч байгаа эсэхийг дүгнэхэд маш том гарын авлага болно гэж ингэж бас харж байна.

Хөдөө аж ахуйн салбарын энэ татаасны асуудлууд байна. Би түрүүнд хэлсэн энэ олон татаас, энэ олон хөнгөлөлт энэ болгон тэгээд хаагуур яваад байгаа юм бэ гэдгийг бас маш олон иргэд, аж ахуйн нэгжүүд бас их эргэлздэг. Тийм учраас энэ ер нь төрөөс олгож байгаа энэ хөнгөлөлт, татаас энэ бүх зүйлүүдийг бид ил тод болгоё. Энийгээ яамныхаа тэр цахим хаяг юмнуудаар сонирхсон хүн болгонд ороод харчих хэмжээнд байлгая.

Нөгөө талдаа салбарын онцлог, цаг үеийн асуудлуудыг мөн зөвлөгөөн хийж биш яг энэ яамныхаа пэйж хуудсаар, албан ёсны хуудсаараа ингээд дамжуулдаг. Тэгэхээр их амьд болгоё, нээлттэй болгоё гэж ингэж бодож байгаа. Хүлэмжээ яах юм, үрээ яах юм гэхэд бүх юм нь тодорхой болгоё гэж ингэж үзэж байгаа.

Нөгөө талдаа энэ хөдөө аж ахуйн салбарын энэ татаасны асуудлууд маш их өндөр авч байна. Ямар үр дүн гарч байгаа юм тэгээд энэ дээр яах вэ бид нар хөдөө аж ахуйн салбарын жишээ нь дөнгөж саяын яригдсан энэ 200 тэрбум төгрөгийн татаасны асуудлыг хэдүүлээ ярья л даа. Тэгэхэд энэ дээр яг төрөөс өгч байгаа татаас нь 15, 6 тэрбум төгрөг л байгаа юм. Бусдыг нь арилжааны банкнууд нөөцөөсөө гаргаад тэгээд дээрээс нь эрсдэлээ үүрээд явж байгаа. Тэгэхээр энэ дээр төр оролцоод тэрэнд өг, энд өг юм байхгүй.

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

200 тэрбум төгрөг ингээд хөнгөлөлттэй зээл олгосноороо энэ 3 сая 500 мянган хүн хоолтой, ундтай байх уу үгүй юү гэдэг энэ асуудлууд одоо шийдэгдэх гол л цөм болчихоод байгаа юм. Төрөөс өгч байгаа татаас 16 тэрбум төгрөг маань өнөөдөр 1500 хүүхдийн томоохон шиг сургууль нэгийг барьж чадахгүй л мөнгө байхгүй юу. Тэгэхээр хэдүүлээ энэ хөдөө аж ахуйн салбар дээр өгч байгаа энэ татаасны задаргаа, зарцуулж байгаа хөрөнгийн асуудал дээр ингээд бас нээлттэй өгч байхгүй бол татвар төлөгчдийн мөнгөнөөс шууд 200-г аваачаад өгчихсэн юм шиг ийм ойлголт бас зарим талдаа төрөөд байгаа юм байна лээ. Төрөөд байгаа юм байна лээ.

Тэгэхээр арилжааны банкнууд 80, 90 гаруй хувийг нь гаргаж байна. Төрөөс 1 сургууль барих хэмжээний мөнгийг гаргаад тэгээд 3 сая 500 мянган хүний гурил, хоол, хүнсний ногоо энэ бүх асуудлыг шийдэж байгаа ийм том зүйл ээ гэж энийг ингэж хэлмээр байна.

Дараагийнх нь энэ хаврын тариалалттай холбоотой бордоо, ургамал хамгааллын асуудлууд байна. Тэгээд энэ асуудал дээр манай хөдөө аж ахуйн корпорац өөрийнхөө хэмжээнд, тодорхой хэмжээнд нөөцөө бүрдүүлээд ингээд явж байгаа. Үүн дээр зөрүү гарах нь ээ гэж ингэж бас үзэж байгаа учраас аж ахуйн нэгжүүд өөрсдийнхөө хөрөнгө мөнгөөр өөрсдөө зардлаа даагаад ингээд оруулчхаж. Бордоон дээр, хууль нь дээр 30 хүртэл хувийн урамшуулал олгоно гэсэн ийм зүйл байдаг юм байна лээ. Тэгээд тэр нь яг амьдрал дээр 30 хүртэл гэсэн үгнийхээ агуулгаар 3 ч байж болдог, 10 ч байж болдог, 15 ч байдаг ийм зүйл байгаа юм байна лээ. Тэгэхээр яах вэ тухайн үед тухайн жилдээ төсөв дээр хэдий хэмжээний мөнгө энэ бордооны урамшуулал тавигдсанаас шалтгаалаад хэдэн хувиар өгөх вэ гэдэг нь ингээд шийдэгдээд л ингээд явдаг юм байна лээ.

Тэгэхээр яах вэ энэ жилийн хувьд бас нэлээн анхаарлаа хандуулж байгаа нь энэ. Ойр Дорнод Дорнодын энэ нөхцөл байдал зөвхөн шатахуун биш энэ бордоо олон зүйлүүд дээр бас сөрөг нөлөө үзүүлээд байгаа учраас бид хангалттай оруулж ирэх ийм бодлого барьж сонгон шалгаруулалт гэж би ойлгосон. 3 аж ахуйн нэгж оруулж ирье гэсэн импортын зөвшөөрлөө авсан юм билээ. Тэрнийх нь хүрээнд оруулж ирээд ингээд явж байгаа. Хадгалалт, хамгаалалт тал дээр ямар ёс журамтай вэ түрээгээрээ л явах ёс.../минут дуусав./

Б.Бейсен: Мандхай гишүүн тодруулъя.

М.Мандхай: Миний хувьд хөдөө аж ахуйн салбарт олгогдож байгаа ер нь энэ төрийн дэмжлэг өөрөө үр дүнгээ өгөх ёстой гэдэг дээр хатуу зарчим барьж бас тодорхой түвшинд бас хяналт тавихыг боддог. Тийм учраас би Байнгын хорооны даргад бас хэлмээр байна, захимаар байна. Ер нь энэ төрийн дэмжлэг сүүлийн 3-5 жилийн хугацаанд яг хэчнээн аж ахуйн нэгжүүдэд яг ямар дэмжлэгүүдийг өгөөд яг нийлүүлэлтийн хэмжээнд ямар үр дүн гарсан юм бэ гэдэг дээр хэдүүлээ сонсгол хиймээр байна. Ер нь энэ дээр хэдүүлээ харах цаг болсон байх гэж бодож байна.

Хоёрдугаарт, энэ цахим дээр тавих мэдээллийг яг хэзээ биелэх вэ? Энэ бас их зөв санаачилга байна гэж харж байгаа. Гэхдээ хэдүүлээ цаг хугацаатай ярих хэрэгтэй. Хэзээ цахим дээр тавьж ил тод болох вэ гэдэг дээр сонсчихье.

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Гуравдугаарт, ер нь хөдөө аж дархан салбарын энэ мэдээлэл бид нар Улаанбаатар, хот орон нутаг гэдгээр нь ер нь ангил.../минут дуусав./

Б.Бейсен: 6 номер Мандхай гишүүн 1 минут.

М.Мандхай: Улаанбаатар, орон нутгаар нь хэдүүлээ дата мэдээллүүдээ ангилж хармаар байна. Ер нь энэ Улаанбаатар хотын өсөн нэмэгдэж байгаа хүн амыг бид нар хүнсний хангамжаар яаж хангах юм бэ? Өнөөдөр жишээлбэл цэцэрлэг, сургуулийн үдийн хоолонд зөвхөн нийслэл дээр гэхэд үдийн хоолыг бүрэн дунд, ахлах ангийн хүүхдүүдэд хоолоор хангая гэхлээр Хөдөө аж ахуйн яамны энэ хүнсний хангамжийн асуудал маш учир дутагдалтай юм байна лээ. Энэнтэй зэрэгцээд Улаанбаатар хотын энэ нэмэгдэж байгаа хүнсний хангамжид ямар бодлого баримтлах юм? Төвийн бүс болон энэ эргэн тойрон байгаа алслагдсан энэ хотыг тойрсон энэ бүсүүд дээр бид нар хөдөө аж ахуйн ямар үйлдвэрлэл явуулах юм? Энэ бүүр тусгайлсан бодлого шаардлагатай байгаад байгаа юм. Тэгээд ингээд нэгдсэн журмаар ийм яамны бодлого улс орон даяарх тоо баримт биш бид нар ер нь энэ Улаанбаатар, орон нутаг гэдэг 2 том өөр ийм бодлогын ийм ялгаатай байдлаа гаргуулж байж бид нар ажиллахгүй бол ерөөсөө болохгүй байгаад байгаа юм гэдгийг хэлэх гээд тэгээд.../минут дуусав./

Б.Бейсен: 6 номерт сайд хариулъя.

Ц.Идэрбат: Мандхай гишүүн маш чухал зүйл ярьж байна. Бид ингээд хөдөө аж ахуй гээд л ингээд л базаад л ингээд л томоор нь яваад байдаг. Гэтэл нөгөө төв суурин газар ялангуяа Улаанбаатар хотын хүнсний хангамжийн асуудлыг доголдуулахгүй байх тийм зүйлийг гаргая гэдэгтэй санал нэг байна. Зөв зүйтэй санал байна гэж ингэж үзэж байна. Сая нийслэл дээр хүүхдийн сүү өгнө гэхэд л сүүгээ барах уу барахгүй юу гээд л ингээд л асуудал үүсэж байгаа. Хоолны махны асуудал, ногооны асуудал гээд л олон хүндрэлүүд байгаа учраас энэ дээр яам бас ингээд хамтраад ажиллахад бэлэн байгаа Нийслэлтэй, Байнгын хороотойгоо.

Нөгөө талдаа саяын таны хэлдэг энэ төрөөс өгч байгаа дэмжлэг, татааснуудыг бас ил болгоод ямар үр дүн гарсан бэ гэдэг дээр бас үнэлэлт, дүгнэлт өгье гэдэгтэй бас санал байна.

Гурав дахь асуудал энэ мэдээллүүдийг ил болгох ажил руу яаралтай орж байгаа. Энэ 7 хоногоос ер нь энэ бүх мэдээллүүдийг ил болгож эхэлнэ ээ. Энэ одоо, 1 минутаа авчихъя.

Б.Бейсен: 6 номер гүйцээж яриулъя.

Ц.Идэрбат: Тийм яамны энэ сайт зөвхөн юу гэдэг юм сайд нь хэдэн зургаа хэдэн талаас нь авхуулдаг сайт биш ээ. Энэ бол мал эмнэлгийн салбар дээр жишээ нь тарилга, туулга юу явах юм, хэзээ явах юм, ямар тариа тарих гэж байгаа юм, хөнгөлөлт, урамшуулал гэхэд улаан буудай нь яах юм, сүү нь яах юм, арьс шир нь яах юм, ноос нь яах юм, авбал яаж авах юм гээд ингээд бүх зүйлүүдийг мэдээллүүдийг ил болгоно.

Энэ сайтуудаар манай энэ газрын дарга нар, ажил хариуцсан мэргэжилтнүүд тодорхой самбар гаргаж ирж байгаад самбар дээр тоотой, хугацаатай, дүрэм, журам бүх юмыг нь ил болгоно. Тийм учраас яамны хэвлэл

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

мэдээллийн энэ системийг яаман дээрээ бий болгохын төлөө Төрийн нарийн бичгийн даргадаа үүрэг өгчихсөн. Тэгээд энийг юу гэдэг юм PR гэхээсээ илүүтэйгээр PR гэж харахгүйгээр, зөвхөн сайдын зураг гэж харахгүйгээр энэ салбарын мэдээллийг ил болгох ийм том мэдээллийн суваг хэдүүлээ босгоё гэсэн ийм бэлтгэл ажилдаа ороод эхнээсээ хэрэгжиж эхэлж байгаа гэж ингэж.../минут дуусав./

Б.Бейсен: Дууссан. Та 2 удаа тодруулчихлаа шүү дээ. Гомбын Ганбаатар гишүүн асуулт асууя.

Г.Ганбаатар: Шинэ сайдад амжилт хүсье. Тэгээд ер нь яах вэ манай энэ хөдөө аж ахуйн салбар ч мал аж ахуй, газар тариалан гээд л 2 гол салбар байгаа. Мал аж ахуйн салбарт нэг үеэ бодвол бас махны экспорт, ноолуурын үнэ харьцангуй гайгүй болж байна. Одоо арьс шир түүхий эдийг боловсруулах асуудал дээр маш их анхаарч энэ манай Байнгын хороо ч гэсэн, Улсын Их Хурал ч гэсэн энэ дээр их түлхүү бодлогын дэмжлэг үзүүлэх ёстой гэж бодож явдгаа хэлье.

Хоёр дахь нь газар тариалангийн салбар байгаа. Манай газар тариалангийн салбар угаасаа бас тийм газар тариалангийн тийм таатай орчин биш шүү дээ Монгол Улс чинь. Тэр улаан буудайн урамшуулал гээд олгоод байгаа чинь тэнд гарч байгаа шатахуун, зардал, тос, тоног төхөөрөмж тэр бүгдийг л бодож л төрөөс олгож байгаа хэлбэр.

Гэхдээ энэ цаг үе арай өөр болж байна. Бас дэлхий даяараа энэ улс орнуудын хооронд хэрэгцээ бий болсон. Ялангуяа манай улсад таримлын шинэ төрлийг бодлогоор дэмжиж экспортод гаргавал аж ахуйн нэгж хөдөө аж ахуйн газар тариалангийн салбар арай их дэмжлэг болох юм даа гэж хувь хүнийхээ хувьд бодож явдаг юм. Тэгээд энэ чиглэлээр энэ 2 салбар дээр малын гаралтай түүхий эд боловсруулах чиглэлээр яг бодлогынхоо хувьд Байнгын хорооноосоо ямар дэмжлэг авч ажиллахаар байгаагаа, дээрээс нь тэр таримлын нэр төрлийг олшруулах чиглэлээр ямар бодлого баримтлахыгаа та бас энэ дээр ярьж өгвөл сайн байна.

Бас нэг асуудал бол энэ хөдөөгийн залуу малчдын асуудал байгаа. Ер нь малчингүй боллоо Монгол орон. Хоёр дахь нь ингээд 6 настай хүүхэд сургуульд сууж байгаа асуудал чинь ингээд хөдөө мал маллах хүнгүй боллоо. Тэр ганц бие залуу зайлуул бие эрүүл мэнд ч үгүй болж байна. Энэ чиглэлээр ямар бодлого барихыг чинь бас сонсмоор байна? Тэр нөөцийн мах харин яам бэлдэхгүй байгаад нь би их талархаж байгаа. Нийслэл бэлдэж байгаа боловч сая харин үгүй ээ энэ гэрээ хийж байгаа бол намар тэр үнэтэй, боломжтой гэж гэрээ хийж байгаа. Махны үнэ өсөнгүүт дагаад өсдөгийг ер зөвшөөрч болохгүй. Ер нь нөөцийн мах буруу зүйл. Би угаасаа энэ төрөөс энэ хувийн өмчид халдаж байгаа хэлбэр шүү дээ. Энэ үнэд оролцоно гэдэг чинь. Энийг ерөөсөө дэмждэггүй. Гэхдээ нэгэнт гэрээ байгуулсан бол тэр Нийслэл дээр энэ их буруу зүйл шүү гэдгийг хэлье.

Бас нэг асуулт нь Засгийн газрын энэ оны 3 дугаар сарын 25-ны хуралдаанаар өөрт чинь болоод Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд хаврын тариалалттай холбоотой 10 мянган тонн түлшийг 3400-гаар нийлүүлэх асуудал та нарт даалгавар өгсөн байгаа. Яг бодит амьдрал дээр хөдөө аж ахуйн бирж зар тавиад 15 хүртэл авна гэсэн боловч 5 хоногийн өмнөөс бүртгэлээ зогсоосон. Би өөрөө мэдэж байна. Бүүр би сонирхоод асууж үзсэн юм. Тариаланчдаас ялангуяа

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Булган аймгийн Тэшиг сумын тариаланчдаас надад бүүр хүсэлт ирсэн. Бас яагаад вэ гэхлээр ба газар тариалангийн салбарт сүүлийн 10-аад жил ажиллаж байгаа хүний хувьд бас энэ жаргал зовлонг мэдэх хүн гэж хандсан юм шиг байгаа юм. Эрдэнэбат тэргүүтэй тариаланчдаас. Үндсэндээ 5 хоногийн өмнө юу нь зогсчихсон. Тэгээд энэ дээрээ ямар бодлого баримт.../минут дуусав./

Б.Бейсен: 6 номер хариулъя. Мөнхсоёл гишүүний нэрийг оруулчхаарай асуулт асууна гэж. Сайд.

Ц.Идэрбат: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Ганбаатар гишүүний хувьд яг намайг сайдын томилогддог тэр орой бол энэ ургамлын экспортын асуудал дээр ер нь ямар бодлоготой байгаа вэ гэж ингэж асууж байсан. Тэгээд Монгол Улсын Их Хурал 2024 оны 6 сард энэ Ургамал хамгаалал, ургамлын эрүүл мэндийн тухай хуулийг баталж, анх удаа Ургамлын хамгааллын газар гэдэг агентлагийг шинээр байгуулсан.

Үүний зорилго бол яг Ганбаатар гишүүний хэлж байгаа энэ ургамлын экспортыг дэмжихэд 2 улсын засгийн газруудын хоорондын хэлэлцээр тэр олон улсын стандарт юмнуудыг нийцүүлэхэд яг ийм статустай байгууллага Монголд байхгүйгээс болоод ургамлын экспорт явахгүй байна гэдэг ийм агуулгаар батлагдаж, тухайн үед ажлын хэсэг Наранбаатар гишүүн ахалж бие биеийн хувьд бас дотор нь орж ажиллаж байсан. Тэгээд дэмжиж байгуулж байсан сайдын ажлыг авсны маргааш нь энэ Дарханы энэ Ургамал хамгааллын газар очиж ажилласан.

Ер нь сайдын хувьд энэ хөдөө аж ахуйн хөгжлийг бид экспорт руу чиглүүлэхээс дотоодын нөөцөө хангалаа гэдэг ийм зорилго тавиад тэрэндээ хүрэхийн төлөө ажиллаад явахгүй ээ. Тийм учраас энэ махны экспорт, ургамлын экспорт, энэ Цагаан алтын экспорт, Евроазийн гээд энэ 4 рүүгээ ер нь цогцоор нь анхаарна гээд ажлын хэсэг гаргаад ажиллаж байгаа.

Ургамал хамгааллын газар дээр ингээд яваад очихоор одоогоор 15, 6 стандартыг орчуулаад Монгол руугаа хөрвүүлээд Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу 8 нэр төрлийн ургамлыг протоколоор хэлэлцье ээ гэдэг ийм хүсэлтээ явуулчихсан байгаа. Тэгэхээр сая яаман дээр байгуулагдаж байгаа одоо энэ газар тариалангийн газрын даргаар ажиллаж байгаа Есөн-Эрдэнээр ахлуулсан энэ ажлын хэсэг бол тэр явуулсан 8 нэр төрлийн ургамлаа цааш нь борлуулах энэ асуудал руугаа эрхээ авах, борлуулах үүд хаалгаа нээх та тал дээр онцгой анхаарч ажиллах ийм чиг үүрэгтэй байгаа. Нэг утгаараа сая 5 сарын 8-нд бид нар махны экспортыг нэмэгдүүлэх талаар юу хийж байгаа шиг 8 сарын 10-даар яг энэ ургамлын экспортыг нэмэгдүүлэхэд яамны зүгээс юу хийв ямар бололцоо бүрдүүлэв гэдгээ газар тариалан эрхлэгч нартаа бид танилцуулах гэж байгаа.

Мөн манайд нөгөө талаас маань ямар шаардлагууд тавиад байдаг юм бэ гэдгийг нь бас газар тариалангийнхандаа танилцуулаад ингээд экспортод гаргах улсынхаа шаардлагад нийцсэн тариалалтыг 2027 оны хавраас эхлүүлэе ээ гэсэн ийм бодолтой. Тэгээд хавар болтол нөгөө борлуулах схем, санхүү мөнгө, бүх зүйлүүдээ манай тариаланчид бэлтгэх ийм л бололцоо олгохоор ингэж байгаа.

Тэгэхээр ер нь цаашдаа Монгол Улсын газар тариаланг хөгжүүлэе гэвэл экспорт чиглэнэ ээ гэсэн энэ зүйлийг Дарханд газар тариалангийнхантай уулзахдаа бас хэлсэн. Энийг манай тариалангийнхан маш дэмжиж байгаа.

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Өчигдөр Монголын үндэсний тариаланчдын холбооныхонтой бас төлөөллүүдтэй нь уулзалт хийсэн. Экспорт руу чиглэж байж бид хөгжил ярина. Тэгэхгүйгээр улаан буудай ахиухан тарчих юм бол хаана хийхээ мэдэхээ больдог. Бага тарьчихаар үнэ өсдөг гээд ингээд маш их зовлон ярьж байгаа. Тийм учраас энэ ургамлын юу руу маш сайн анхаарна.

Залуу малчдын асуудал дээр би ер нь түрүүнд хэлсэн залуу малчдыг хөгжүүлэе гээд ингээд янз янзын зээл өгөөд ингээд үзсэн. Тэгээд бас яг хөгжихгүй байна. Яг хөгжихгүй байгаа шалтгаан бол мал аж ахуйн бараа, бүтээгдэхүүний үнэ асар бага байгаагаас, малчдын орлого бага байгаагаас энэ залуу малчдын залгамж халаа бас ер нь алдагдах гээд байна гэж яг суурь шалтгаан болно. Үүнийгээ шийдэх юм бол олон залуучууд малаа яаж залахаа хэнээр ч.../минут дуусав./

Б.Бейсен: Сайд гүйцээж яриулья.

Ц.Идэрбат: Тийм одоо ингээд зөвхөн ноолуурын үнэ биш бид ноосон дээр, арьс ширэн дээр, тэгээд махны экспорт энэ бүх зүйлүүдээ хөдөлгөөд эдийн засгийн хувьд малчин хүн хөдөлмөрлөх тэр хүнд хөдөлмөр хийснийхээ хэрээр орлого олдог ийм систем рүү орчихвол олон залуу малчид бас би мал дээрээ гарах болов уу гэж ингэж бас боддог.

10 мянган тонн шатахууны асуудал дээр хөдөө аж ахуйн яам бол өөрийн хүлээсэн санхүүгийнхээ асуудлыг бүрэн шийдвэрлэсэн. Импортлогч компаниуд хэлсэн, ярьснаасаа буцаж байгаа, хагас дутуу өгч байгаа олон хүндрэлүүд бид байгаа. Тэгээд тэр болгоныг бид ярихгүй байгаа. Үүргээ биелүүлж байгаа маш сайн импортлогч нар бас байгаа байгаа. Сая та бол Булган аймгийг жишээ татаж ярилаа. Булган аймгийн хувьд 560 орчим тонн шатахууныг 55 аж ахуйн нэгж авсан байна. Эндээс би ер нь олон зүйлийг харж байгаа. Монгол Улсын хэмжээнд бүртгэлтэй 1500-аад, 1600-аад аж ахуйн нэгж. Ногоочид гэвэл 16 мянга байна. Тэгээд зарим нь аваад учир шалтгаанаар.../минут дуусав./

Б.Бейсен: Ганбаатар гишүүн тодруулья.

Г.Ганбаатар: Үгүй ээ яах вэ энэ ийм л юм байна лээ л дээ. Манай улс чинь би андуураагүй бол сая гаран га эргэлтийн талбайтай байдаг байх. Тэгээд та нар ингээд автоматаар 1 га-г нь 10 литр гэж бодоод 10 мянган тонн гээд л бодчихсон юм уу? Энэ чинь эргэлтийн талбай чинь бас өөр шүү дээ. Нөгөө талдаа яг ингэж зарлачхаад тэр Хөдөө аж ахуйн корпорац гээд нөхдүүд чинь 15-ыг хүртэл авна гэххээд тэгэнгүүтээ ерөөсөө бүртгэлээ 5 хоногийн өмнө хаачихсан байхгүй юу. Хэрвээ тэр Я.Отгонбаатар гээд 98111456, Х.Болортуяа гээд 99864277 би зүгээр сонирхоод ярьж үзсэн юм. Тэгэхэд нээрээ хаачихсан байгаа байхгүй юу. Манайх бүртгэл авахгүй гээд.

Гэтэл та нарын энд яриад байгаа чинь өөр. Засгийн газраас та нарт даалгавар чиглэл өгчихсөн байдаг. Уг нь 15 хоног байдаг 9 хоног үлдлээ гээд сүртэй сүртэй юм яриад байсан чинь одоо ингээд байхгүй болчхож байгаа байхгүй юу. Яг 50 хувьдаа хүрсэн юм уу үгүй юм уу? Энийг хэтдээ ер нь яг бодитой үр дүнг нь яаж хэмжих юм бэ л гэж асуугаад байхгүй юу.

Б.Бейсен: 6 номер сайд хариулья.

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Ц.Идэрбат: Нефть хангамжийн асуудал дээр 7 мянга гарчихсан явж байгаа. Авч чадсан, чадаагүй гээд ингээд шалтгаан яривал бас дотор нь зөндөө л юм байдаг бололтой юм билээ. Гэхдээ ямар ч байсан газар зүйн байрлалын хувьд энэ ногоочдодоо, тариаланчдадаа, зүүн бүсийнх нь хаанаас авах вэ, баруун бүс нь хаанаас авах вэ, төвийн бүс нь хаанаас авах вэ гээд учир шалтгаануудыг нь нэлээн ингээд тайлбарлаад ингээд явж байгаа. Энэ хэлсэн ярьсандаа байхгүй байгаа энэ аж ахуйн нэгжүүдийн нэр усыг бид нар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд хүргүүлж байгаа. Тэд шахаж ажиллаж байгаа.

Гэхдээ цаана нь тэгээд бас яг үнэндээ гаднаас орж ирж байгаа л ийм зүйл шүү дээ. Харин зүгээр дотооддоо татчихаад дараад байна уу үгүй юу гэдэг дээр Эрдэс баялгийн яам маргаашийн Засгийн газрын хуралдаан дээр энэ тал дээр бас энэ импортлогч компаниудын асуудлыг ярина. Манай яамны зүгээс санхүүжилтийг нь бүрэн шийдсэн. 23 аж ахуйн нэгж санамж бичигт гарын үсэг зурснаас одоогийн байдлаар 16, 7 нь өгчихсөн байгаа. 15 гэдэг хугацааг бид эд нараасаа авч чадвал сунгаж.../минут дуусав./

Б.Бейсен: Мөнхсоёл гишүүн асуулт асууя.

Б.Мөнхсоёл: Өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр иргэд олон нийтийн асууж байгаа бас эдийн засагчид бидний санаа зовж байгаа нэг зүйл байна. Энэ инфляцын хэрэглээний үнийн индекс маш их ийм том байр суурь эзэлдэг махны үнийн асуудал байна. Өнгөрсөн 25 оны 10 сарын 20 гэхэд үхрийн ястай мах жишээлбэл килограмм нь 20 мянга гаран төгрөгтэй байсан бол өнөөдөр даруй үнэ нь 5 сарын хугацааны дараа 32 мянга гаран төгрөг болоод 52.6 хувиар өсчихсөн байна. Бусад ямааны мах ч гэдэг юм уу, хонины мах ч гэдэг юм уу бүгд үнэ өсчихсөн. Тэгэхээр энэ тал дээр юу бодож байна аа? Өчнөөн олон сая малтай гээд байдаг, малын тоогоороо алдаршаад байдаг. Гэтэл хот суурин газраа бид нар энэ малынхаа, махныхаа эрэлтийг хангаж чадахгүй байгаад байна. Энэ дээр юу ямар бодлого хэрэгжүүлэх гэж байна?

Хоёрдугаар асуудал нь болохоор зөвхөн хөлдөөсөн махаар бас хот сууринд амьдарч байгаа иргэдээ хангахад боломжгүй, амтгүй ийм хатсан юм шиг тийм мах байгаад байна. Шинэ технологи оруулж ирэх тэр дээр нь бодлогын түвшин дэмжих ийм боломж байна уу? Энэ 2 чухал асуудлыг асуучихъя.

Б.Бейсен: 6 номер сайд яриулъя.

Ц.Идэрбат: Хөдөө аж ахуйн сайдын яамны үүрэг бол, үүрэг бол энэ малчинтай байх, махтай байх, хоол ундтай байх энэ талын л зохицуулалтын асуудал байгаа гэж би танд хэлье. Нэгдүгээрт нөөцийн махны асуудал бол яамны асуудал биш Нийслэлийн асуудал болоод 3 жил болж байгаа. 3 жил болж байгаа. Улаанбаатар хотын хувьд нөөцийн махны нийлүүлэлт дээр зах зээл дээр гаргаагүй байсан 3 мянган шахуу тонн махаа түгээлтийг нь цэгийг нь нэмэгдүүлэх арга хэмжээг Нийслэлээс цогц хэмжээгээр арга хэмжээ авч байгаа.

Таны хэлсэн амттай шинэ ийм махыг нийслэлийн эргэн тойронд энэ хувийн фермерүүд бэлтгээд намраас хойш тэр ариун цэврийн тэр эрүүл ахуйн шаардлага юмыг нь хангуулаад ингээд зах зээлд нийлүүлээд ингээд явж байгаа. Тэгэхээр энэ нөгөө махны фермерийн аж ахуйг Хөдөө аж ахуйн яамнаас энэ хөнгөлөлттэй зээл

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

олон талаар дэмжлэг үзүүлээд үеэ бодвол бас ч гэж сэргэлт үзүүлээд ингээд явж байгаа гэж би танд товчхон хариулъя. Баярлалаа.

Б.Бейсен: Сонгобайн Замира гишүүн асуулт асууя.

С.Замира: Баярлалаа. Шинээр томилогдсон сайддаа ажлын амжилт хүсье. Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе ээ. Хэдэн асуулт байна. Манай улсын хувьд газар тариалан, мал аж ахуйн тогтвортой хөгжүүлэх асуудал хур бороотой холбоотой. Тэгэхээр манай улс ер нь зундаа бороо орохгүй бол өвөлдөө, намартаа тэгээд гай гамшиг тохиолдож байна. Асуудал хүндэрлээ гэж 36 жил яваад ирсэн. Бид нар Киргизстан, Тажикстан гээд улс орнууддаа очоод үзэхэд тэр улсууд 40-50 градусын халуунтай юм байна лээ зундаа. Тэгэхдээ зун ямар ч бороо хур ордоггүй.

Гэвч энэ улсууд газар тариалангийн асуудал, мал аж ахуйгаа яаж шийдэж байна гэхээр нь усны суваг татдаг юм байна, шланг хэрэглэдэг юм байна түрүүгээрээ тэгээд тогтвортой үйл ажиллагаагаа жигдрүүлсэн мал аж ахуйн энэ асуудлыг ч газар тариалан ингээд асуудлыг ч ямар ч бэрхшээлгүй ингээд шийдвэрлэсэн байна. Манай улс энийг судлаад энийг хэрэгжүүлэх боломж байна уу нэгдүгээрт?

Хоёрдугаарт, баруун бүс газар тариалан хөгжөөгүй байгаа. Заавал эндээс төвөөс гурил татах шаардлагатай байдаг. Тухайн үед энэ асуудлыг Их Хуралд асуудал болгож Жангабыл гишүүн тэргүүтэй баг бид нар бүгдээрээ гарын үсэг зураад гаалийн гурил, хивгийн гаалийн татварыг тэглэхсэн байгаа юм. Тэр хугацаа нь 4 сар гэхэд болж байгаа байх. Тийм учраас одоогоор яг баруун бүсийн газар тариалан хөгжүүлэх одоохондоо боломж байхгүй юм чинь энэ гаалийн татварыг тэглэсэн хэвээрээ дахиад өргөжүүлэх боломж байна уу?

Тэгээд мал аж ахуйн салбарт эмч, зоотехникч, техник хүрэлцээ муутай гэж. Бид нар бар энийг газар дээр нь очоод танилцахад тэгж танилцуулж байсан. Энд ямар арга хэмжээ авагдсан байна? Шийдэгдсэн юм байна уу? Манай малын махыг эрүүлжүүлэх, газрын хөрсийг эрүүлжүүлэхийн төлөө бид нар вакцин, газрын бордоо гээд тэгээд хорхой, шавж устгах бодис гээд ер нь ханаас нь нийлүүлж байгаа, нэгдсэн нэг бодлого байна уу?

Малын арьс ширний асуудал ингээд яриад байдаг, хурал болгонд яриад байдаг ер нь шийдэгдсэн асуудал байхгүй юм байна. Итали улсын бизнесменүүд Дархан хотод хүсэлт ирүүлчихсэн байна. Хамтран ажиллах, арьс шир, мал аж ахуйн түүхий эдийн чиглэлээр. Энд хариу хүлээгээд байна гэсэн юу.../минут дуусав./

Б.Бейсен: Замира гишүүнд 1 минут.

С.Замира: Элчин нь бид нар уулзалт хийхэд ярьж байсан. Тийм учраас тэр ер нь тэр тал дээр ер нь Дарханы үйлдвэр шийдвэрлэсэн, дэвшүүлэн саналаа хүргүүлсэн юм байна уу? Байхгүй бол заавал Дархан гээд хараад суух шаардлага байхгүй тийм Итали мэтийн Турк ч байна. Арьс ширээр дагнаад дэлхий дээр экспортод гаргаж байгаа улсуудтай нийлээд хөрөнгө оруулалт татаад энэ арьсыг яаралтай ашиглахгүй бол хайран долларын юм бол энэ бараг газарт хаягдаад байгаа шүү. Иймэрхүү асуудалд хариу авъя. Дараа нь тодруулна.

Б.Бейсен: 6 номер сайд яриулья.

Ц.Идэрбат: Замира гишүүнтэй тэр арьс ширний холбогдолтой асуудал дээр санал нэг байна. Зүгээр би бас орон нутагт ажиллаж байгаад сумын дарга байхдаа бас баахан арьс л газар булж ирсэн хүн шүү дээ. Харахад харамсмаар, халагламаар юм байдаг юм. Тэгээд энэ юм чинь 10-аад жил явлаа зүгээр миний энэ Их Хуралд ирээд авсан мэдээллийн дагуу ингээд судлаад үзэхэд бид нар 100 гаруй сая арьсаа энэ олон жилийн хугацаанд булжээ. Энэ мөнгөөр үржүүлбэл хэчнээн юм болох вэ. Тийм учраас энэ арьс ширний асуудал дээр бид нар энэ миний хэлээд байгаа тэр яг өнөөдөр бодитой явж байгаа нь тэр Дорноговь, Чойр дээр байгаа, дээрээс нь Эмээлт хамгийн сайн байна. Өвөрхангай дээр явж байгаа энэ 1 сая арьс боловсруулах энэ үйлдвэрийнхээ асуудлыг бид дэмжээд явж байгаа.

Тэгэхээр цаашдаа энэ Цагаан алт хөтөлбөрийн хүрээнд арьс, шир боловсруулахаасаа гадна арьс ширэн бүтээгдэхүүн хийдэг маш олон аж ахуйн нэгжүүд нэмэгдсэн байна. Өчигдөр бас уулзлаа. Энэ уулзалтаар Ерөнхийлөгчтэй цуг уулзсан уулзалт дээр гутал хийж байгаа тэгээд нөгөө үйлдвэрлэлийнхээ дамжлага, замаа нэмж байгаа, хүчин чадлаа нэмж байгаа гээд. Тэгээд бид нар ирэх 7 хоногт энэ Ноос, ноолуурын мэргэжлийн холбоо, Арьс, ширний холбоо гээд олон холбоонуудтай уулзах ажлыг зохион байгуулах гэж байна. Тэгээд хамтдаа одоо яг цаашдаа бид яаж явах юм бэ гэдэг дээр замын зураг гаргая гэж.

Тэгэхээр Монголд маань ийм аж ахуйн нэгжүүд олон байгаа. Тэгээд энэ гаднын аж ахуйн нэгжүүд орж ирэх бүрэн дүүрэн бололцоо юмнууд нь нээлттэй байгаа гэж ингэж хэлье. Тэр бордоо, ургамал хамгааллын бодистой холбоотой асуудал дээр ер нь хэдий хэрийн юм оруулах юм, яаж оруулах юм гэдэг дээр тэр Пестицийн зөвлөл гэж эрдэмтдийн зөвлөл байдаг юм. Үүнтэй уялдуулаад тэндээс гарсан саналыг Эрүүл мэндийн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн, Хүнс, хөдөө аж ахуйн сайд гэсэн 3 сайдын хамтарсан тушаалаар батлагддаг юм байна. Тэгээд ямар улсаас яаж орж ирэх вэ гэдгийг тэндээс саналуудыг нь аваад шийдээд ингээд явдаг юм байна.

Одоогоор манайд Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас орж ирсэн түлхүү энэ ургамал хамгааллын бодис, бордоонууд орж ирж байгаа. Энэ хөдөө аж ахуйн салбарын энэ боловсон хүчний асуудал байна. Үнэхээр манай дээр олон хүндрэлтэй зүйлүүд байгаа. Боловсон хүчин тэр дундаа энэ яг мал аж ахуйн дээр олон зүйлүүд үүсэж байгаагийн нэг нь энэ зоо техникч энэ үржил селекцийн асуудлууд бас хаягдаж байгаа. Үүнээсээ болоод малын чанар муудаж байгаа, үүнээсээ буруу ойлголттойгоос болоод нөгөө ноолуурын маань чанар, ноосны чанар гээд олон юмнуудад сөрөг нөлөө үзүүлэх учраас энэ Хөдөө аж ахуйн сургууль дээр энэ манай салбарт дутагдаад байгаа мэргэжилтнүүдийг бэлтгэх ажиллагааг уул нь бас явуулсан. Тэгээд харамсалтай нь бас тийм өндөр хүлээлтэд хүрэхгүй улсын хэмжээнд 40 хэдхэн хүүхэд ирээд сурч байна гэдэг бас жоохон харамсалтай тоо. Тэгээд бид бас энэ рүүгээ анхааръя гэдэг дээр яамны бид ингээд ярьж байгаа.

Энэ газар тариалангийн эрсдэл, цаашдын хөгжил гээд ингээд ярих юм бол зөвхөн байгаль цаг уураас хамааралтайгаар бид цаашаа явахгүй юм байна. Тийм учраас энэ газар тариалангийн байгаль цаг уурын эрсдэлийг даван туулахын тулд

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

төрөөс нэгдүгээрт тэр үүлэнд зориудаар нөлөөлөх энэ процессыг хийе ээ, бэлтгэлээ хангая. Энэ дээр орон нутгийн удирдлагууд бас идэвх санаачилгатай ажиллах хэрэгтэй.

Нөгөө талдаа өнөөдөр ингээд 16 цагаас яг энэ усалгааны систем, усалгааны газар тариаланг хөгжүүлэх тал дээр шинэ инновац нэвтрүүлсэн гэж өөрсдийгөө танилцуулж байгаа. Мөн дээрээс нь одоо байгаа зах зээлийн ханшаас бас харьцангуй хямд байгаа гэж танилцуулж байгаа энэ аж ахуйн нэгжүүдтэй яам дээр уулзалт зохион байгуулах гэж байгаа. Хэрвээ энэ нь манай Монголын газар тариалангийн компаниудын хувьд санхүүгийн хувьд боломжтой, технологийн хувьд боломжтой ийм байх юм бол бид ган боллоо гэж айхгүйгээр тариалангаа хөгжүүлээд явах бололцоо бас бүрдэнэ. Тэгэхээр энэ талаар манай энэ салбарынхан судалдаг. Гэхдээ бас төр энд нь тодорхой хэмжээнд дэмжлэг.../минут дуусав./

Б.Бейсен: Замира гишүүн тодруулъя.

С.Замира: Энэ жилийн хувьд баруун бүсийн энэ газар тариалан нь хөгжих боломжгүй гээд харж байна л даа. Тэгэхээр энэ гаалийн татвар тэглэсэн асуудлыг яаж шийдье гэж бодож байна? Яагаад гэвэл энэ 2000 км, 1800 км газраас гурил зөөхөд маш үнэтэй очиж байгаа байхгүй юу баруун бүсэд. Тийм учраас хэрвээ Монгол орон гурил үнэхээр хангалттай гарах юм бол экспортод гаргаж болно ойрхон газарт. Тэгээд тэндээс ойрхон газраас гурил, будааг оруулж ирж болно. Ийм зохицуулалт хийх үү гэж?

Б.Бейсен: 6 номер сайд хариулъя.

Ц.Идэрбат: Гаалийн татвартай холбоотой асуудал дээр түрүүчийн танилцуулга дээр бас гарсан баруун бүсэд гурил, тэжээлийн үнийг бас тогтвортой байлгах хэмжээнд цаг үеийн хүндрэлтэй холбогдуулаад тэглэх асуудлууд хөндөгдөөд ингээд явсан. Үүний үр дүнд 23 мянган тонн гурил орж ирэхээс одоогоор 12 мянган тонн л орж ирээд байна. 4 сарын 5-наас 7 сарын 5 хүртэл энэ 5 хувийн татвартай орж ирнэ. Ер нь цаашдаа энэ баруун бүсийн газар тариалангийн хөгжлийн асуудал дээр би баруун бүсийн тариаланчдын зөвлөгөөн дээр цахимаар оролцож тодорхой саналуудаа хэлсэн. Тэнд усалгаатай газар тариалан тэнд элеватор, тэнд хувийн хэвшлийнхэн гурилын үйлдвэр барих судалгаа юмнууд бас хийгдээд явж байгаа юм билээ.

Тэгэхээр энийг бид нар хамтраад шуурхайлан хийчихвэл заавал гаднаас гурил авна, гаалийн татвараа оролдоно гэх ийм шалтгаан бас би үүсэхгүй болов уу. Тэгвэл гурилын үйлдвэртэй больё л гэдэг зүйлийг та бүхэн маань ярьдаг шүү дээ. Тэгэхээр тэр талын асуудлууд бас шийдэгдэнэ гэж бодож байна.

Б.Бейсен: Ганхүлэг гишүүн асуулт асууя.

М.Ганхүлэг: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Шинэ сайддаа бас ажлын амжилт хүсье ээ. Бас ажлаа аваад эхлүүлээд ажиллаж байгаа бас олон ажлууд бас нэлээн бас тодорхой нээлттэй байгаад их баяртай байгаагаа илэрхийлье.

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Ялангуяа бас зөвлөхөөрөө бас туршлагатай өмнө нь бас сайдаар ажиллаж байсан хүнийг би авсанд харин эсрэгээрээ их баяртай байгаа. Тэгээд шинэ сайд болоод л нөгөө танилцаж ядсаар байтал дараагийн бас ингээд л холио, сэлгээ нь ингээд бий болдог. Тэгээд энэ яваад салбарын бодлого энэ салбарт байгаа хүмүүст эсрэгээрээ асар ийм хохирлыг бас авчирдаг. Тийм учраас бас таны хувьд бас танилцаад өмнө нь бас янз янзын ийм байдлууд гаргаад байхгүйгээр шууд бас үргэлжлүүлээд ажиллах энэ боломж бололцоо бас нээгдэж байна гэж ингэж харж байна. Тэгээд энэ хөдөө аж ахуйн агрономич мэргэжилтэй энэ салбарын бас туршлагатай хүнийг бас зөвлөхөөрөө авсанд би хувьдаа их талархалтай байгаа гэдгээ хэлчихье ээ.

Тэгээд ажил эхэлж байгаа учраас нэг зүйлийг л бас яах вэ олон бас зорилт, саналуудын тухай хэд хэдүүлээ бас ярилцаж байна. Гэхдээ ер нь энэ хөдөө аж ахуйн салбарын ойлгомжгүй байгаа ил тод биш байгаа энэ асуудлууд дээр нээлттэй байх дээр л номер нэгд та бас анхаараарай, анхаарч ажиллана гэж бас хэлж байх шиг байна. Энэ бол манай салбарын хувьд бас хийж болохоор бас дутагдалтай байгаа их чухал асуудлуудын маань нэг шүү. Тэгээд энийг бас би хамгийн нэн тэргүүнд ажиллая. Хөдөө аж ахуйн салбарт явж байгаа бүх асуудлууд нээлттэй ил тод болсноороо бодлого, үйл ажиллагаанууд бас тодорхой энэ салбарынхандаа бас нэлээн нээлттэй хүрэх энэ үндэс болно. Тэгээд энэ дээр нэн тэргүүнд анхаараарай гэдгийг бас захиж хэлье ээ.

Байнгын хороогоор өвөлжилтийн нөхцөл байдлын хариу арга хэмжээ, хаврын энэ бэлтгэл ажилтай холбогдолтой чухал асуудал орж ирж байна. Тийм учраас би хэд хэдэн бас тодорхой асуултыг асууя. Дорнод, Сүхбаатар аймаг, мөн бас нэлээдгүй газруудаар бас өвөлжилт нэлээн хүндэрсэн. Ялангуяа манай Халх гол Чулуунхороот, Дашбалбар, Чойбалсан, Гурванзагал гээд ингээд Дорнодын хэд хэдэн сумууд, мөн Сүхбаатарын хэдэн сумууд байгаа. Энэ дээр гарз, хохирол түүнтэй холбогдолтой хариу арга хэмжээн дээр бас тодорхой бодлогууд бас ямар байдлаар хийгдэж байна вэ гэдэг эхний асуултыг асууя. Тэгээд шаардлагатай бол бас энэ дээр анхаарч ажиллаасай гэдэг энэ саналыг бас хэлж байгаа юм.

Хоёр дахь нь газар тариалангийн салбарын бэлтгэл ажлууд бас нэлээн оройтож байна. Шатахуун дээр тодорхой арга хэмжээ авч байгаа юм байна. Бордоо болон үр үр дээр бас ямаршуу асуудлуудыг бас байна вэ гэдгийг ил дахиад тодотгоод өгөөч ээ. Энэ улсаас олгогдож байгаа энэ тодорхой урамшуулал маань тодорхой хэрэгцээтэй нэр төрлүүд дээр, тариалангийн нэр төрлүүд дээр арай ийм бас ялгавартай байдлаар зохицуулалтууд хийгдэж байна уу? Эс үгүй бол яг л нийтлэгээр нь асуудлуудыг авч үзэж байна уу? Экспортын чиг баримжаатай Монгол Улсын импортыг бас орлох энд тариалангийн бас нэр төрлүүдийг нэмэгдүүлэх чиглэл рүү энэхүү бас урамшууллуудаа чиглүүлэх энэ тал руугаа бид бас.../минут дуусав./

Б.Бейсен: 6 номер сайд хариулъя.

Ц.Идэрбат: Өвөлжилт бас зарим газруудад хүндэрсэн. Сая ялангуяа манай Ганхүлэг гишүүний хэлж байгаа сумуудад хүндэрсэн ийм бодит байдлууд үүссэн, гэнэтийн гамшиг осол манай Дорнод аймгийн Халх гол суманд бас тохиолдсон. Үүн дээр холбогдох яам Улсын онцгүй комисс анхаарлаа хандуулж, энэ улсын нөөцөө сая энэ тайлан дээр дурдагдсан төсөл, хөтөлбөрөөс олгож байгаа энэ зээл, хөнгөлөлттэй тэжээл, өвс гээд олон зүйлүүд бас тийшээ хүргэгдсэн гэдгийг

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

бас хэлье. Өчигдөр гэхэд туулах чадвар сайтай машинаас авхуулаад Шадар сайдаас ингээд шийдээд ингээд явж байгаа гэх мэтчилнээр ингээд шийдэгдээд явж байгаа.

Тэр нээлттэй байх гэдэг өөрөө туйлын чухал. Маш олон хардлага сэрдлэг явдаг тийм байгаа. Нөгөө талаасаа яамны хувьд нээлттэй байхаасаа гадна энэ салбарын тэр хөнгөлөлт, тусламж, дэмжлэг, татаас бүх зүйлүүдийг өгөхөд янз янзын шаардлагагүй олон шат дамжлагуудыг цөөлье, шуурхай олгодог болъё гэдэг ийм чиглэлээрээ тэгээд маргааш бол Монгол Улсын Засгийн газрын хуралдаанд тодорхой асуудлуудыг оруулах гэж байна. Тэгээд Монгол Улсын Ерөнхий сайд энэ чөлөөлье санаачилгын хүрээнд ялангуяа бизнесийн орчинд тээг саад болж байгаа олон зүйлүүдийг бас чөлөөлье гэдэг ийм зүйлүүдийг бас ярьж байгаа. Тэрний хүрээнд бид бас яамны зүгээс нэлээн асуудлуудаа бас оруулж байгаа.

Үр, бордооны хувьд энэ Ойрх Дорнодод үүсээд байгаа нөхцөл байдал чинь зөвхөн шатахуун биш, ялангуяа энэ бордоо, энэ газар тариалангийн салбарт хэрэгцээтэй байгаа химийн бүтээгдэхүүнүүдтэй холбоотой хүндрэлүүд ингээд үүсэх ийм учраас энэ Хөдөө аж ахуйн корпорац, дээрээс нь хувийн хэвшил олон талаасаа ингээд дэмжиж байгаад энэ жилийн хаврын тариалалтын энэ бордоо, энэ ургамал хамгааллын, зун хэрэг болох ургамал хамгааллын бодис юмнуудын хангалт хангалттай сайн хийгдээд байгаа. Эх үүсвэр нь сая Оросын Холбооны Улс, ер нь бордоо талаа Оросын Холбооны Улс. Ургамал хамгаалал талаа бол дийлэнх нь Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс байгаа.

Энэ татаас, дэмжлэгүүд бол яг үнэндээ хаврын тариалалт, хүнсний ногоо, хоол, улаан буудай ийшийгээ л чиглэгдэж байгаа. Ганбаатар гишүүний хэлдэг, таны хэлж байгаа энэ нөгөө ургамлын экспорт руу чиглэсэн тийм хөнгөлөлт байхгүй байгаа. Бид энэ орон зайг юугаар нөхөх вэ гэхээр төр олон улсын, хоёр улсын Засгийн газрын хоорондын хэлэлцээрүүдийг шуурхай явуулах, протокол юмнуудаа хурдлах, ингээд тохиролцоонд хүрсний ард дээр тухайн улсын аж ахуйн нэгжүүдийг Монгол Улсынхаа газар тариалангийн аж ахуйн нэгжүүдтэй холбох гээд ингээд ийм төрийн өөрийнхөө үндсэн чиг үүргийн ажлуудаа хийгээд явна гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа гэдгийг хэлье.

Одоогоор 8 ургамлын төрлийг Монголд ургаж байгаа энэ ургамлыг Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу экспортлох тэр хорио цээр, олон зүйлүүдийнх нь асуудлуудыг шийдвэрлэхийн төлөө бүүр энэ яаман дээр газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг гарч байгаа. 10 хоног болгон бид нар энэ ажлын гүйцэтгэлийн асуудал дээр хяналт тавьж, ингэж хамтарч энэ газар тариалангийн салбарт экспортын чиг баримжаатай энэ чиглэлийг хөгжүүлэхийн төлөө хичээж зүтгэж ажиллана л гэж, ажиллаж байгаа л гэж би танд хэлье дээ.

Ц.Идэрбат: Ганхүлэг гишүүн тодруулъя.

М.Ганхүлэг: Хаврын тариалалттай холбогдолтой, бас хүнсний ногооны тодорхой бас дэмжлэгтэй холбогдолтой асуултыг бас нэмж тодруулъя. Өнгөрсөн жил 4.8 тэрбум төгрөг энэ чиглэлээр бас олгосон юм шиг байна. Тэгэхээр хүнсний ногоо тариалж байгаа иргэдэд зориулж 4 төрлийн бодлогыг урамшуулал, татаасны бодлогыг бид бас хэрэгжүүлж байгаа. Үрийн хувьд төл сонгино энэ тэр гээд бас нэр төрөл нэлээн буурсан юм шиг байна. Тэгэхээр хэчнээн нэр төрлийн үрийг ямар

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

шат дамжлагаар, ямар хэмжээтэйгээр, хаана өсөлтийг нь авч олгох вэ? Бордооны 30 хувийн урамшууллыг бас хүнсний ногоо тариалагч нарт бас олгож байгаа. Өнгөрсөн онд ямар байсан, энэ онд бас ямар хэмжээгээр олгох вэ? Трактор, тоног төхөөрөмжийн 50 хувийн буцаан олголтыг бас заавал ч үгүй энэ аж ахуйн нэгжээр дамжуулах гэдэг ийм зохицуулалтууд бас байгаа. Тэгээд энэ дээр тодорхой өөрчлөлт, саналууд бас орох ийм хувилбарууд бас хийх үү? Өнгөрсөн онд ямар байна, энэ онд ямар байх вэ? Нөгөө тонн тутам 100 мянган төгрөгийн урамшуулал бас энэ онд хэрхэн хэрэг.../минут дуусав./

Б.Бейсен: Сайд хариулах уу тээ? 6 номер сайд хариулъя.

Ц.Идэрбат: Тэр 900 сая төгрөгийн хөнгөлөлттэй нөхцөлөөр гэж хэлж болох байх тийм ээ? 4 нэр төрлийн энэ юмнууд олгогдоно. Энэ ногооны үрүүд дээр бас тодорхой хэмжээнд төмснөөс бусад нь дээр айхтар хүндрэлүүд үүсээгүй. Энэ нэр дурдагдаж байгаа 4 нэр төрөл дээр үрийн хомсдолууд бас байгаа гэж ингэж үзэж байгаа. Харин өнөөдрөөс ингээд энэ чинь нөгөө Хөдөө аж ахуйн газраараа дамжаад явдаг тэр схемээрээ энэ жилдээ явахаас өөр аргагүй. Яагаад гэвэл цаг хугацаа тулж байгаа учраас. Цаашдаа тэр ил тод болгох, нээлттэй болгох энэ юм руугаа явна гэж ингэж болно. Тэр бордоон дээр 30 хүртэл гэж байгаа. Яг 30 гэсэн хатуу үг байхгүй. Тэгэхээр энэ жил 2 тэрбум төгрөг байгаа. Энийг бид нар хэдий хэмжээний юм ирэх нь вэ тэндээ ингээд уялдуулаад олгоод ингээд явна гэсэн үг. Тэр ногооны урамшуулалтай холбоотой тэр урамшууллууд хуучин хэвээрээ явна. Зүгээр цаг хугацааны хувьд жоохон онд дамжчих гээд байгаа юмнууд л.../минут дуусав./

Б.Бейсен: Сайд гүйцээж хариулъя 1 минут.

Ц.Идэрбат: Тракторын урамшуулал тэр хөнгөлөлттэй холбоотой асуудал дээр миний барьж байгаа зарчмын байр суурь бол бас тэр байгаа. Яагаад зүгээр хувь хүн очоод тэр улсын, хаанаас авах гэж байгаа тэндээсээ сайн чанарыг нь сонгоод ингээд шууд өгч болохгүйгээр заавал дилерээр дамжуулах гээд байгаа юм бэ гэдэг дээр би бас арай өөр байр суурьтай байдаг. Зүгээр бидэнд хэлж байгаа зүйлээр хөрөнгө оруулалтын зээл орж ирж гарч авдаг.

Нөгөө талдаа нөгөө дилер компаниараа дамжуулаад чанартай байх энэ талаа боддог. Засвар үйлчилгээ, тос тосолгоо гээд ийм зүйлүүд нь бас давхар явдаг гэсэн ийм л тайлбартай сууж байгаа. Тэгээд бидний хувьд энэ дээр бас жоохон нээлттэй, сонголттой ийм болгох нь зүйтэй гэж боддог. Яагаад гэвэл бас миний хувьд орон нутагт ажиллаж байхад заавал ингэж энэ хэдээс авах биш би өөрөө очоод сонгогчоод энийгээ авах гэж үйлээ үзээд байна гэдэг олон тохиолдлууд энэ Хөлөнбуйр сумаас авхуулаад л олон газар таарч байсан. Тийм.

Б.Бейсен: Ганхүлэг гишүүн тодруулъя.

М.Ганхүлэг: Баярлалаа. Жижиг, дунд үйлдвэрлэлийн зээлийг бас тодруулъя аа. Бас өмнө нь бас нэлээн хэлбэрүүдийг нь бас өөрчлөөд зөвхөн хөдөө аж ахуйн төвийн бүс рүү энэ тэр олгох ийм зохицуулалтуудаа сайдуудаас хийгээд тэгээд тэр үнэхээр зөв байсан уу, буруу байсан уу? Одоо хаврын тариалалтын тухай бид ярьж байна. Уул нь зээл нь гарчихсан нөгөө зээл хуулиа аваад, хүлэмжээ бариад тариалалтаа эхлүүлээд явж байх цаг хугацаа ингээд оройтчихоод байна. Тэгэхээр энэ жилийн жижиг, дунд үйлдвэрлэлийн зээл хэчнээн

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хэмжээтэй яаж олгогдох вэ? Энэ чиглэл дээр бас тодорхой мэдээлэл юмнуудаа өгөөд ингээд явахгүй бол оройтож байна. Дахиад бас бүсчлэх үү? Ямар зохион байгуулалт руу оруулах вэ? Бадамсүрэн сайдын хувьд бас зөв нэг шийдэл гаргасан нь хугацааг нь уртасгасан тээ? Тэгээд тэр зохион байгуулалтаараа бас явах уу, журам юмнууд дээр бас яаж өөрчлөлт орох вэ гээд энийг бас нэмээд асуучихъя. Яг энэ цаг үед бас хүмүүсийн сонирхож байгаа асуулт бас байгаа?

Б.Бейсен: 6 номер сайд хариулъя.

Ц.Идэрбат: Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн зээл бол энэ жил дээр улсын төсөв дээр юм байхгүй байгаа. Эргэн төлөлтөөсөө 20 тэрбум төгрөг байгаа. Энэ 20 тэрбум төгрөг бол орон нутгуудад хуваарилагдахдаа тухайн орон нутаг Жижиг, дунд үйлдвэрлэлийн сан дээрээ мөнгө тавих юм бол дээр нь хувьчлаад өгдөг энэ л зарчмаар явна. Цаг хугацааны хувьд хугацаа алдаж байгаа эд нар гээд тэр нь утгагүй олон баахан шат дараалсан 4, 5 тийм дамжлагатай.

Жишээ нь, Баян-Өлгий аймагт жижиг, дунд үйлдвэрлэлийн зээл авах гэж байгаа хүнийг Улаанбаатар хотоос очиж баг очиж шалгадаг эд нар гээд ийм хаана хаана төвөгтэй ийм зүйлүүдийг шинэчлэх гэж байгаа. Тэгээд маргааш бол Засгийн газрын хуралдаанаар энэ Жижиг, дунд үйлдвэрлэлийн сангийн хугацааг өөрчлөх асуудлыг танилцуулж шийдвэр гаргах гэж байгаа юм. Хугацаа өөрчлөх. Тэгэхээр энэ хугацаа өөрчлөгдөөгүй байсныг өөрчлөх гэж байгаа юм. Шат дамжлагыг нь цөөлөх гэж байгаа юм. Тийм. Олголтын хувьд ингээд энэ эдийн засгийн идэвхжилтэйгээ бид уямаар юм билээ.

Б.Бейсен: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Идэрбат гишүүндээ амжилт хүсье ээ. Орон нутагт ажилласан бас хөдөө аж ахуйн чиглэлээр бас нэлээн мэдлэг, мэдээлэлтэй гишүүн ийм сайд болсон амжилт хүсье ямар ч байсан. Тэгээд нэн тэргүүнд хамгийн эхнийхээ үйл ажиллагааг махны үнэтэй холбоотойгоор зах зээл дээр очиж судлаад бас нэлээн илүү хүч дагуулах шиг боллоо. Энэ бол буруу биш зөв байсан.

Тэгээд энэ махныхаа нийлүүлэлт, өртгийн сүлжээтэй холбоотой асуудал дээр нэлээн шинэчлэл хийх цаг болчихоод байна Идэрээ гишүүн ээ. Би асуулт асуухгүй ээ ер нь бодлого ингээд хэд хэдэн зүйлүүд хэлчихмээр байна. Саналуудаа хэлээд явчихъя. Наана чинь сууж байгаа 2 газрын дарга нар чинь ч ерөөсөө угаасаа бодлогуудаа мэдэж байгаа. Тэгээд бид хэд Улсын Их Хурлын гишүүд тэгээд орон нутагт ажиллаж байгаа Засаг дарга нар гээд яг өөр өөрсдийнхөө юмыг бас ингээд тулгаад байх шинжтэй байдаг. Гэтэл наад яаман дээр чинь үндсэндээ бол бодлого бас зангилагдчихсан байдаг шүү дээ. Тэгээд бид хэд сайд болохоороо л ухаантай болоод л ингээд л хамаг юмыг өөрөө шийдэх гээд ингээд зүтгээд урдах сайдаасаа ялгарах гээд ингээд зүтгээд байдаг. Тэр талынхаа зүйлийг бас болиорой. Урьдын сайд чинь хэл үг ерөөсөө авдаггүй байсан шүү. Тийм болохоор бас гишүүдийнхээ зүйлийг ч гэсэн наад бодлогынхоо, яамныхаа бодлоготой уялдуулаад яваарай гэж хэлье ээ.

Өртгийн сүлжээ нь махныхаа өртгийн сүлжээг нэг мөр болгох цаг хугацаа болчихоод байна. Ер нь бол малчид ойрын хавийнхаа ямар радиуст байх юм, махны үйлдвэртээ өгдөг, стандартын дагуу махаа бэлтгэдэг, ингээд махны үйлдвэр нь өөрсдөө магадгүй махныхаа үйлдвэрийнхээ хувьцааг малчид өөрсдөө

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

эзэмшдэг байх, тодорхой махны үйлдвэр рүүгээ бэлтгэн нийлүүлэлтээ хийдэг байх. Тэгээд махны үйлдвэр нь цаашаагаа жижиглэн болоод рестораны юу байдаг юм зах зээл рүүгээ гаргаж байдаг ийм сүлжээ бол бид нарын стандарт сүлжээ шүү дээ. Энэ рүүгээ хэзээ орох юм бэ? Энийгээ оруулах хэрэгтэй байна. Зөндөө удаан ярилаа.

Тийм болохоор ерөөсөө орон нутгийнхаа хэмжээнд Монгол Улсынхаа мафижсан байдлаар хаана, хаана одоо ямар махны үйлдвэрүүд байх юм, ямар стандарт хангасан байх юм, тэр махны үйлдвэрүүд нь зах зээл рүүгээ ч нийлүүлж байдаг, стандарт хангасан мах, мал, махаа гадагш нь экспортод гаргаж байдаг ийм сүлжээ рүү орох цаг хугацаа чинь болчхоод байна. Энэ дээр анхаарах хэрэгтэй байна.

Тэгэхгүй бид нар чинь гараараа мах бэлдээд тэгээд дундуур нь ченж орж ирээд малчны бэлдсэн мах нийлүүлж байгаа, зах зээлд нийлүүлж байгаа махны чинь, жижиглэнгээр зарж байгаа махны чинь үнэ дундаа бол асар зөрүүтэй болчхоод байна шүү дээ. Одоо бол нөгөө үхрийн мах чинь 30 гараад явчихлаа. 32 ч билүү хонины мах чинь 25 болоод явчихлаа. Гэтэл экспортод бид нар махаа мэдээж гаргах шаардлагатай байж байдаг. Малчдынхаа энэ том хөдөлмөрийг бол үнэлэх шаардлагатай байдаг. Тэгэхээр энэний том сүлжээгээ бид нар нэг мөр болгож байж эндээс чинь махны үнэ чинь бол тогтох ёстой гэдэг дээр анхаарч ажиллаарай гэж.

Яг энэтэй уялдуулаад, 1 минутаа авчихъя.

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүнд 1 минут.

Ж.Бат-Эрдэнэ: Тэгээд яг энэтэй уялдуулаад малынхаа эрүүл мэндтэй холбоотой асуудал дээр анхаарах хэрэгтэй байна. Би яриад л байгаа наадуул чинь бүгдээрээ мэдэж байгаа. Наад хүмүүс чинь. Үндсэндээ малын эрүүл мэндтэйгээ бид нар дайн зарлах хэрэгтэй, өвчинтэй дайн зарлах хэрэгтэй болчхоод байна шүү дээ. Малынхаа эрүүл мэндийг стандартын дагуу байлгаж, малын өвчнөө бол бас тодорхой хэмжээнд хорьж, тэр нөгөө хязгаарлагдмал бүсэд нараа бий болгож байж ингэж байж бид нарын гадагш экспорт маань гарна. Энэ дээр анхаарах хэрэгтэй байна. Тэр Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга дээр нэлээн хатуухан шиг, нэлээн зоригтойнхон шиг ийм хүн тавьж байж ажиллах хэрэгтэй байна.

Би олон удаа наад Мал эмнэлгийн эрүүл мэндийн тухай хууль дээр чинь сууж байсан, яамныхантай сууж байсан. Үнэхээр зоригтой таазанд тулсан бүх саналуудаа оруулаад ирэхэд тэрийг чинь оруулж ирж чадахгүй бөөрөнхийлдөөд байдаг ийм хүмүүс ер нь ажиллаад байсан шүү. Тийм болохоор ерөөсөө зоригтойнхон шиг ажиллаж чадахаар ийм хүмүүсээ оруулаад явах хэрэгтэй байна. Шинэ хоршоогоо маш сайн дэмжих хэрэгтэй байна. Шинэ хоршоогоор жишээ нь зүүн аймгуудад бол малчид өөрсдөө хадлангаа хадах ийм боломж бололцоог нь олгочихсон шүү дээ. Трактор тоног төхөөрөмжтэй болчихсон, ядаж өөрсдөө тэр.../минут дуусав./

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүн санал хэллээ. Сайд хариулъя гэж байна.

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Ц.Идэрбат: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя Бас мөн баярлалаа. Таны хувьд бас Шинэ хөдөө хөтөлбөр гээд ингээд анх санаачлаад хөдөөгийн малчдын тулгамдсан олон асуудлуудыг шийдвэрлэхийн төлөө бас их санаачилгатай ажиллаж байсан гишүүдийн нэг. Би тантай олон зүйлүүдээр санал нэг байна. Ялангуяа шинэ сайдын хувьд төрийн албаны энэ тогтвортой байдал, залгамж халаа энэ дээр маш анхаарлаа хандуулна. Энэ яаманд халаа сэлгээ янз янзын ийм зүйлийг огт хийхгүй ээ. Энэ яамны бодлогыг энэ Алсын хараа-2050, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, шинэ Монгол Улсын Ерөнхий сайдын дэвшүүлэн тавьж байгаа энэ зорилтын хүрээнд манай энэ яамны баг хамт олон бүгдээрээ хамтдаа сайхан хичээж ажиллана.

Нөгөө талдаа сайд бүгдийг зөв бодож байгаа. Сайдын зөв гэдэг ийм муйхар бодлого явуулахгүй. Олон эрдэмтэн, судлаачид одоо өнөөдрийн яг энэ хөдөө аж ахуйг мэддэг энэ гишүүдийнхээ үг яриа, саналыг бид бас үйл ажиллагаандаа тусгаж ажиллана. Та бүхэн бас орон нутгаас, хотоос сонгогдсон гишүүдийн хувьд энэ салбарын олон асуудлуудыг бас мэдэж байгаа, нүүр тулж байгаа хүмүүс учраас энэ бодитой саналууд гэж сайдын хувьд хүлээж авна гэдгээ бас хэлье.

Энэ хөдөө аж ахуй дээр холбоотой олон асуудлуудын нэг бол энэ ченжийн систем гэж байгаа. Энэ бол олон жил ингээд урхагшчихсан ийм сүлжээ. Үүн дээр бид Нийслэлтэй, ялангуяа Улаанбаатар хотын махны сүлжээний нийлүүлэлтийн асуудал дээр ямархуу менежмент хийх вэ, нөгөө хөдөө талдаа шинэ хоршоогоо үнэтэйгээ яаж уялдуулах вэ гээд ингээд бодлогын нэлээн том дүр зураглал гаргана гэсэн ийм чигтэй.

Нөгөө талдаа энэ мал эмнэлгийн салбар дээр би зоригтой өөрчлөлт хийхийн төлөө ажиллана. Өчигдөр ч бас тэрийгээ яамны шуурхай дээр тодорхой илэрхийлсэн. Намайг сумын Засаг даргаар ажиллаж байхад Мал эмнэлгийн ерөнхий газар ийм л газар байсан. Өнөөдөр 100 гаруй тэрбум төгрөг авчхаад тэр үеийнхээс маань ялгаагүй зарим юм нь бараг дордчихсон ийм хэмжээнд л байгаад байгаа юм. Тийм учраас энэ мал эмнэлгийн тогтолцоо өөрөө сайн байж байж, мал эрүүл байж байж энэ Монголын хүн амын эрүүл мэндийн асуудал ч бас энд яригдана. Малчдын эдийн засгийн асуудал энд яригдана. Тийм учраас энэ мал эм бэлгийн салбар дээр дорвитой зоригтой өөрчлөлт хийнэ ээ гэдгээ бас хэлье.

Дараа нь энэ махны энэ ченжийн тогтолцооноос гадна энэ махны эрүүл мэндийн асуудал байна. Үнэхээр бид нар эрүүл мах наашаа оруулж ирж чадаж байна уу үгүй юү. Орон нутгаас наашаа гарч байгаа махан дээр зүгээр бичиг хийж өгч байгаа болохоос биш яг энэ эрүүл мах гэдгийг ер нь баталж байгаа газар яг одоогоор алга байна шүү дээ. Тийм.

Тийм учраас орон нутагт намайг ажиллаж байх үед Хэнтий аймгийн Баян-Адарга сумын Тамгын газрын Мал аж ахуйн тасгийн мэргэжилтэн хүн бол яамны зүгээр цааш нь хэлж өгөөч ээ манай энэ хөдөө аж ахуйн тасаг бид нар ядаж сумынхаа сургууль, эмнэлэг, цэцэрлэгт өгч байгаа малын махыг шинжилчихдэг болмоор байна. Үнэхээр тэр вакцины үлдэгдэлтэй юү үгүй юү олон зүйлүүдийг шинэчилчихдэг болмоор. Ингэхийн тулд бидэнд тодорхой хэмжээний жоохон лабораторийн анхан шатын багаж зэвсэг байхад бид хийх болом бүрэн дүүрэн бололцоо байна гээд илэрхийлж байсан. Үүнийг ч гэсэн би манай яам бол, манай хамт олон энэ бодлого, үйл ажиллагаандаа тусгаж ажиллах ёстой гэсэн ийм бодолтой байгаа гэдгээ бас хэлье ээ.

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Ерөнхийдөө бодлого нэг байх шиг байна. Нэг зүйлийг бас их сайн анхаарах хэрэгтэй байна. Яамнаас гарч байгаа бодлого чинь орон нутагт очихоороо тухайн орон нутаг ч яг тэр чигээрээ босоо байдлаар бол шилжиж чадахгүй байгаа шүү дээ. Орон нутагт ямар Засаг дарга арай жоохон амьдралтай ойрхон, арай жоохон мал аж ахуйтай ойрхон, газар тариалантайгаа ойрхон ийм хүн нь ийм Засаг даргатай ийм аймаг нь арай аятайхан шиг ажилладаг энэнээс арай жоохон хол байгаа бол тэгээд л ерөөсөө хамаг юм хаячхаад байдаг шүү дээ.

Тийм болохоор энэ орон нутагтайгаа ажиллах босоо байдлаар байх юм уу ямар хэмжээнд байх юм? Орон нутгийн мал аж ахуй, газар тариалантай холбоотой агентлагууд та бүхэн яг нэг бодлогоор явж байдаг энэ схемээ бий болгох ёстой шүү. Тэгэхгүй бол та энд юм яриад л байдаг орон нутаг шал ондоо зүүн тийшээгээ ажил хийгээд юу гэдэг билээ солгой ажил хийгээд ингээд яваад байдаг уялдахгүй юм байдаг шүү энэ дээр анхаараарай гэж хэлье. Тийм.

Б.Бейсен: Би асуулт асууя гэж бодож байна. Энэ Атрын энэ 4 дүгээр аян эхлүүлж байсан урд сайд. Нийтдээ сая 200 га талбайтай тэр нь 800 га-д нь тариалалт хийж байгаа. Энэ жил нэмж тэр 400 мянган га-д нэмж тариалалт хийж байна уу энэ хавар? Нэг дэх асуудал.

Хоёр дахь асуудал энэ баруун бүсийн аймгууд гурил, тэжээлээ Оросын Холбооны Улсаас импортолж байна. Тэгэхээр энэ Увсын Баруунтурууны гурил тэжээлийн аж ахуй гээд байсан. Энийг сэргээх асуудал, Ховдын Эрдэнэбүрэн усалгаатай тариалангийн аж ахуй, Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын хуучин гурил, тэжээлийн үйлдвэр байсан. Гэтэл энэ тэжээлийн үйлдвэрийн байрыг ингээд Онцгой комисс жилийн өмнө тэрбум таван зуугаас үнэлээд л авсан бас дамлаад зарж байгаа асуудал байгаа. Тэгэхээр энийг буцааж авч байгаа тэжээл яаж байх сэргэх боломж байгаа юм? Энэ талаар ямар бодлого баримталж байна? Нэг дэх асуудал.

Хоёр дахь асуудал энэ Ерөнхийлөгчийн Хүнсний хувьсгалын хүрээнд гол нэрийн хүнсний ногоогоо дотооддоо тариалаад Монгол орны хөрсөнд ургасан эрүүл хүнсээр ногоогоор хангах боломж байгаа л даа. Ялангуяа энэ сургуулийн хүүхдүүд, цэцэрлэг, яслийн дотуур байрны асуудлууд байж байгаа. Хавдар залуужиж байна, хүнсний аюулгүй байдал алдагдсан. Энд Ерөнхийлөгч маань санаа зовоод бас ийм Хүнсний хувьсгал нэртэй хөтөлбөр явуулж байгаа. Энэ дээр хүлэмжийн аж ахуй гол, мөрөн дагасан том Ховд байна, Баян-Өлгийн Баяннуур сумын сангийн аж ахуй гээд байсан хүнсээр хангах боломжтой энэ сумууд дээр энэ жижиг, дунд үйлдвэрлэлээс зээл олгох асуудал дээр яаж анхаарч байна вэ? Одоогоор хэчнээн тэрбум төгрөг төлөвлөөд байна?

Энэ сая энэ намаржилтын асуудал асууж байна л даа. Нөгөө салхи гараагүй учраас ... хайрлахгүй байна гэдэг шиг зундаа бороо бурхан тэнгэр маань хур бороо хариулбал сайхан зун болох байх гээд ерөөе бид нар. Тэгээд бас энэ юутай холбоотой зуншлага ямар байдагтай холбоотой энэ тариалалтын асуудал бас нэлээн асуудал орох байх. Та бүгд бас энийг мэдэж байгаа.

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Дараагийн асуудал энэ хөрш зэргэлдээ Уйгур, Шинжаан, Оросын Холбооны Улсын ... мужид малын гоц халдварт өвчин гарсан байна. Сүүлийн үеийн ... -аар бас үүдсэн. Одоо айлууд бүгд хаваржаанаасаа зуслан руугаа, хаваржаа руугаа нүүж байна. Цаад талын улсууд мөн адилхан наашаа гарна. Энэ орж ирэх аюул маш их байна. Тийм учраас вакцины асуудал дээр ямар бодолтой байна вакцин хангалттай юу энэ талаар асуулт асууя.

6 номер сайд хариулъя.

Ц.Идэрбат: Газар тариалангийн салбарын өсөлт бас яг га-гаар нь хэмжвэл бас явж байна. 500 энэ чинь 70-н хэдэн мянган га тарьж байсан бол энэ жил 630 болж ингэж өсөж байгаа. Тэр дотроо төмс 16 мянган га-д тарина. Хүнсний ногоо 18 мянган га-даа тарина. Ингээд энэ тариалалт маань байгаль, цаг уур олон зүйлүүд ингээд аятайхан байгаад ингээд авч чадвал улаан буудайн дотоодын хэрэгцээгээ 100 хувь хангана, төмсөө 100 хувь хангана. Энэ 18 мянган га-д тарьсан хүнсний ногоо маань 80 хувиа хангана гэсэн ийм бодолтой, төлөвлөгөөтэй байгаа. Цаашдаа энийг бүр 100, 100 хувь хангадаг болохын тулд энэ Засгийн газрын тогтоолыг өнгөрсөн 7 хоногт гаргасан. Үүний хүрээнд энэ үрийнхээ 4 төрлийн үрээ нэмэх, хүлэмжийн аж ахуйгаа сайжруулах, дээрээс нь дахиад өвлийн хүлэмж ажиллуулсан хүмүүст нөгөө халаалтын цахилгаанаар шийддэг цахилгаан маш чухал учраас цахилгааны үнийн хөнгөлөлтүүд үзүүлэх гээд ингээд олон зүйлүүдийг бид бас хэрэгжүүлээд ингээд бэлтгэлийг нь шийдвэрээ гаргуулчихсан. Хэрэгжилтийг нь хангаад ингээд ажиллачихна.

Цаашдаа энэ хүлэмжийг зуны болон өвлийн гээд. Тэгэхээр өвлийн хүлэмжийн асуудал Монгол Улсад туйлын чухал зүйл. Үнийн өсөлттэй холбоотой, хэрэглээтэй холбоотой. Тийм учраас ер нь өвлийн хүлэмж талдаа бид бас цаашдаа нэлээн анхаарах ёстой юм байна. Зуны хүлэмжийн асуудлыг бид нар зөвхөн Цэцгээ, Дулмаа гэж 1, 1 хүнд хүлэмж өгнө гэхээсээ илүүтэйгээр үнэхээр ажиллуулж чадах туршлагатай, газартай ийм хоршоонуудаар дамжуулаад бүс нутгийн асуудал болгож, аймгийн асуудал болгож ярих нь зүйтэй юм байна гэсэн ийм чигтэй байгаа.

Тэгэхээр хур борооны асуудал дээр та бас анхаарал хандуулж байна. Бидний хувьд нэг л бололцоо байгаа нь одоогийн байдлаар энэ пуужингийн асуудал байгаа. Тэгээд пуужин болд өөрөө маш чухал байдаг. Энэ дээр аймгийн удирдлагууд яамны зүгээс пуужинг нь шийдээд өгнө. Авсан пуужингаа бид нар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, цаг уурынханд өгнө. Тэгээд цаг уурынхнаараа дамжуулаад нөгөө экспедицийнх нь бензин тос бүх юмнуудыг нь аймгуудын удирдлагууд би шийдээд өгнө гэдэгт итгэлтэй байгаа.

Дараа нь энэ малын өвчтэй холбоотой асуудал байна. Бүгд Найрамдах Хятад Ард Улсад бас малын өвчин гарсан, хойд 3 сарын 20-диор гарсан ийм тохиолдлууд байгаа. Оросын Холбооны Улсад бас малын халдварт өвчний асуудлууд байгаа. Манай мал аж ахуй, энэ мал эмнэлгийн өнөөдрийн үйл явц бол туйлын хангалтгүй байгаа. Би бол шулуухан хэлнэ. Аль 1 сард гарсан малын өвчний эсрэг ямар ч арга хэмжээ авалгүйгээр өнөөдөр ийшийгээ төвөөр дамжаад баруун аймгууд руу орчихно. Энийг бид нар яаралтай зогсоох, яг таны хэлж байгаа энэ хилийн бүс орчмоор бас сэжигтэй юмнууд орж ирэхээс урьдчилан сэргийлэх ажлуудыг бас яаралтай зохион байгуулах ажил байгаа. Сайдын хувьд энэ үйл ажиллагаанд шаардлагатай санхүү мөнгөний асуудлыг бүрэн шийдвэрлэхэд бэлэн

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

байгаа. Гагцхүү надад төлөвлөгөөгөө юмнуудаа танилцуулах ёстой гэж ингэж бас бодож байгаа.

Б.Бейсен: Баруун аймгуудын тэр баруун Увсын Баруунтурууны гурил тэжээл аж ахуй, Ховдын Эрдэнэбүрэний усалгаатай Ногоон нуурын тэжээлийн аж ахуй?

Ц.Идэрбат: Баруун бүсийн тариаланчдын зөвлөгөөнд би цахимаар оролцсон. Ер нь улсын төсөв дээр Увсын Баруунтуруунд элеваторын асуудал шийдэгдэж байгаа. Хувийн аж ахуйн нэгжүүд баруун бүсэд ер нь гурилын үйлдвэр яригдаж байгаа. Тэр Эрдэнэбүрэний усалгаатай газар тариалангийн 500 га-гийн асуудал дээр Азийн хөгжлийн банканд бас санал тавьсан. Одоогоор зөвшөөрөл нь харамсалтай нь ирээгүй байгаа.

Таны хэлж байгаа тэр байшин барилгын худалдаатай, дуудлага худалдаатай холбоотой асуудал бол манай яамны биш Шадар сайд Улсын онцгой комиссын зүгээс гарсан шийдвэр гэдгийг манай хэд сая танилцуулж байна. Тэгэхээр тэр хүрээнд та асуудлаа тавих нь зүйтэй байх.

Бидний хувьд бол цаашдаа энэ Евро Азийн хэлэлцээртэй холбоотой баруун бүс ийшийгээ гарцтай маш том бололцоотой ийм бүс болох учраас баруун бүсийн газар тариалангийн хөгжлийн ТЭЗҮ, зураглал гаргах энэ ажил руу бас орж байгаа. Төсөв мөнгө нь бас тодорхой хэмжээнд.../минут дуусав./

Б.Бейсен: Тэр тэжээлийн аж ахуйн байр дээр чинь уг нь хувьчилж авсан байгууллага нь ажиллахгүй байсаар байгаад өөр байгууллагад өгчхөж байна л даа. Цаашдаа ер нь тэжээлийн аж ахуй байгуулах нөхцөл байгаа л даа.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Мэдээлэлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрс өгнө үү.

Ганхүлэг гишүүнээр тасалъя. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн үг хэлье.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа Идэрбат сайдад бас үнэнийг хэлсэнд баярлалаа. Урьдын сайд нар нь дандаа Дарханы арьс, ширний үйлдвэр болж байгаа л гэдэг мэдээлэл өгдөг байсан. Болохгүй байгаа гээд тэгэхээр болоод байгаа гээд л байдаг байсан. Энийг бол та сая үнэн шударгаар бол болохгүй байгаа гэдгийг нь шууд хэлчихсэн нь дээр байсан. Баярлалаа гэж хэлье. Үүнтэй холбогдуулаад манайх жишээлбэл Хөвсгөл аймаг. Та ч тойргоос сонгогдсон. Би ч тойргоос сонгогдсон. Хөвсгөл, Булган, Орхон аймаг. Манай Хөвсгөл, Булган хоёр бол мал ихтэй, бэлчээр бас бус хөдөө аж ахуй болон мал аж ахуйн асуудлууд хөндөгддөг ийм аймгуудын нэг хэсэг нь.

Арьс, ширээ яах вэ гэдгийг л та сайд байх хугацаандаа ядаж шийдээд өгөөч ээ. Та өмнөх Байнгын хорооны хуралдаан болон энэ хөдөө аж ахуйн салбарын чиглэлийн бүх юман дээр дандаа энэ арьс, ширийг өөрөө хөнддөг байсан гишүүн. Малчдад маань энэ арьс, ширийг ашигтай болгох эдийн засгийн эргэлтэд оруулах тал дээр та сайд байх хугацаандаа яаж ийгээд шийдэл гаргаж эцэслэж өгөөч ээ гэдгийг би танаас хүсэх гэж байгаа юм.

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Нэгэнт Дарханы арьс, ширний үйлдвэр болохоо больчихсон гэдгийг хэлж байгаа бол аймгууд дээр байгаа саяынх шиг арьс, ширний тодорхой хэмжээний жижигчилсэн үйлдвэрүүдийг бид нар байгуулах шаардлагатай байгаа. 2026 оны 1 сарын 5-ны өдөр Монгол Улсын Ерөнхий сайдаар ажиллаж байсан Гомбожавын Занданшатар Ерөнхий сайд байхдаа очсон. Ингээд Хөвсгөл аймгаас санал тавьсан. Бид нар бол газар, дэд бүтэц бүгдийг нь шийдье ээ, 27 оныхоо улсын төсөв дээр ядаж чадвал 26 ондоо багтаагаад бид нарт энэ дунд оврын арьс, ширний үйлдвэр байгуулах боломжоор хангаад өгөөч ээ гээд. Занданшатар дарга Ерөнхий сайд, Бадамсүрэн сайд байсан хоёулаа байсан. Энийг шийдэж өгнө гэж амласан. Тэгээд одоо ингээд Засгийн газар, Ерөнхий сайд нь ч өөрчлөгдчихлөө, сайд нь ч өөрчлөгдчихлөө.

Тэгээд Хөвсгөлчүүдийн маань хийж бүтээж байгаа төлөвлөж байгаа энэ ажлууд үргэлжлэх ёстой. Бид нар тойргоос сонгогдсон гишүүний хувьд, ард түмний элч болж байгаагийн хувьд, мөн аймагтайгаа нягт уялдаа холбоотой ажиллаж байгаагийн хувьд энэ ажлыг бол та бүхнээс бас нэхэж шаардаж явна гэдгийг би хэлэх гэж байгаа. Тэгэхдээ нэхэж шаардуулалгүйгээр энэ арьс, ширний тодорхой аймгууд дээр төвлөрсөн үйлдвэрүүд байгуулах ажил руу та ханцуй шамлан ороод өгөөч ээ. Та сая хэлсэн үг байна малчин хомсдож байна. Гэхдээ малчин төрөөс хэчнээн мөнгө төгрөг өгөөд ч малчдыг бий болгож чадахгүй. Малчных нь өөрсдийнх нь эдийн засгийн хэрэглээ буюу мал аж ахуйг нь үнэтэй болгоод олдог орлогыг нь нэмэгдүүлээд өгчихвөл малчид өөрсдөө олноор бий болно гэж. Энэ бодлогыг л та маш сайн барьж энэ хөдөө аж ахуйн салбарт явуулаад өгөөч ээ гэж хүсэж байгаа юм.

Манай Засгийн газрын бас нийтлэг ийм ялгаварлал гэдэг юм уу эсвэл ялгамжгүй байдал гэдэг юм уу нэг зүйл байна. Дэд сайдгүй байна гэвэл бүгдийг нь дэд сайдгүй болгох гээд дайраад байдаг. Дэд сайдтай байна гэвэл бүх яамыг нь дэд сайдтай байлгах гээд дайраад байдаг. Уул нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хамгийн багадаа 2 дэд сайдтай байх ёстой. Бүүр хамгийн багадаа шүү. 2-оос 3 дэд сайдтай байж байж энэ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны манай Монгол Улсын гол явж байгаа бодлогын яамны ажил бол цаашдаа маш үр дүнтэй үргэлжилнэ гэж би хардаг.

Тэгээд эсвэл яамны сайдгүй байлгая, эсвэл ганцхан сайд, дэд сайд, эсвэл яамны дэд сайдгүй байлгая, эсвэл ганцхан дэд сайдтай болгоё гэдэг энэ бодлогоос бас манай Монгол Улсын Ерөнхий сайд шинэ Учрал Ерөнхий сайд маань бас татгалзаад ялгамжтай байдлыг нь тогтоогоод яг тэр аль нь илүү эрэлттэй байгаа юм, аль нь их ажлын ачаалалтай байгаа юм, аль нь ямар хэмжээний ямар цар хүрээний бодлого барьж байгаа вэ гэдэг дээр Ерөнхий сайд өөрийн шийдвэрийг гаргаж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамыг хамгийн багадаа 2 дэд сайдтай болгож өгөх ёстой л гэдэг ийм зарчим дээр байгаа. Тэгээд төгсгөлд нь дахин хэлэхэд та өөрөө маш их ярьдаг байсан сэдэв өөрөө сайд нь боллоо энэ арьс, шириийг малчдад ашигтай болгож өгөөч ээ, эдийн засгийн эргэлтэд оруулж өгөөч ээ гэдгийг хүсэх гэж байгаа юм. Баярлалаа.

Б.Бейсен: Сэддорж гишүүн үг хэлье.

Р.Сэддорж: Сайдад ажлын амжилт хүсье ээ. Танай хамт олонд амжилт хүсье. Надад бас хэдэн мэдээлэл гаргаад өгөөч, ирүүлээч. Тэгээд танайхтай бас урьд нь бас өмнөх сайдын чинь үед бас уулзаж байсан тэгээд таг болчихдог юм

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

билээ. Тэгээд ус ярихаар их сайн ойлгож өгөхгүй байх шиг байна лээ. Бас говийн нөхцөл байдлыг ярихаар бас ойлгож өгөхгүй байх шиг байдаг юм. Үгүй байлгүй дээ би бас андуурсан байлгүй. Амьд мал гаргах энэ ажлууд ер нь багасгасан нь дээр ээ. Энэ дээр та бүхэн энэ махны экспортыг хорихгүй 2 жил болсон Улсын Их Хуралд талархах хэрэгтэй. Ингэж махны үнэ өндөр болж одоогийн малчдын хөдөө хөдөө амьдрах итгэл нь жоохон ч гэсэн сайн байгаа. Магадгүй бас залуу малчид эргэж мал дээрээ гарах залуу малчид нэмэгдэх хандлага байгаа. Амьд мал экспортолж байгаа энэ үйл явцыг мэдээг бас явуулаач ээ.

Тэр малчин өрхийн хүүхдийг хэрхэн сургах тал дээр та бүхэн бас санаа бодлоо илэрхийлээч. Ер нь ангид хөдөөгийн суманд ангийн 30-аас 40 хувь нь малчин хүүхэд байдаг гэсэн зүгээр ерөнхий тооцоо байгаа. Тэгэхээр зарим суманд бүр 15, 16 хүүхэдтэй 1 дүгээр ангид хүртэл байгаа асуудлууд байгаа. Тэгээд энэ бол маш чухал асуудлууд юм. Маш нандин, хамгийн эмзэг асуудал бол энэ асуудал юм. Тэр хүүхдийг 6, 7 настайд нь малаас нь, гэрээс нь холдуулаад ер нь сайн зүйл авч ирэхгүй ээ.

Ноос, ноолуур, тэмээний ноос угаах, хонь, тэмээний ноос угаах үйлдвэр Өмнөговь аймгийн Даланзадгад хотод төр хувийн хэвшлийн түншлэлээр орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн түншлэлээр ашиглалтад орсон. Энэ үйлдвэрийг та хүн явуулж үзүүлээд энэ үйлдвэрийг бодлогоор дэмжээч ээ. Тэгээд ер нь энэ арьс шир боловсруулах үйлдвэр, энэ ноос, ноолуурын ноолуур бол тусдаа, тэмээний ноос бас гайгүй хонины ноос, бусад энэ түүхий эдийг үнэтэй болгох тал дээр та бүхэн маань бас яг худалдан авагч оронтойгоо, үйлдвэртэйгээ хамтарч ажиллахгүй бол энэ ер нь бүтэхгүй зүйл болчихоод байгаа юм.

Тэгэхээр хөдөөгүүр хамгийн их яригддаг зүйл бол энэ малын энэ арьс, нэхий эд нарыг үнэгүй байгаад үнэхээр харамсаж байна гэдэг зүйл Монгол орон дээр яригдаж байгаа. Тэгээд энэ дээр бас дорвитой ажил хийж, хийхийг хүсэж байна. Энэ дээр бас нэлээн туршлагатай хүн энэ Говьсүмбэр аймагт байдаг ноос угаах үйлдвэр юм билээ. Бүх зах зээлийн хүнд хэцүү үеийг даван туулж байгаа маш их зовлон бэрхшээлийг үзчихсэн ийм үйлдвэр байна лээ. Тэгээд энэ үйлдвэрийн хүмүүстэй бас танай хамт олон уулзах хэрэгтэй гэсэн ийм зүйлүүдийг хэлье ээ.

Б.Бейсен: Мандхай гишүүн санал хэлье.

М.Мандхай: Би түрүүн бас хэлсэн хөдөө аж ахуйн салбарт энэ олгож байгаа татаас сүүлийн 5 жилийн нийт татаас 4.6 дахин өндөр дүнтэй гарсан. Тэгэхээр 15 оноос хойш ерөнхийдөө манай татаасны хэмжээ илт өссөн мөртөө бүтээмж 15 онд 20 хувиас 6 хувь болтлоо буурсан байгаад байгаа юм. Тэгээд нийт татаасны хэмжээг харахаар эдийн засгийн хэллэгээр орц, гарц гэж байдаг. Бид нар нийт олгож байгаа татаасны 50 хувьд нь зөвхөн орцонд бид нар татаасыг олгож байгаа буюу дөнгөж эргэлтийн хөрөнгө эхлэх гэж байгаа бизнес. Тэндээс магадгүй орцонд олгож байгаа татаасны хэмжээ 10 оноо авах ёстойгоос 8 оноог нь авсан байж болно. Тэндээс үр ашигтай ажилласан, үр дүнтэй ажилласан бизнесүүд төрсөн.

Гэхдээ олон улсад хөдөө аж ахуйн татаас, урамшууллыг олгохдоо гарц буюу нэмүү өртөг шингэсэн эргээд нийлүүлэлтэд нөлөөлсөн, ДНБ-тэй уялдсан байдлаар татаасыг олгодог манай улс дандаа зөвхөн орцонд олгож ирсэн байгаад байгаа юм. Тийм учраас өнөөдөр бүтээмжийн хэмжээ буураад байгаа буюу үр дүн тааруу байгаагийн илэрхийлэл байгаад байгаа юм. Тийм учраас би Бейсен даргад

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хэлмээр байгаа юм. Бейсен даргаа нэгэнт бид нар татаасны асуудал ярьж байгаа учраас олон хардлага сэрдлэг байдаг. Энэ мөнгө яг үндсэндээ эзэндээ очсон юм уу? Хэдэн аж ахуйн нэгж авсан юм? Өнөөдөр юмны үнэ, хүнсний үнэ нэмэгдээд байгаа. Тэгээд энэ олон татаас, урамшуулал чинь хаана яваад байгаа юм бэ гэдэг эргэлзээ тээнэгэлзэл надад ч байдаг.

Тийм учраас би Байнгын хороон дээр сонсгол би яг энэ төрийн дэмжлэг татаастай холбоотойгоор сонсголыг би санаачилмаар байна тэгээд Байнгын хорооны дарга энийг санаачилгыг хүлээж аваад дэмжээд өгнө үү гэдэг хүсэлт байна. Тэгээд сүүлийн энэ 15 оноос хойш олгогдсон олон судалгаа байгаа. 23 онд хийгдсэн бас олон улсын татаастай холбоотой энэ төрийн дэмжлэг хэр үр дүнтэй байсан судалгаа бас байгаа. Тайлангууд байгаа. Тэрийг ч харна. Тэгээд тийм учраас ер нь энэ төрийн дэмжлэг бодол ер нь манайд олгож байгаа төрийн энэ өөрөө дэмжлэг нь бодлогын хувьд яг зөв яваад байгаа юм уу гэдэг дээр бид нар үнэлэлт, дүгнэлт өгөх цаг болчихсон байгаа учраас миний хувьд би өөрөө энэ ажлыг санаачлаад хэрэгжүүлэх хүсэлтэй байгаагаа албан ёсоор бас энд хэлчихье ээ гэж бодож байна.

Б.Бейсен: Ганхүлэг гишүүн санал хэлье.

М.Ганхүлэг: Шинэ сайд бас ажлаа аваад удаагүй байгаа болохоор өнөөдрийн бас хэлэлцүүлэг нэлээн өргөн хүрээтэй бас боллоо. Салбарт тулгамдаж байгаа олон асуудлын тухай бас ярилцлаа. Ямартаа ч нэлээн нээлттэй ил тод байдлаар бас ажиллана гэдгийг бас дэмжиж байна. Тэгээд энэтэй холбогдолтой тодорхой асуудал, мэдээллүүдийг салбарынханд хүргээд явах, төрөөс олгож байгаа бага хэмжээний ч гэлтгүй энэ нөөцийг бас илүү үр бүтээлтэй болгох чиглэл рүү гол анхаарлууд хандах нь зөв юм гэсэн ийм саналууд бас гарч байна.

Тэгэхээр өнөөдрийн бас Байнгын хорооноос гарч байгаа энэ саналуудаар тодорхой тогтоол, саналууд гараад ингээд явах байх. Мандхай тэргүүтэй бас гишүүдийн хэлж байгаа энэ татаас, урамшуулалтай холбогдолтой энэ асуудал дээр сонсгол байх уу, асуулга байх уу бас энэ тодорхой энэ хуулийн бас юу зохицуулалтын дагуу дараагийн арга хэмжээнүүд аваад явахыг дэмжиж байгаагаа бас илэрхийлье. Боломжоор бас оролцоод ингээд явна гэж бодож байна.

Энэ хаврын нөхцөл байдалтай холбогдолтой бас хэд хэдэн зүйлүүдийг би бас ажилдаа хэрэгжүүлээсэй гэж бодож байгаагаа бас хэлье.

Нэгд, энэ мал эмнэлгийн энэ гоц халдварт өвчлөлтэй холбогдолтой тарилгын энэ хуваарийн дагуу явах, явахгүй асуудал ингээд жилийн жилд л гарах юм. Түүнтэй холбогдолтой бас Турк вакцин, Орос вакцин, янз янзын вакцин гээд ингээд вакцинтай холбогдолтой асуудлууд бас гарах юм. Яах вэ энэний бас цаад гол асуудал нь энэ тендер, олон асуудалтай холбогдолтой зүйлүүд бас байх шиг байна. Энэ дээр бас онцгой анхаарлаа хандуулаад 6 сар тутамд явах ёстой энэ тодорхой энэ графикайх нь дагуу явуулах тал дээр онцгой анхаарал хандуулах нь зөв байна гэдэг эхний санал байгаа юм.

Хоёрт нь мал эмнэлгийн үйл ажиллагааны энэ хяналт зохион байгуулалтын асуудлыг үндсэндээ орон нутаг руу шилжүүлэх орон нутгийн мал эмнэлгийн байгууллагууд өөрсдөө бие даах, ингээд энэ мал эмнэлгийн үйл ажиллагаагаараа

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

дамжуулаад хэрвээ тухайн бүс нутагт нь хариуцсан бүс нутагт нь ямар нэгэн асуудал гарах юм бол тухайн бас энэ орон нутгийн удирдлага нь өөрсдөө бас хариуцлага тооцоод явдаг иймэрхүү жишиг рүү орохгүй бол эзэнгүй байгаа энэ асуудлаас болоод хийх ёстой энэ асуудлууд нэр төдий ийм бас байдлуудаас бий болсон бас болоод асуудлууд явж байна. Ингээд цаашлаад экспортын асуудал, хүн амын хүнсний аюулгүй байдлын асуудал гээд олон асуудлын суурь болж байна. Тэгэхээр энэ дээр бас цаашдаа нэлээн гол анхаарал хандуулаад ажиллах дээр бас анхаарах нь зөв гэж бодож байгаагаа хэлье ээ.

Хоёрт нь энэ газар тариалангийн салбарыг бид бүхэн бас харахдаа экспорт руу чиглүүлнэ ээ гэж байгаа маань зөв. Энэ дундаа бас нэр төрлийг илүү олон болгож байгаа, экспортын чиг баримжаатай байгаа, шинээр бас янз янзын баримал ургамлуудыг бас тариалж байгаа руугаа нөгөө энэ шатахууны урамшуулал, бордооны урамшуулал, үрийн энэ дэмжлэгүүдээ чиглүүлэх энэ бас байгаа энэ бололцоо энэ урамшууллаараа шинээр гарч ирж байгаа энэ өрсөлдөөнийг бий болгох энэ чиглэлийн бодлогууд руугаа явуулах бас цаг нь болсон. Тэгэхээр энийг илүү үр бүтээлтэй болгох талын чиглэл дээр бас анхаарах нь зөв гэж бодож байна.

Хүнсний ногоо тариалагч тариалан эрхлэгч нартаа бас тодорхой хэмжээнд дэмжиж байгаа. Энэ жилийн бас тариалалтын ажлуудыг ил тод бас ийм ийм дэмжлэгүүд байна гэдгээ ингээд 3, 4 төрлөөр нь зарлаад энэнийхээ үр дүнг бас хэмжээд явах нь зөв гэсэн энэ саналыг бас анхаараарай.

Экспортын асуудал дээр Евро Азийн хэлэлцээрийг тусад нь ажлын хэсэг гаргаад ажиллаж байгаа нь маш зөв санаачилга байна. Ялангуяа та бас зүүн бүсээс сонгогдсон гишүүний хувьд бол энэ Ульхан боомт бас хэд хэдэн энэ боомтуудаар дамжуулж шинэ гарцуудыг нээх чиглэлийн ажлууд дээр бас магадгүй 2-3 жилийн цаадхыг харж тодорхой ажлуудын төлөвлөгөө юмнуудыг гаргаж бас ажиллах цаг нь болсон. Ингэж байж зам, дэд бүтцийн боломжуудаа ашиглаад энэ Евро Азийн хэлэлцээртэй холбогдолтой тодорхой ажлууд бас явах нөхцөлүүд бүрдэнэ ээ. Тийм учраас энэ ажлууд дээр бас онцгой анхаарал хандуулаарай гэсэн саналыг бас ажил эхэлж байгаа энэ цаг үед бас хэлье ээ.

Б.Бейсен: Мэдээлэлтэй холбоотой гишүүд саналаа хэллээ.

Би санал хэлчихье. Түрүүн Мандхай гишүүн ярьж байх шиг байна. Нөгөө энэ сонсгол явуулна гээд. Сонсгол чинь Улсын Их Хурлын хяналтын сонсгол зохион байгуулах журам гээд байгаа 119 дүгээр зүйл дээр байгаа. Энд бас Улсын Их Хурлын 15-аас доош гишүүн, эс үгүй бол цөөнхийн бүлэг хүсэлтээ Улсын Их Хурал гаргаж байж явах ёстой. Хуулийн дагуу явуулбал бид нар энэ зүгээс татгалзах зүйлгүй. Бас дэд хороо бас явуулж болох юм байна.

Энэтэй холбоотой энэ Хөдөө аж ахуйн яамнаас төслөө шалгаруулаад банкнууд дээр өгчихдөг. Банкнүүдэд тухайн иргэнд өгдөггүй өөр хүнд өгчихдөг тийм асуудал гарсан. Өлгийн 5 дугаар багийн Ихбулан дээр газар тариалан хийлгэгчхсэн Козбай гэдэг хүн сая бид нарт яасан тэрбум 600 сая гэл үү тийм юуны зөвшөөрөл олгосон байна. Гэтэл бид нар банкнууд байхгүй ээ, эх үүсвэр байхгүй байна гээд өгөхгүй байна гэсэн тийм асуудал гомдол ярьсан шүү.

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Тэгэхээр энэ асуудлууд дээр бас үнэхээр одоо улсын тусламж энэ тэр авчхаад 5 жилийн асуудлыг сонсгол сонсьё гээд энд. Уг нь олон ч үйлдвэр хүлэмж босчихоор юмнууд байгаа. Бас төсөл, хөтөлбөр авчхаад зарим нь хийдэггүй тийм асуудлууд бас байгаа. Тэгэхээр энэ тал дээр анхаарна биз. Бас энэ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн Есөн-Эрдэнэ нар бас туршлага тай улсууд. Тэгээд бас мэргэжлийн сайдууд хариултаас харж байхад ер нь урд Байнгын хороондоо, дэд хороонд ажиллаж байсан, ажлын хэсэгт ажиллаж байсан туршлагатай хүн очсон гээд бид нар баярлаж байгаа манай Байнгын хорооны хувьд. Тэгээд танд бас ажлын амжилт хүсье. Бас анхаарч сая гишүүдийн тавьсан асуулт, зөвлөмжийг хүлээж авч ажиллана гэдэгт итгэлтэй байна. Баярлалаа.

Гишүүд санал хэлж дууслаа. Ажлын хэсэгт баярлалаа. Дараагийн асуудалд оръё.

13.22 цаг

Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг хэлэлцье.

Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн талаарх тайланг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Баттөмөрийн Энхбаяр танилцуулна.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнууд танилцуулъя.

Г.Эрдэнэбат Улсын Их Хурлын Тамгын газрын Дэд дарга, Б.Алтантуяа Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын зөвлөх, Б.Энхбаяр Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Ч.Бат-Эрдэнэ Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын газрын дарга, Б.Анар Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч. Анар байна уу? Байна шүү. Б.Дашпүрэв Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ш.Батбаяр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, М.Баяраа Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Т.Жамбалцэрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Б.Болор-Эрдэнэ Зам, тээврийн яамны Төрийн захиргаа, удирдлагын дарга, Ц.Уранчимэг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Ү.Ганболд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга. А.Энхманлай Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга.

Энхбаяр сайд мэдээлэл танилцуулъя.

Б.Энхбаяр: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Засгийн газрын 2025 оны 183 дугаар тогтоолоор баталсан Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журмын 6-д заасны дагуу цахим системд хяналтад байгаа Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд хамаарах 55 шийдвэрийн 366 заалтын биелэлтэд 2025 оны жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээний хийсэн дүнг танилцуулж байна.

Хяналт шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд ирүүлсэн тайлан, мэдээллийн их өгөгдлийн дата баазыг ашиглаж хийсэн бөгөөд анхан шатын нэгжээс шат дараалсан үнэлгээний тайлан нэгтгэсэн үнэлгээг хийж гүйцэтгэсэн.

Энэ үйл явцад яам, агентлаг, орон нутгийн төлөөллийг оролцуулснаас гадна Канадын Мерит төсөл, UNICEF, Удирдлагын академийн зөвлөхүүдийн арга зүйн дэмжлэг зөвлөмж, саналыг тусган ажилласан нь анх удаа бүх шатын оролцоог хангасан арга хэмжээ боллоо.

Мөн ажлын бүтээмж, үр дүнг нэмэгдүүлэхэд технологийн дэвшлийг аш ашиглаж тус Байнгын хороонд хамаарах шийдвэрүүдийн биелэлтэд хиймэл оюун ухааныг ашиглан дүн шинжилгээ хийж үзсэн болно. 2025 оны жилийн эцсийн байдлаар тус Байнгын хорооны 55 шийдвэрийн 366 заалтыг яам, агентлаг, нийслэл, аймаг хэрэгжүүлж ажилласан хувь 73 хувь байна. Нийт 190 заалт хэрэгжсэн. 130 заалт хэрэгжих шатад байна. Үүнээс удаашралтай эрчимжүүлэх шаардлагатай 33 заалт, хэрэгжээгүй 29 заалт байгаагаас 25 нь удирдлага зохион байгуулалтаас, 4 нь санхүү, хөрөнгө оруулалтаас шалтгаалсан байна.

Хугацаатай өгөгдсөн оны төгсгөлд гарсан буюу хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 12 заалт байна. Мөн хэрэгжүүлэх хугацаа, чиг үүрэг тодорхойгүй, зардал, санхүүгийн эх үүсвэр, хийх ажил, зорилго тодорхойгүй, хэмжигдэхүйц биш байдлаас үүдэн 5 шийдвэр хэрэгжих боломжгүйгээр дүгнэгдсэн байна.

2025 оны жилийн эцсийн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнд үндэслэн бүрэн хэрэгжсэн, бодит шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй болсон, цаг хугацааны хувьд ч ач холбогдолгүй болсон, тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан, тухайн шийдвэр хүчингүй болсон зэрэг шалтгаанаар 190 заалтыг Засгийн газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сангийн хяналтаас хасах үндэслэлтэй гэж үзэж Байнгын хорооны хуралд танилцуулж байна.

Тайлант онд хэрэгжээгүй шийдвэрүүд нь төрийн байгууллагуудын удирдлага зохион байгуулалт хангалтгүйгээс шалтгаалсан гэж дүгнэгдэхээр байна. Тухайлбал, төрийн байгууллагуудын түвшинд хариуцлагын тогтолцоо хангалттай бүрдээгүй, салбар хоорондын ажлын уялдаа сул, олон удаагийн бүтцийн өөрчлөлт хийгдсэн, төсөв, хөрөнгө оруулалтын эрэмбэ дараалал хангалтгүй, бодлогын болон хүний нөөцийн тогтворгүй байдал зэрэг нь хууль тогтоомжийн биелэлтэд сөргөөр нөлөөлж байна.

Иймд Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтийн 2025 оны жилийн эцсийн тайланг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэнтэй холбоотойгоор Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт дараах арга хэмжээ авахыг даалгасан. Үүнд:

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтийг эрчимжүүлж, салбар хоорондын уялдааг ханган бодитой үр дүнтэй хэрэгжүүлэх;

Салбарын хэмжээнд хэрэгжүүлж байгаа хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгч, иргэдийн ахуй амьдрал болон салбарын хөгжлийн үзүүлэлтэд хэрхэн нөлөөлж буйг үнэлж тооцож ажиллах;

Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн төслийг боловсруулахдаа зохицуулалт, утга агуулгын хувьд давхардал, хийдэл, зөрчилтэй шийдвэр гаргахгүй байх, санхүүгийн эх үүсвэрийг тусгах, хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт хэрэгжихүйц байхад анхаарах. Дижитал хяналт хийх өгөгдөл суурьшсан үнэлгээ хийх. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтийг бодит цагт хянах, ил тод болгох чиглэлээр цахим шинэчлэл хийх санал боловсруулалт танилцуулах;

Мөн хууль тогтоомжийг хангалтгүй биелүүлсэн албан тушаалтнуудад зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад даалгасан.

Цаашид Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлогыг эргэн харах, шинэчлэх, сайжруулах үндэслэл бий болсныг харуулж байна.

Хууль тогтоомжийн биелэлттэй холбоотойгоор Улсын Их Хурлын түвшинд анхаарах бас асуудлууд байна. Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог, сонгогддог байгууллагуудад үүрэг даалгавар болгосон шийдвэрийн хэрэгжилтийг хангах, биелэлтийг тайлагнах үйл ажиллагааг гүйцэтгэх засаглалын байгууллагын түвшинд уялдуулах, нэгдсэн байдлаар тайлагнах боломжоор бүрдүүлэх

Улсын Их Хурлаас гарч байгаа шийдвэрийн талаар нэгдсэн бүртгэлийн систем үүсгэж, Засгийн газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сантай уялдуулах, гарч байгаа шийдвэрийг шуурхай дамжуулах, хяналтад авах, Улсын Их Хурлын Байнгын хороо, гишүүдийн түвшинд шийдвэрийн хэрэгжилтийн явцыг цахим систем ашиглан улирал тутам танилцах боломжтой болох

Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчил болон тухайн жилд бүрэн хэрэгжсэн болон бусад шалтгаанаар хяналтаас хасуулах шийдвэр заалтын талаар Засгийн газартай тогтмол хамтарч ажиллах

Хууль тогтоомж, Улсын Их Хурлын тогтоол, Байнгын хорооны шийдвэр, Засгийн газрын бодлогын баримт бичигт заасан зарим заалт агуулгын хувьд давхцаж, хуулиар ноогдуулсан чиг үүргийг дахин тогтоол хэлбэрээр албажуулах зэрэг зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16.1-д Улсын Их Хурлаас Засгийн газар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагад хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон энэ хуулийн 10 дугаар зүйлд зааснаас бусад Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг ээлжит чуулган эхлэхээс 15 хоногийн өмнө Улсын Их Хуралд ирүүлнэ гэж заасан нь цаг хугацааны хувьд үр дүнд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд хангалтгүй байгаа тул хугацааг уян хатан зохицуулах шаардлагатай байна.

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Тус Байнгын хороонд хамаарах шийдвэрийн биелэлтэд анх удаа хиймэл оюун ухааныг ашиглан дүн шинжилгээ хийлээ. Нийт 366 заалтын 0.3 хувь нь хуулиар ноогдуулсан чиг үүргийг дахин үүрэгжүүлсэн, 31.1 хувь нь тогтоолын хэрэгжилтийг давтан баталгаажуулсан заалт, 4.6 хувь нь бодлогын баримт бичгийн агуулгын огтлолцолтой заалтууд тус тус эзэлж байна.

Цаашид Улсын Их Хурлын холбогдох бүтцийн нэгжтэй хамтран хиймэл оюун ухааныг ашиглаж, дүн шинжилгээ хийх ажлыг улам боловсронгуй болгож, Улсын Их Хурлаас гарч байгаа шийдвэрийн биелэлт, үр нөлөө, хяналтыг сайжруулахыг хичээж байна.

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хороонд хамаарах хууль, тогтоолын биелэлтийн 2025 оны жилийн эцсийн хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийг хавсаргасан болно. Баярлалаа.

Б.Бейсен: Мэдээлэл танилцуулсан Энхбаяр сайдад баярлалаа. Мэдээлэлтэй холбогдуулан асуултаа асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Ганхүлэг гишүүн. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя. Дарааллаар орж байгаа юм байна. Ирсэн бүрдсэн.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлт дундаж 54.6 хувь, Байнгын хорооны тогтоол 51.9 хувь байна л даа. Яагаад хэрэгжихгүй байгаа вэ гэдгийг л асуух гээд байгаа юм. Маш бага үзүүлэлттэй байна. Төр засаг тогтворгүй байгаатай холбогдоод байгаа юм уу, эсвэл яаман дээр юм уу, эсвэл хэрэгжүүлж байгаа субъектүүд нь мэргэжлийн бус байгаад байгаа юм уу, эсвэл төрөөс гарч байгаа шийдвэр та бүхний үйл ажиллагаанд нөлөөлөөд байгаа юм уу? Яг энийг үнэн бодитоор нь хэлээд өгөөч ээ гэдэг ганцхан асуулт.

Б.Бейсен: 6 номер хариулъя. Албан тушаал албан тушаал хэлээрэй.

Ч.Бат-Эрдэнэ: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Бат-Эрдэнэ байна. Бид нар энэ хяналт шинжилгээ, үнэлгээний дүгнэлттэй холбоотой хэд хэдэн зүйл дээр бас хэрэгжих хэрэгжилт хангалтгүй ийм нөхцөл шалтгаанууд үүсээд байна гэдгийг бас тайлан дээрээ оруулж өгсөн байж байгаа. Энэ дээр хамгийн чухал асуудал нь хариуцлагын тогтолцоо хаа хаанаа хангалтгүй байна гэдэг ийм дүгнэлт гаргаж байгаа. Салбар хоорондын ажлын уялдаа бас сул байна гэдэг.

Мөн энэ бүтцийн өөрчлөлтүүд бас ялангуяа салбарын яамд дээр бол бас давтамжтай хийгдээд байгаа. Тэгэхээр энэ дээр бол бас, тодорхой хэсэг нь бол төсөв, хөрөнгө оруулалтын эрэмбэ дараалал хангалтгүйтэй холбоотой ийм нөхцөл байдлууд байгаа. Мөн энэ хүний нөөцийн тогтворгүй байдал гэдэг энэ зүйл дээр бид нар цаашид анхаарах шаардлагатай гэсэн ийм дүгнэлтэд хүрсэн.

Тухайлах юм бол бид нар тухайн Байнгын хороотой холбоотой Засгийн газрын түвшинд хэрэгжилт маань 71 хувийн хэрэгжилттэй гэдэг үнэлгээ өгч

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Засгийн газрын хуралдаанд танилцуулагдаж тайлан маань ирсэн. Манай Их Хурлын Хяналт шинжилгээ, үнэлгээний нэгжээс тухайн хэрэгжилтийн хувь маань бол буурч орж ирсэн.

Гэхдээ 24 он болон 25 оны хагас жилийн хэрэгжилтээс 29.4 хувиар хэрэгжилт маань сайжирч ингэж орж ирж байгаа. Тэгээд бид нар цаашдаа энэ сая манай Хэрэг эрхлэхийн сайдын танилцуулгад дурдсанаар хэд хэдэн чиглэлд бас энэ үйл ажиллагаагаа сайжруулах хэрэгжилтээ бол бас үр нөлөөг нэмэгдүүлэх энэ чиглэл дээр бас анхаарч ажиллана гэсэн ийм дүгнэлтүүд гарсан байж байгаа.

Б.Бейсен: Гомбын Ганбаатар гишүүн асуулт асууя.

Г.Ганбаатар: Энэ ноднин бас л энэ асуудал орж ирж байсан? Хэлж л ярьж л байсан. Энэ шийдвэрийн биелэлт гэдэг юм үнэхээрийн хангалтгүй байх юм. Үндсэндээ сая сайдын танилцуулсан чинь манай Байнгын хороотой холбоотой 55 шийдвэр, 366 заалт түүнээс эрэгдсэн хэрэгжсэн 190, хэрэгжих шатдаа 130, хэрэгжээгүй 29, 4 нь санхүү, хөрөнгө оруулалт болон ингээд зохион байгуулалттай холбоотой л гээд. Сая хариулж байгааг нь бас сонсож байхад энэ салбар хоорондын уялдаа, бүтцийн өөрчлөлт, төр засгийн тогтворгүй байдал бүгд л нөлөөлж байгаа байх.

Одоо цаашдаа энийгээ хэрэгжүүлэхээр яг юу хийж байна вэ гэдгийг саяынхаа тэр 6 номер бас нэлээн дэлгэрэнгүй ярих хэрэгтэй. Бид энд шийдвэр гаргаад л байдаг хэрэгжилт нь иймэрхүү байх юм ямар хэрэг байх вэ дээ. Энэ чинь 51.9 хувьтай гэж байна шүү дээ. Яг ялангуяа манай Байнгын хорооны нийлээд дунджаар 54.6 л юм байна тээ? Яг Байнгын хорооны тогтоолтой холбоотой ингээд юуг нь харж байсан.

Тэгэхлээр чинь ингээд 100 хувь ажил төлөвлөхөд дөнгөж 50 нэмэх гараад байвал ямар байх вэ, цаашдаа юу хийх юм гэдгээ л яривал их сайн байна. Бид нарын зүгээс бас Улсын Их Хурлын зүгээс анхаарах юм юу байна вэ? Сая яах вэ мэдээлэл хийсэн сайдын юунд гарч л байна л даа Улсын Их Хурал, Засгийн газрын уялдаатай холбоотой. Бид бас бодох юмнууд байна. Энд нөгөө шийдвэр гаргаж байгаа түвшиндээ бид цаашдаа юу анхаарах юм? Энэ дээр их тодорхой хариулж өгөх хэрэгтэй байна.

Б.Бейсен: 6 номер хариулъя.

Ч.Бат-Эрдэнэ: Гишүүний асуултад хариулъя. Цаашдаа бидэнд хэд хэдэн чиглэлээр анхаа гарах ийм асуудлууд байгаа. Хамгийн эхлээд бид нар энэ үнэлгээний арга, аргачлалаа маш тодорхой болгох шаардлагатай юм байна гэж үзсэн. Үндсэндээ 2013 оноос хойш өнөөдрийг хүртэл бид нарын энэ Улсын Их Хурлын түвшинд, Засгийн газрын түвшинд хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээг тооцож байгаа энэ арга, аргачлалаа бид нар боловсронгуй болгож чадаагүй байж байгаа. Зохион байгуулалтын ийм өөрчлөлтүүд хийгээд өдийг хүрсэн байж байгаа.

Тэгэхээр бид нар цаашдаа яг энэ үнэлж байгаа арга, аргачлалаа бол бас сайжруулъя гэж ийм чиглэлээр бас ажиллаж байна. Дараа нь бол энэ хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах яг энэ чиглэлээр мэргэшиж ажиллаж байгаа энэ албан хаагчдыг тогтвортой байлгах энэ хүмүүсээ бас тодорхой чадавхжуулах

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

энэ асуудал дээр анхаарах шаардлагатай юм байна гэж үзээд Канадын “Мерит” төсөлтэй хамтраад энэ рүү бас тодорхой ажлууд хийгдэж байна.

Хамгийн чухал зүйл нь юу байна гэхээр энэ цахимжилтын асуудал байж байгаа. Засгийн газрын түвшинд 5600 орчим заалтыг улсын хэмжээнд бид нар хяналтад аваад ингээд хэрэгжилтийг нь тооцоод ажиллаж байгаа юм. Тэгэхээр энэ дээр сүүлийн жилүүдэд гарч байгаа Засгийн газрын түвшинд гарч байгаа шийдвэрийн тоо маань бол эрс нэмэгдээд байгаа. Тэгэхээр бид нар энийг бол бас хиймэл оюун ухаан, их өгөгдөлд суурилсан энэ байдлаар хянах энэ боломж, бололцоог бүрдүүлэх чиглэлээр бас энэ системээ, хяналтын системээ сайжруулах ийм шаардлага урган гарч байгаа.

Нөгөө талд нь энэ гарч байгаа шийдвэрүүдийг өмнө нь яг энэ чиглэлээр гарсан шийдвэр байна уу? Энийг бас бид нар шүүж үздэг, шүүлтүүртэй ханддаг энэ асуудал маш чухал байж байгаа. Маш олон салбар дээр бол өмнө нь гарсан агуулгын хүрээнд, өмнө гарсан чиглэлийн хүрээнд шийдвэрүүд маань давтагдаж гараад байгаа. Тэгээд өмнөх хэрэгжилт нь ямар байгаа юм бэ гэдгээ үнэлж дүгнэлгүйгээр дараагийн шийдвэрүүд гараад байгаа ийм зүйлүүд байгаа. Тэгэхээр бид нар бас энэ түвшиндээ нэлээн анхаарч ажиллах шаардлагатай юм байна гэж ингэж үзсэн. Тэгээд Их Хурлынхаа бас энэ цахим системтэй Засгийн газрын inelgee.gov системийг холбох, Байнгын хороодоо тухай бүр бас мэдээллээр хангадаг, Байнгын хороодтойгоо хамтраад гарсан шийдвэрийнхээ хэрэгжилтүүдийг бодит цаг ийн горим дээр бол бас хүссэн үедээ орж харах ийм боломж, бололцоог бүрдүүлэх чиглэлээр бас бид нар анхаарал тавиад ингээд ажиллаж байгаа гэдгийг бас гишүүнд хэлье ээ. Баярлалаа.

Б.Бейсен: Ганхүлэг гишүүн тодруулъя.

М.Ганхүлэг: Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээн дэх Улсын Их Хурал болон Байнгын хорооноос өгсөн энэ асуудлуудын хэрэгжилт 54.6 хувьтай гэдэг ийм дүгнэлт гарсан байна гэдгийг тайланд тусгажээ. Ингээд дотор нь задлаад асуувал зөндөө олон юм зүйлүүд байна.

Гэхдээ хэдүүлээ ингээд нэр төдий ингээд жил болгон тодорхой асуудлаа ингээд яриад л, заримыг нь хасъя, хугацаа нь дууссан, хэрэгжээгүй гэдэг ийм байдлаар энэ асуудлууддаа хандаад яваад байх уу гэдэг эхний асуулт дээр гишүүдтэй санал нэг байгаа юм.

Цаашдаа яах вэ гэх гэхээр ингээд хиймэл оюун ухаан гээд иймэрхүү зүйл яриад байна л даа. Тэгээд энийгээ илүү тодорхой болгох энэ чиглэлийн ажлуудыг хиймээр байна. Түүнтэй холбогдолтой хэрэгжүүлэх арга хэмжээтэй холбогдолтой нарийвчилсан юмнуудыг бас хэдүүлээ сайн ярих хэрэгтэй байна. Өмнөх өмнөх жилүүдийн ийм үзүүлэлтүүд дээр яг хариуцлага тооцсон ийм кэйсүүд байдаг юм уу ажлаас чөлөөлсөн, эс үгүй бол яг энэ ямар хуулиар ямар процессоор асуудалд яг ханддаг юм? Тэр хуулийн тодорхой энэ боломж, бололцоог нь хэрэг эрхлэхийнхэн маань та бас яг хэлээд өгөөч. Яаж энэ хүмүүсийг ингээд бид нар 50 хэдэн хувьтай ажиллаж байна гээд ингээд зүгээр хараад суугаад байх юм бэ гэдэг эхний ийм асуулт байгаа юм. Үнэхээр яг ажлаас чөлөөлсөн тодорхой асуудал дээр ийм ийм хариуцлага тооцсон гэдэг тэр тодорхой ийм тоо, кэйс яг хэлээч? Энэ асуудал дээр үндэслээд ийм арга хэмжээ авсан гээд.

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Хоёрт нь ингээд дотор нь задлаад ингээд харах юм бол тайлагнаагүй нэлээн олон асуудал байж байгаа юм. Тэгээд ямар учир шалтгаантай гэж тийм тайлбар байхгүй. Зүгээр л ийм заалтыг хэрэгжүүлсэн, хэрэгжүүлээгүй гэдгийг тайлагнаагүй. Тэгэхээр энэ ямар үндсэндээ шалтгаанаар тайлагнаагүй гэдгийг нь ингээд хүлээж аваад энэ дээр ямар ч дүгнэлт байхгүй орж ирж байгаа юм бэ? Нэлээн олон асуудал байна.

Жишээ нь гэх юм бол Хүнсний тухай хууль, Малын генетик, нөөцийн тухай хууль дээр маш тодорхой заалтууд хүнсний аюулгүй байдлыг ингэж ханга гээд заачихсан. Тайлагнаагүй ээ гэдэг ийм тайлан орж ирж байна шүү дээ. Тэгэхээр одоо яг яах юм гээд? Ингээд дотор нь задлахаар зөндөө олон юм байна. Цаг хугацааны хувьд ач холбогдолгүй гэж дүгнэсэн гэж байгаа юм. Одоо тэгээд цаг хугацаа нь ач холбогдолгүй болчихоод зүгээр хасчихъя гэнэ ээ. Тэгэхээр чинь ингээд энэ чинь хэн нэгэн хүний хариуцлагын асуудал үүний цаана яриад байна шүү дээ. Цаг хугацаанд нь хийхгүй яасан юм бэ тэгээд одоо ингээд хасчихаар энэ асуудал нь шийдэгдчих юм уу гэдэг ийм асуудал. Тэгэхээр ингээд нарийвчлаад ярих юм бол зөндөө олон асуудлууд бас байна.

Мөн дээрээс нь цаашид арга жуух хэрэгжүүлэх арга хэмжээтэй холбогдолтой, ер нь бид нар энэ бүтээмжтэй холбогдолтой асуудал дээрээ яг яаж ажиллах юм бэ? Энэ бүтээмжтэй байгаа гэж үзээд энэ ажлын хоногийг 5 байгааг 4 болгох гээд байна уу? Дахиад дээрээс нь тайлан авахгүй гэхээр энэ тайлангаа бид нар цаашдаа яаж дүгнэдэг болох юм бэ? Төрийн албан хаагчдаас тайлан авахгүй гэж байгаа нь нэг талдаа зөв боловчиг нөгөө талдаа энэ миний ойлголтоор энэ тайлангуудыг л ингэж нэгтгэхгүй л болно л гэсэн үг л санаа яваад байгаа шүү дээ шиг байна. Тэгэхээр энэ зүйлүүдийн уялдаа нь яаж гарч ирж байгаа юм бэ?

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? Сайд хариулъя Энхбаяр сайд.

Б.Энхбаяр: Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Үнэхээр төрийн ажил бас тогтвортой, залгамж халаатай байж байж бид бас үр дүн, гүйцэтгэл хүлээнэ. Нөгөө талаас бүтэц, зохион байгуулалтын хувьд оновчтой байж байж бид сайн гүйцэтгэл хүлээнэ. 3 дахид бид сайн чадварлаг, мэргэшсэн туршлагатай хүний нөөцтэй байж байж мөн сайн үр дүнг хүлээнэ.

Бид шинэ Засгийн газар байгуулагдаад 2 жил хүрэхгүй хугацаанд 3 дахь засгийн газраа байгуулагдаад ажиллаж байгааг та мэдэж байгаа. Бодлогын тогтвортой байдал байхгүй. Тэр дотроо хяналт мониторингийн нэгж өнгөрсөн хугацаанд Засгийн газрын түвшинд Мэргэжлийн хяналтын газар багтан буугдсан, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэгч агентлаг гэж байгуулсан. Энэ байгууллага байгуулагдсантай холбоотойгоор Засгийн газрын түвшинд, Хэрэг эрхлэх газрын түвшинд ярьж байгаа би Хяналт шинжилгээ, мониторингийн нэгж байхгүй болчихсон хүмүүс нь. Өнгөрсөн 2 жил бол ийм хяналт мониторингийн нэгжгүй явж ирсэн байх бүүр. Тэгэхээр энэ төрийн бүтцийн зохион байгуулалтын тогтворгүй байдал өөрөө юунд нөлөөлж байна вэ гэдгийн нэг жишээ энэ.

Тэгэхдээ энэ нь дахиад бүтэц байгуулж байж үр дүнд хүрнэ гэж би ерөөсөө хэлэхгүй байгаа. Монгол Улсын Ерөнхий сайд бол саяын хэлсэнчлэн төрийн жинхэнэ албан хаагчдын ажлын байран дээр зураглал хийж үзээд байна. Тэгээд энэ зураглалыг хийж үзэхээр энэ яг анхан шатад ажиллаж байгаа албан хаагчдын

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

чинь ажлын 50 хувь нь тайлан, бичиг баримт тайлагнах дээр л ерөөсөө зарцуулагддаг. Зохиомол ачаалал бий болоод байна.

Тэгэхээр цаасанд дарагдчихсан, ажлын стресстэй хүнээс бүтээмж гарахгүй. Эрүүл саруул, толгой сийрэг байж байж хүний толгой ажилладаг. Зохиомол ийм юманд ингээд төр бүхэлдээ ингээд шат шатандаа ингэж бас дарсан байна гэж үзэж байгаа юм. Тийм учраас тэр уурагт тархийг нь боомилоод дараад байгаа цаасыг нь хөнгөвчилье гэж байгаа юм. Энэ нь болохоор огт тайлан гаргахгүй гэсэн үг биш. Одоо энэ төрийн их өгөгдлийн дата мэдээлэл дотор бол төрийн албан хаагчдын өдөр тутам тайлан, мэдээлэлд ордог энэ дата мэдээллүүд бүгд байгаад байгаа юм.

Тийм учраас угаасаа өөрөө компьютероосоо үзчихэж болох ийм олон мэдээллүүдийг тийм бичмэл байдлаар шат шатдаа доороос эхлээд ингээд дээшээ ингээд тайлагнадаг, ирсээр байгаад ийм зузаан цаас хамгийн сүүлд даргын ширээн дээр ирдэг. Дарга ерөөсөө уншдаггүй, гүйцэтгэл байхгүй, ямар ч ач холбогдолгүй ийм зохиомол ачаалал руу бий болчихоод байгаа юм.

Тийм учраас энийг хөнгөвчлөөд ийм цаасаар ерөөсөө мэдээлэл авдаг юмыг ер нь Ерөнхий сайд больё гэж байгаа юм. Тийм ч учраас өнгөрсөн 7 хоногийн Засгийн газрын хуралдаан дээр энэ асуудлыг шийдвэрлэсэн. Мөн үүнтэй холбоотой төрийн жинхэнэ албан хаагчдыг энэ амралтын өдрүүдээр илүү цагаар ажиллуулдаг энэ юмаа ер нь бас юу яагаач ээ, ер нь дэлхийн бус улс орнууд ч байна илүү үр дүнтэй, гүйцэтгэлтэй байхын тулд тэр албан хаагч маань эрүүл саруул байх ёстой. Та бүхэн зүгээр хүмүүсийг харах хэрэгтэй шүү дээ. Одоо ингээд яг төрийн жинхэнэ албан хаагчдыг ингээд хараад байхад ингээд зовхи нь унжчихсан, харц нь доошоо, нүдэнд нь гал ингээд унтарчихсан. Тэр зохиомол хэтийдсэн ачааллаар дараад байгаа байхгүй юу хүнийг. Ар гэр байхгүй, амьдрал байхгүй, цалин хөлс багатай. Тийм учраас бид энэ төрийн албаны тогтолцоо дээр Засгийн газрын Хэрэг эрхлэхийн сайдад Ерөнхий сайд Нийтийн албаны хуулийг шинэчлэн боловсруулах үүрэг өгсөн байгаа.

Б.Бейсен: Ганхүлэг гишүүн тодруулъя.

М.Ганхүлэг: Тийм тодорхой асуултууддаа бас хариулт авъя. Сүүлийн бүх л Засгийн газарт та бас байгаа учраас Засгийн газар ер нь тогтвортой, тогтворгүй байгаа энэ асуудалд хэрэгжилт нь бас муу сул байгаа гэдэг асуудал дээр бултах, булзааруулах зүйл бас би бас байхгүй болов уу гэж бодож байна. Цаашдаа бас энэ асуудлуудыг яаж шийдэх вэ гэдэг дээр тодорхой саналуудыг, шийдлүүдийг бас та бүхэн маань бас хэлэх хэрэгтэй байна.

Жишээлэх юм бол, үндсэндээ энэ тайлагнаагүй гэсэн энэ маш олон заалтууд орж ирж байна. Хууль батлагдаад энэ асуудлыг зүгээр тайлагнахгүй байж болох юм уу тээ? Болж байгаа бол ямар хариуцлага хүлээх юм, яах юм гэдэг дээр ямар арга хэмжээ авч байгаа юм бэ гэсэн асуулт байгаа.

Хоёр дахь нь хугацаа нь дууссан гэдэг. Хугацаанд нь амжуулаагүй байгаа байхгүй юу. Тэгэхээр яах юм бэ? Нэлээн олон бүлэг асуудлууд орж ирж байгаа. Ер нь өмнөх өмнөх асуудлууд дээр энэ мэт тодорхой асуудлууд тулгарахад ямар кэйс хариу арга хэмжээ авсан юм бэ гэдгийг яг.../минут дуусав./

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Б.Бейсен: 5 номер хариулъя.

Т.Жамбалцэрэн: Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жамбалцэрэн.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хувьд 2025 оны жилийн эцсийн байдлаар хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн салбарын үнэлгээ 80.4 хувиар үнэлээд тэгээд холбогдох тайлангаа Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн. Хяналт хэрэгжүүлэх газраас үнэлээд 69.8 хувь гээд үнэлээд ирж байгаа юм. Нийтдээ 277 хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 727 зүйл заалтаар ингээд тайланг гаргаж ирүүлж байгаа юм.

Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, Байнгын хорооны биелэлтүүд гээд ялангуяа тайлангийн биелэлтээр Байнгын хорооноос өгсөн мэдээлэл дээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар дээр биелэлт гараагүй, хэрэгжээгүй гэдэг агуулгуудтай заалтууд.../минут дуусав./

Б.Бейсен: 5 номер гүйцээж хариулъя.

Т.Жамбалцэрэн: Тэгээд энэ зүйл, заалтуудыг нь ингээд тайлагнаагүй гээд харахаар хэрэгжүүлээд бүрэн хэрэгжээд тайлагналтын системээс хасчихсан зүйлүүд бас нэлээн давхардаад ороод ирсэн байгаа юм. Тэгэхээр энэ зүйлүүдийг бас эргэж хармаар юм шиг бас бодол төрж байгаа юм.

Нөгөө талдаа яамнууд тайлан, мэдээллүүдээ өгөөд ингээд гаргаад яваад байдаг. Тэгээд Засгийн газрын жилийн эцсийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайлан авах системд энэ заалтууд тодорхой ингээд орчихдог. Тэгээд системд ороогүй заалтууд маань энэ дээр тайлагнагдаагүй гэдэг байдлаар гараад ирсэн. Энэ ажлууд нь хийгдээд бүрэн хаагдаад зарим нь энэ системээс хасагдсан заалтууд байгаад байгаа юм. Дээр нь Их Хурал дээр бид нар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар тайлан хүргүүлэхдээ Засгийн газрын тогтоолоор баталсан журмын хүрээнд тайлагналтуудыг хийж байгаа. Тэгээд яг ямар бай байдлаар Их Хурал дээр, Их Хурлын Тамгын газар дээр дүгнэгдээд ямар журмаар орж ирж байгаа гэдэг нь бас их тийм ойлгомжтой болмоор байгаа юм. Тэгэхээр.../минут дуусав./

Б.Бейсен: Ганхүлэг гишүүн тодруулъя.

М.Ганхүлэг: Яах вэ тодорхой хариултаа тавиад чадахгүй л байгаад байна. Ер нь иймэрхүү байдлаар яваад байх уу гэдэг дээр та хэд маань бас сайн бодоорой.

Хоёр дахь нь яг тодорхой хариуцлага тооцсон ийм кэйсүүд байна уу гэдгийг би Хэрэг эрхлэхээс асуугаад байгаа юм. Тэр дээр тоон үзүүлэлттэй ийм ийм байдлаар арга хэмжээнүүд авсан гэдэг дээр. Хэрвээ тэгэхгүй бол хэдүүлээ ингээд тайлан гаргаад нэг нэгэндээ үндсэндээ ингээд асуулт, хариулт болоод явахын хэрэг байхгүй ээ.

Энхбаяр сайдын хувьд тэр төрийн албан хаагчдын ачааллыг, тайлан гаргаж байгаа ачааллыг бууруулъя гэдгийг би бас дэмжиж байгаа. Зөв өө. Гэхдээ яах вэ ингээд ийм тайлангууд цахимаар ирчих юм байна, зохион байгуулалт нь арай өөр

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

болох юм байна тэгээд илүү сайжрах болов уу л гэдэг ийм бодолтой байна. Тэгэхдээ яг энэ хэмжээний тайлан юмнууд бас яаж өөрчлөгдөх юм гэдэг дээр.

Хоёр дахь нь ямар тооцоо, судалгаа юмаар ингээд бүтээмжтэй байна гэж үзээд байгаа юм уу? 5 өдөр байгааг 4 өдөр болгох тухай асуудал бас ярьж байна. Энийг ямар судлаач нь ямар бас шинжлэх ухааны үндэслэлтэйгээр бас ийм хувилбар нь зөв юм гэж тооцож ямар үр дүнг бас хүсээд байгаа юм бэ гэдгийг тодруулъя.

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? Сайд хариулах уу? Энхбаяр сайд яриулъя.

Б.Энхбаяр: Энэ Засгийн газрын шийдвэр их уян хатан байдлаар шийдвэрлэхээр гарч байгаа юм. Өөрөөр хэлбэл, жишээлбэл эмч, багш гэдэг юм уу энэ тодорхой төрийн тусгай алба байна. Хил, цагдаа, шийдвэр гүйцэтгэл гэсэн энэ бас тусгай албад байна. Зэвсэгт хүчин. Энэ тангараг өргөчихсөн хүмүүсийн хувьд бол нэг өөр. Төрийн захиргааны албаны тухайтад бол тухайн сайд тухайн байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга, байгууллагын дарга нар өөрсдөө нөхцөл байдлаа их сайн үнэлж мэдэрч байгаа. Өөрсдөө. Ажлын байрныхаа нөхцөл байдлыг мэдэж байгаа, ажлын ачааллаа мэдэж байгаа. Тийм учраас цагийн хувьд нэгдүгээрт их уян хатан зохицуулалт хийе гэж байгаа юм.

Б.Бейсен: Хэдэн номер хэнээс асууж байна? Урд 6 номер гүйцээж хариулъя.

Ч.Бат-Эрдэнэ: Гишүүний асуултад хариулъя. Хариуцлага тооцож ажиллаж байна уу гэдэг ийм асуулт байгаа. Энэ дээр түрүүн манай сайдын танилцуулга дээр бас дурдагдсан хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтийн тайлантай холбоотойгоор Засгийн газраас тодорхой шийдвэрүүдийг хуралдаанаас гаргасан. Энд бол бид нар төрийн бүх шатны байгууллагууддаа бас энэ зөвлөмжийг хүргүүлнэ. Энэ зөвлөмжийнхөө дагуу бас хэрэгжилтэд нь хяналт тавих энэ ажлыг хийж байгаа.

Засгийн газраас гарч байгаа шийдвэртэй холбоотойгоор яам, агентлаг, аймгийнхаа түвшинд хангалтгүй хэрэгжүүлж байгаа албан тушаалтнуудад хариуцлага тооцож эхэлсэн. Тухайлах юм бол бас энэ Засгаас гарсан шийдвэрүүд дээр хангалтгүй ажиллаж байсан Эрчим хүчний яам, Сэлэнгэ аймаг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын холбогдох албан тушаалтнуудаас бас Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр хариуцлага тооцох үүрэг өгөгдөөд ингээд явж байгаа. Тэгэхээр энэ хариуцлагын механизм дээр бид нар бас.../минут дуусав.

Б.Бейсен: 6 номер гүйцээж хариулъя. Дараа нь 5 номер.

Ч.Бат-Эрдэнэ: Засгийн газраас гарч байгаа шийдвэрүүдийг хангалтгүй хэрэгжүүлж байгаа энэ байгууллагууд дээр хариуцлагын механизм бас явж байгаа гэдгийг бас та бүхэндээ хэлье. Тэр нь бас томилох эрх бүхий албан тушаалтан нь Төрийн албаны хууль тогтоомжид заасны дагуу бас энэ хариуцлага хүлээлгэх энэ зохицуулалтын хүрээнд бас явагдаж байгаа.

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Тодотгоод хэлэх юм бол яг энэ хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтийн 25 оны жилийн эцсийн тайлан хэлэлцсэнтэй холбоотой орвол бүх яамнуудад, бүх аймгуудад энэ зөвлөмж хүргэгдэж байгаа юм. Тэгэхээр цаашид тодорхой чиглэлүүдээр энэ зөвлөмжийнхөө хэрэгжилтүүдийг бид нар бас хяналт тавиад ингээд явна. Мөн Их Хурлын хяналт шалгалтын нэгж, мөн бид нар хэрэгжилтийг нь хангаж ажилладаг энэ тодорхой институтийнхээ холбогдох нэгжүүдтэй хамтраад хяналт шалгалтын ажлуудыг бас зохион байгуулах ийм ажлуудыг бас ярилцаад ингээд явж байгаа гэдгийг бас танд хэлье ээ. Баярлалаа.

Б.Бейсен: Гишүүд асуулт асууж дуусаж байх шиг байна. Энэ хууль тогтоомжийн биелэлтийн асуудлууд бас муу байна. Энэ сая Энхбаяр сайдын ярьснаар Засгийн газар тогтвортой биш 25 онд бараг 3 Засгийн газар, 3 Их Хурлын дарга солигдчихлоо. Энэнтэй ч холбоотой, тэрэнтэй холбоотой бас ажлын албанаасаа солигдож байгаа асуудал энэ хууль тогтоолын биелэлтэд нөлөөлж байгаа. Гэхдээ Хүнс, хөдөө аж ахуйн яамны хувьд энэ түүхий эд боловсруулах үйлдвэр дээр хуучин Эмээлт, Дархан, Баруун бүс, Ховдод тэгээд Замын-Үүд гээд байж байсан тийм ээ? Замын-Үүдэд тухайн үед бас хөрөнгө оруулалт 6-аас 8 тэрбум билүү тавьж байсан тэнд юм байна уу ер нь? Ийм юман дээр чинь бас анхаараад ажиллахгүй бол болгохгүй асуудал байгаа юм байна.

Нөгөө талаар энэ Туулын хурдны замын асуудал дээр 23 онд Засгийн газар Улсын Их Хуралд оруулаад 39 дүгээр тогтоол батлуулж байсан тийм ээ Энхбаяр сайд? 6 сарын хэдэнд билүү. Тэгээд энэ Байгаль орчны яамны дүгнэлт бас тухайн үед гарчихсан гэсэн. Гэтэл одоо ингээд хөрөнгө зарчхаад энийг эсэргүүцчихээд байна эд нар. Одоогоор бид нар бас Байгаль орчин манай Байнгын хороо яригдах ёстой байсан чинь Байгаль орчны сайд нь түүнд нь хориг тавьсан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас бас комисс гараад ажиллах гэж байгаа юм байна. Энэнтэй холбоотой түрүүн даргын дэргэдэх зөвлөл дээр бид нар танилцуулсан тэгээд хойшлуулчихаад байж байгаа.

Дараагийн асуудал энэ Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаман дээр Аялал жуулчлал, соёл, спорт залуучуудын яамны, Аялал жуулчлалын яамтай холбоотой бас Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөрт орсон Таванбогдын тусгай хамгаалалтаас аялал жуулчлалын отоглох газар, ариун цэврийн байгууламжийн асуудал жил болгон яригддаг Засгийн газрын мөрийн хөтөлбөрт орсон. Гэтэл энэ асуудал биелэгдэхгүй байгаа. Жил болгонд сайдын багш дээр тодорхой хэмжээний юм тавигддаг. Гэтэл биелэлт нь муу байгаа ийм асуудлууд байгаа. Тийм учраас энд анхаарч ажиллах шаардлагатай байна гээд хэлье.

Саяын юутай холбоотой Энхбаяр сайдад хариулт өгчих үү яах вэ? Тэр нөгөө Туулын хурдны замын 23 оны 6 сарын хэдэнд билүү 39 дүгээр тогтоол гээд Засгийн газар Их Хурал ороод батлуул, тийм үү? Тэр талын мэдээллийг. 3 номер хариульа Батбаяр Төрийн нарийн дарга. 3 номер.

Ш.Батбаяр: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам Төрийн нарийн бичгийн дарга Батбаяр Бейсен гишүүний асуултад хариульа.

Туулын хурдны замын гүйцэтгэлтэй холбоотой байгаль орчны ерөнхий болон нарийвчилсан үнэлгээг Байгаль орчин, уур амьсгалын хөгжлийн яамнаас

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

баталж гаргасан байгаа. Үүн дээр экологи, эдийн засгийн хохирол 72 тэрбум төгрөгийг нийт байгаль орчны хохирол дээр гаргасан байгаа.

Сүүлд ажлыг түр зогсоодог дээр гүйцэтгэгч компани маань Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө 2026 оныхоо төлөвлөгөөг батлуулаагүй байсан. Иймд холбогдох хууль тогтоомжийн дагуу яамнаас энэхүү төлөвлөгөөгөө батлуултал ажлыг нь түр зогсоосон байгаа. Тэгэхээр гүйцэтгэгч компани маань Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө бидэнд ирүүлээд ажлаа албажуулаад явахаа хүлээн зөвшөөрсөн байгаа.

Б.Бейсен: Гишүүд асуулт асууж дууслаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад үг хэлэх гишүүд нэрс өгнө үү.

Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Ирцээр Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн үг хэлэх юм байна.

Б.Бат-Эрдэнэ: Би түрүүн асуулт асуусан тэгээд хариулт нь өнгөрсөн жилийнхтэй яг л адилхан хариулт л өгсөн. Энэ хоёрын хоорондох хугацаа өнгөрсөн та нарын ажлын үр дүн огт гараагүй. Хариуцлага тооцох механизм та нарт ерөөсөө байхгүй. Өөрөөр хэлбэл, та нар хариуцлага тооцдоггүй, тооцож чадахгүй байгаа. Яагаад гэвэл улс төрийн нөлөөлөл өндөртэй хүмүүсийн томилгооноос улбаатай. Энийгээ одоо үнэнээр нь хэлэх хэрэгтэй. Бие биеийгээ хуурч ингэж ажилладгаа болих хэрэгтэй ний нуугүй хэлэхэд.

Өнгөрсөн жил орж ирээд л бас Занданшатар даргын Ерөнхий сайдын Засгийн газарт бид нар ингэж ажиллаж байгаа ийм шийдвэрүүд гарч байгаа гээд л зарлаад л байсан. Сая танай дарга Учрал Ерөнхий сайд ингээд зарласан учраас бид нар энийг хийнэ ээ гэгчихсэн зарлачихсан гүйж явна лээ. Тэгээд танай байгууллага төрийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлдэг байгууллага гэж би ойлгодог. Хэн нэг Ерөнхий сайдын хэлсэн үг болгоныг дамжуулагчийн үүрэг гүйцэтгэдэг гэж ойлгодоггүй. Би өнгөрсөн жил танай байгууллага дээр шүүмжлэлтэй хандаж байсан. Энэ жил ахиад баталгаажих маш харамсалтай.

Анх Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх танай энэ байгууллагыг байгуулахдаа их өөрөөр ярьж байсан. Өөрөөр ярьж байж Мэргэжлийн хяналтын байгууллагыг татан буулгаж, танайхыг бий болгож байсан. Тэгээд маш харамсалтай байна. Яагаад өнөөдөр Монголд хариуцлагагүйн зуд нүүрлэсэн бэ гэхээр та нарын байж байгаа байдал өнөөдөр ийм нөхцөл байдалтай байгаатай л холбоотой. Та нар төрөөс өгсөн чиг үүргийг хэрэгжүүлж чадахгүй байгаатай холбоотой. Тийм учраас би та нараас яагаад хэрэгжүүлж чадахгүй байгаа вэ гэдэг л уул нь асуулт асуусан юм. Одоо тэгээд сайжраад явах ёстой гэж ойлгож байгаа.

ТӨК-уд дээр маш олон асуудлууд байна. Энэ ерөөсөө шийдвэрлэгдэхгүй байгаа. Хуульдаа сонгон шалгаруулалт гээд орчихсон мөртөө нэг ч сонгон шалгаруулалтгүй явж байгаа, өнөөдөр томилгоонууд хийгдэж байгаа ТӨК-уд байсаар л байгаа. Тэнд алдагдалтай ажиллаад тэр алдагдлыг хариуцаад шүүхийн шийдвэр гараад, эсвэл төрийн захиргааны байгууллага нь шийдвэр гаргаад нөхөж төлсөн нэг ч албан тушаалтны тухай бид нар сонсоогүй.

Тийм учраас тэнд эрх мэдэл, албан тушаалын гэмт хэргүүд үйлдэгдсээр л байгаа. Өнөөдөр төрийн бичиг баримт, архивтай холбоотой асуудлууд Энхбаяр

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

сайд бас мэдэгдэж байсан Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороон дээр бичиг баримт алга болсон байсан гээд. Тэгээд би гайхаж байсан. Чекэлсэн, араас нь би бичиг явуулсан. Би өөрөө олж чадаагүй. Тийм, бас бус материалууд олж чадаагүй жишээлбэл. Тэр Засгийн газрын хэрэг эрхлэх дээр ч байсан энэ материал байхгүй байна гээд.

Тэгэхээр цаашдаа энэ хариуцлагагүйн зудаас яаж гарах ёстой вэ? Уул нь танай агентлаг энд орж ирж байгаа асуудлуудыг өнгөрсөн жилээс авхуулаад шахаад, биелэлтийг нь шахаад, хэрэгжилтийг нь шахаад, холбогдох албан тушаалтнууд нь дор дор нь хариуцлагын арга хэмжээг нь аваад зөвлөмж явуулсан гэдгээр хязгаарлагдахгүйгээр л уул нь ажиллаад явбал зөв юм шиг байгаа. Эрх, үүргийн хувьд, чадамжийн хувьд үнэхээр болохгүй байгаа бол тэрийгээ хэлэх хэрэгтэй. Бид нар үнэхээр эрх мэдэл маань хуулиар олгогдсон хэмжээнд болохгүй байна. Энийгээ өөрчилмөөр байна. Үндэсний аудитын газрынхан хэлсэн шүү дээ тэрэнтэй яг адилхан байхгүй юу. Тэгээд энийг л шийдэхгүй бол бид нар энд ярьдаг, та нар хариулдаг нэртэй ингээд л бүх цаг хугацаа өнгөрч байна. Би дахиад хэлье та нар ерөөсөө хариуцлага тооцож чадахгүй байгаа, танай механизм өөрөө ажиллахгүй байгаа. Танай механизм ажилладаг болох цагаас хариуцлага тооцдог механизм хэрэгжиж эхэлнэ. Харамсалтай байна.

Б.Бейсен: Гомбын Ганбаатар гишүүн үг хэлье.

Г.Ганбаатар: 6 номер нэр хэн билээ Бат-Эрдэнэ Бат-Эрдэнэ үү? Ер нь Улсын Их Хурал гэдэг байгууллага төлөөлөх, оролцох, хууль батлах, хяналт тавих 4 үндсэн л үүрэгтэй. Ялангуяа тэр сүүлийнх нь хяналт тавих хэсэг бол таны ажилтай их холбоотой. Тэгээд бид нар яагаад сая Бат-Эрдэнэ гишүүн ч ярьж л байна. Бид нар яагаад ингээд яриад байна вэ гэхлээр бид нар ерөөсөө хаа хаа газраа энэ хяналтаа тавих, хариуцлага тооцох механизм байхгүй учраас өнөөдөр ийм болчхоод байгаа юм. Би дараа таныг орж ирэхэд яг асууна шүү. Та миний асуултад хариулахдаа цаашид үнэлгээний арга, аргачлалаа боловсронгуй болгоно бид, хүний нөөцөө тогтвортой байдлаа хангаж, хүмүүсээ чадавхжуулна, тэр Канадын төсөлд явж байгаа юм шиг байна. Тэр Засгийн газрын түвшинд ер нь энэ Их Хурал бол Засгийн газрын түвшинд гарч байгаа тэр 10 мянга гаран шийдвэрийг цахим хяналтад авна. Өмнө нь гарч байсан шийдвэрүүд хэрэгжилт нь агуулгаараа ямар байсан юм. Үнэлж, дүгнэж, бид нар бас үнэлж, дүгнэхгүйгээр яваад байсан байна аа Улсын Их Хурал болон Байнгын хороо Засгийн газрын хоорондын уялдааг хангана. Та 5 зүйлийг өнөөдрийн Байнгын хорооны хурал дээр тодорхой хэллээ шүү. Би дараа танаас яг энэний чинь хүрээнд асууна. Одоо бол яах вэ өмнө нь ингэж явж ирсэн юм байлгүй.

Ер нь нээрээ манай улсад энэ хариуцлага, хяналт гэдэг юм дэндүү сул байна. Дээрээс нь энэ энэ засаг төрийн тогтворгүй байдал ч нөлөөлж байгаа биз. тэгээд та бүхэнд янз бүрийн улс төр есөн жорын дарамт очдог биз. Гэхдээ ингэж болохгүй л дээ энэ чинь. Энд уг нь улс орны Улсын Их Хурал гэдэг чинь улс орны ирээдүйг л зурдаг байгууллага. Бодлогын гол гол шийдвэрүүд гардаг. Гэтэл хэрэгжиж байгаа байдал нь иймэрхүү байна гэдэг үнэхээрийн харамсалтай байна шүү. Дараа би танаас яг энэ 5 зүйлээр чинь асуух болно гэдгийг хэлье.

Б.Бейсен: Ганхүлэг гишүүн үг хэлье.

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

М.Ганхүлэг: Асуулт, хариултууд ер нь жоохон хангалтгүй бас байна. Жилийн жилд хэдүүлээ бас ингээд уулзахаар тодорхой бас хариулдаг нөхцөл байдал бас үргэлжлээд яваад байгаа дээр анхаарна биз дээ. Манай Байнгын хорооны асуудлын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуйн салбарын 10 хуулийн 12 заалтын хэрэгжилтийг тайлагнаагүй байгаа. Энэ дээрээ онцгой анхаарал хандуулаарай. Энэ дотор нөгөө хүнсний нөөц бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдалтай холбогдолтой асуудал зүгээр журам батлаагүй, журам батлах удирдлага, хүний нөөцийн асуудал дутмаг байсан энэ тэр гээд иймэрхүү тайлбарууд бас байх шиг байна.

Тэгэхээр ийм байдлаар ингээд тайлагнахгүй, хугацааг нь хойшлуулчихсан ийм нөхцөл байдлуудыг бид нар ингээд өөгшүүлээд яваад байж болохгүй ээ. Тэгээд энэ дээрээ яг онцгой анхаарлаа хандуулаад тайлагнах ёстой тайланг нь өгөөд ингээд явахгүй бол бас хэтэрхий найзан дундаа ороод ингээд бас нэг нэгнийхээ толгойг илээд явсаар байгаад хаа хаанаа ямар ч хариуцлагын ийм асуудалгүй ийм болж тогтлоо.

Байгаль орчны салбарын 17 тогтоолын 40 заалтын, 40 заалтын шүү 30 нь зохион байгуулалтаас, 8 нь тайлагнаагүйгээс, 2 нь санхүүжилтээс шалтгаалаад хэрэгжилт хангалтгүй гэж дүгнэсэн байгаа. Тэгээд энэ үндсэндээ шалтгаануудыг маш зөвөөр, тодорхой болгоод, тодорхой хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг нь авч хэрэгжүүлээд энэ дээр нь хариуцлага тооцох механизмуудаа илүү сайжруулаад ажиллах энгийн л ийм л бас агуулгууд бас байна. Тэгээд энэ дээрээ яг тодорхой эзэн болоод ажиллах нь зөв болов уу л гэж бодоод байна. Тэгээд гишүүдийн энэ саналуудыг бас нэлээн аваад тайлан юмнууд дээр анхаарна биз дээ.

Монгол Улсын хувьд хөгжиж байгаа орон. Өдөр бүрийг л бид нар цаг, минутыг л улс орныхоо хөгжлийн төлөө энэ төрийн албан хаагчид маань, бизнес эрхлэгч хувийн хэвшлийнхэн маань бүгдээрээ бас цаг заваа зориулаад л ингээд л ажиллах ёстой. Бүгд ажлын төлөө тодорхой үр дүн, бүтээмжийн төлөө ийм хандлагаар асуудалдаа хандах ёстой. Төрийн албан хаагчдаа дэмжих, тайлан янз бүрийн юмны дарамтаас ангижруулах энэ санаачилгуудыг бас дэмжиж байгаа гэдгээ бас хэлэх нь зөв. Илүү ухаалаг болгох, цахим болгох энэ чиглэлүүдийг цаашдаа хийх ёстой.

7 хоногийн 3 өдөр нь амардаг. 1 өдөр нь магадгүй тэр цахимаар хичээллэж байгаа гэдгээрээ тооцуулдаг, ажиллаж байгаа гэдгээрээ тооцуулдаг энэ байдлуудыг их сайн судлаарай. Бид ер нь байгаа цаг хугацаагаа илүү үр бүтээлтэй байлгахын төлөө, илүү чадамжтай байлгахын төлөө бас анхаарах ёстой болохоос биш, илүү бүтээмж баялаг бүтээхийн төлөө бас явах ёстой болохоос биш яг их айхтар ажлын цаг хугацаа маань бас илүүдээд ингээд байгаа зүйл бас байхгүй байх гэж ингэж бодож байна. Ямар судалгаа, тооцооллоор энэ асуудлуудыг ярьж байна вэ гэдэг дээр манай Хэрэг эрхлэхийнхэн маань бас тодорхой шинжлэх ухааны үндэслэлтэйгээр бас хандана биз дээ. Тэгээд хэчнээн төрийн албан хаагч нар маань үнэхээр ажлын ачаалал өндөр байна. 1 өдөр нь цахим болгож бас арай ачааллаа бууруулмаар байна энэ тэр гэдэг санал гаргасан юм, ямар улсын, ямар туршлага, ямар үндэслэлээр бас ингэх нь илүү бүтээмж нэмэгдүүлнэ гэж үзээд байгаа юм энэ тэр гэдэг дээрээ нухацтай хандана биз ээ.

Тэгээд зарим саналуудыг дэмжиж байгаа, зарим саналууд дээр бас анхаарал хандуулахаар ийм зүйлүүд бас байна гэдгийг би бас хэлчих нь зөв болов

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

уу гэж бодож байна. Хэрэг эрхлэхийн дарга маань бас энэ дээр тодорхой бас хариултууд бас бүрэн дүүрэн бас өгч чадахгүй байгаад байна. Энийг бас анхаараарай.

Б.Бейсен: Гишүүдийн хэлсэн саналыг бас дэмжиж байна. Тэгэхдээ манай Байнгын хороотой холбоотой энэ тогтоол, шийдвэрийн биелэлт дээр анхаарах Хүнс хөдөө аж ахуйн яам, Байгаль орчны яам, Спорт, аялал жуулчлалын яам, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам анхаарах шаардлагатай байгаа хуулийн хэрэгжилт гарсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилт дээр нэлээн анхаарч ажиллах шаардлагатай байна.

Ялангуяа Байгаль орчин энэ аюултай хог хаягдлын асуудал байж байгаа. Эрдэс баялгийн яамтай хамтарч байгаад хаягдал тос пелонк тавьж байгаад газрын хэвлий бохирдуулаад булж байгаа асуудал байж байна. Бусад аюултай хог хаягдлын асуудлын хэрэгжилт дээр нэлээн анхаарал тавьж ажиллах нь зөв байх гэж бодож байна.

Хүнс, хөдөө аж ахуйн яамны хувьд сая ярилаа. Хүнсний аюулгүй байдалтай холбоотой бас хяналттай, төв лабораторитой хамтраад ер нь сайжруулахгүй бол бас энэ хавдрын ихсэлтийн асуудал байж байна. Ер нь баталгаат лабораториуд дээр түшиглээд энэ хуулийн хэрэгжилтээ бас хэрэгжүүлэх асуудал дээр нэлээн анхаарах шаардлагатай байна.

Аялал жуулчлал дээр ч отоглох газар ариун цэврийн байгууламж гээд сая бид манай Байнгын хорооныхон Байгаль орчны яамнаас ч улсууд явсан өмнөд Африк дээр туршилт суулдаад ирсэн. Энэ аялал жуулчлалынхан зөвхөн төрөөс санхүүждэг биш хувийн хэвшилтэй бас хамтардаг юм байна. Аялал жуулчлалаа бас хамт тэр отоглох газар ариун цэврийн байгууламжаа бүрэн байгуулсан асуудал байдаг юм байна. Олсон орлогынхоо 60 хувийг нь төрд өгөөд 40 хувийг нь өөрсдөө ашигладаг тийм туршлагатай юм байна. Ер нь энийг бас судлах шаардлагатай байгаа. Тийм учраас энэ манай Байнгын хорооноос гарсан тогтоол, шийдвэрийг бас хэрэгжүүлэх дээр бас онцгой анхаарч ажиллаарай гэдгийг хэлье ээ.

Гишүүд үг хэлж, асуулт асууж дууслаа.

Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Байнгын хорооны гишүүд, ажлын хэсгийнхэнд баярлалаа.

14.10 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ